СЗХ
он 2022 сар 11 0 8 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

# ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН
# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ
## ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ | "БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК |
| ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ | "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК |
| ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ | ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС |
| ҮНЭТ ЦААСНЫ НЭГЖИЙН НЭРЛЭСЭН ҮНЭ | 100,000 ТӨГРӨГ |
| ҮНЭТ ЦААСНЫ НИЙТ ТОО ШИРХЭГ | 100,000 ШИРХЭГ ХҮРТЭЛ |
| ҮНЭТ ЦААСНЫ НИЙТ ДҮН | 10,000,000,000.0 ТӨГРӨГ ХҮРТЭЛ |
| ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ | 17.5% |
| ҮНЭТ ЦААСНЫ ХУГАЦАА | 24 САР |

**АНДЕРРАЙТЕР**
TDB SECURITIES

**ХӨНДЛӨНГИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ**
DB&GTS

**ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ**
Onch & Company

СЭХ
он сар өдөр
2022 11 09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-11-15
БҮРТГЭВ-03

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК /цаашид "Үнэт цаас гаргагч" эсхүл "ТЗК" гэх/ нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид "Хороо" гэх/, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК /цаашид "Бирж" гэх/-ийн холбогдох журмуудын дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 100,000 ширхэг хүртэлх буюу нийт 10,000,000,000.0 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК /цаашид "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч" эсхүл "Үүсгэн байгуулагч" гэх/-аас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багц болгон шилжүүлэн худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж, зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлэхэд бүрэн зарцуулна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийх ажиллагааг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй болно. Мөн Хороо үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв үнэт цаасанд эрсдэл үүсвэл Хороо хариуцахгүй болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөлөл, тооцоолол, мэдээлэл, мэдэгдэл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй мөн тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг баталж байна.

**Энэхүү танилцуулгад тусгасан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж бүртгэсэн нь уг баталгаат үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг Хороо болон Бирж хариуцахгүй! Баталгаат үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, баталгаат үнэт цаасны танилцуулга, баталгаат үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.**

Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад шаардлагатай бүхий л мэдээллийг энэхүү Үнэт цаасны танилцуулгад агуулахыг зорьсон бөгөөд тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл гарсан тохиолдолд Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК болон Андеррайтер "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай танилцуулгад тусгагдсан хаягаар хандана уу.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
20__ он __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

### Үүсгэн байгуулагч / Анхны үүрэг гүйцэтгүүлэгч / Үйлчилгээ үзүүлэгч

**"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК**

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж, 101-р барилга, 705 тоот |
| Утас: | (976) 9911 6366 |
| Э-шуудан: | info@bichilglobus.mn |
| Вэб хуудас: | www.bichilglobus.mn |

### Андеррайтер

**"ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК" ХХК**

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа хөгжлийн банкны байр, 1401 тоот, |
| Утас: | (976) 11 311914, (976) 7010 0261 |
| Э-шуудан: | info@tdbsecurities.mn |
| Вэб хуудас: | www.tdbsecurities.mn |

### Хуулийн зөвлөх

**ӨМГӨӨЛЛИЙН "ДИ БИ ЭНД ЖИ ТИ ЭС" ХХН**

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 7-р давхар |
| Утас: | (976) 9911 0961; (976) 9907 5047 |
| Э-шуудан: | info@dblaw.mn |
| Вэб хуудас: | www.dblaw.mn |

### Зээлийн шинжилгээ гаргагч

**"ОНЧ АУДИТ" ХХК**

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ай Си Си цамхаг, 15 давхар |
| Утас: | (976) 7010 0450 |
| Э-шуудан: | info@onch.mn |
| Вэб хуудас: | www.onch.mn |

### Хөрөнгө итгэмжлэн удирдагч

**"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК**

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот |
| Утас: | (976) 7012 2346, (976) 7014 2346 |
| Э-шуудан: | info@uaf.mn |
| Вэб хуудас: | www.uaf.mn |

## АГУУЛГА


1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 9
1.1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА ... 10
1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ ... 11
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ... 13
2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ ... 14
2.1.1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл ... 14
2.1.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө ... 14
2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ ... 15
2.2.1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц ... 15
2.2.2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн тухай ... 15
2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ... 16
2.3.1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт ... 16
2.3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ... 16
2.3.3. Төлөөлөн удирдах зөвлөл ... 17
2.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 20
2.4.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал ... 20
2.4.2. Хөрөнгийн багц ... 21
2.4.2.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур үзүүлэлтүүд ... 21
2.4.2.2. Хөрөнгийн багцын тойм ... 24
2.4.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллгааны ерөнхий зураглал ... 27
2.4.4. Төлбөр цуглуулах үйл ажиллагаа ... 29
2.4.4.1. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам ... 29
2.4.4.2. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ ... 31
2.4.4.3. Үйлчилгээ үзүүлэгч ... 32
2.4.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа ... 32
2.4.5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам ... 32
2.4.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ ... 34
2.4.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч ... 35
2.4.6. Үнэт цаас гаргагчийн бусад үйл ажиллагаа ... 36
2.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 38
2.5.1. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл ... 38
2.5.1.1. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл ... 38
2.5.1.2. Орлого, зардлын төсөөлөл ... 39
2.5.1.3. Мөнгөн гүйлгээний төсөөлөл ... 40
2.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ ... 40
2.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ТАТАН БУУГДАХ ... 41
3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ / ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ ... 42
3.1. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА ... 43
3.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал ... 44
3.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчид, түүний бүтэц ... 45




СЗХ он сар өдөр 2022 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-11-15 БҮРТГЭВ
TDB SECURITIES

3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн төлөөлөн удирдах зөвлөл ....46
3.1.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн удирдлагын баг ....48
3.2. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ....50
3.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд ....50
3.3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ....52

**4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ....53**
4.1. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР ....54
4.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮГИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ ....54
4.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ....54
4.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ ....55
4.5. ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛ ....55

**5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН ....59**
5.1. МАКРО ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА ....60
5.2. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР ....62
5.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ....66
5.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ....66

**6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ ....68**
6.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР ....69
6.2. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ....69
6.3. ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ....69
6.4. ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ....70
6.5. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ ....70
6.6. ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТ ....70
6.7. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ, ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР ....71
6.8. АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ....72

**7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ ....73**
7.1. АНДЕРРАЙТЕР ....74
7.1.1. Андеррайтерийн танилцуулга ....74
7.1.2. Андеррайтерийн удирдлага зохион байгуулалт ....75
7.1.3. Андеррайтертай байгуулсан гэрээ ....76
7.2. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ ....77
7.2.1. Зээлийн шинжилгээ гаргагчийн танилцуулга ....77
7.2.2. Зээлийн шинжилгээ гаргагчийн удирдлага зохион байгуулалт ....78
7.2.3. Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ ....79
7.3. ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ....80
7.3.1. Хуулийн зөвлөхийн танилцуулга ....80
7.3.2. Хуулийн зөвлөхийн удирдлага зохион байгуулалт ....81
7.3.3. Хуулийн зөвлөхтэй байгуулсан гэрээ ....82

**ХАВСРАЛТ ....84**

СЗХ
он 2022 сар 11 өдөр 09
БҮРТГЭВ
№ 01

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **АНУ** | Америкийн нэгдсэн улс |
| **АҮГ** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч |
| **АХБ** | Азийн хөгжлийн банк |
| **ББСБ** | Банк бус санхүүгийн байгууллага |
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **ЗГХЭГ** | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| **ЗЗҮ** | Зах зээлийн үнэлгээ |
| **ЗҮХ** | Зээл үнэлгээний харьцаа |
| **ИЗОУИС** | Их засаг олон улсын их сургууль |
| **МИК** | Монголын ипотекийн корпораци |
| **МУ** | Монгол Улс |
| **МУИС-ОАСС** | Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль |
| **МУИС-ХЗС** | Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль |
| **МУИС-ЭЗС** | Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль |
| **МХБ** | Монголын хөрөнгийн бирж |
| **НҮТББ** | Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага |
| **ОУВС** | Олон улсын валютын сан |
| **СЗХ** | Санхүүгийн зохицуулах хороо |
| **СУИС** | Соёл Урлагын Их Сургууль |
| **СЭЗИС** | Санхүү эдийн засгийн их сургууль |
| **ТЗ** | Тусгай зөвшөөрөл |
| **ТЗК** | Тусгай зориулалтын компани |
| **ТӨХК** | Төрийн өмчит хувьцаат компани |
| **ТУЗ** | Төлөөлөн удирдах зөвлөл |
| **УИХ** | Улсын их хурал |
| **ҮЦК** | Үнэт цаасны компани |
| **ХААИС** | Хөдөө Аж Ахуйн Их Сургууль |
| **ХБҮЦ** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |
| **ХЗХ** | Хадгаламж зээлийн хоршоо |
| **ХИУ** | Хөрөнгө итгэмжлэн удирдагч |
| **ХНХ** | Хувь нийлүүлсэн хөрөнгө |
| **ХТӨА** | Хүү, татварын өмнөх ашиг |
| **ХХК** | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| **ХХН** | Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл |
| **ШУТИС** | Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль |
| **ROA** | Return on asset буюу нийт хөрөнгийн өгөөж |
| **ROE** | Return on equity буюу нийт эздийн өмчийн өгөөж |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
он 2022 сар 11 өдөр 01
БҮРТГЭВ
№ 01

2022-11-15
БҮРТГЭВ-03

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1: Үнэт цаасны ерөнхий нөхцөл ........ 10
Хүснэгт 2: Үнэт цаасны давуу тал ........ 11
Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл ........ 14
Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл ........ 14
Хүснэгт 5: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл, хуулийн этгээдийн бүртгэл ........ 15
Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл ........ 16
Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга ........ 19
Хүснэгт 8: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур үзүүлэлтүүд ........ 21
Хүснэгт 9: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд ........ 22
Хүснэгт 10: Хөрөнгийн багцын тойм мэдээлэл ........ 24
Хүснэгт 11: Хөрөнгийн багц дахь өндөр дүнтэй зээлийн хөрөнгийн үлдэгдлийн мэдээлэл ........ 25
Хүснэгт 12: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огноо ........ 25
Хүснэгт 13: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон хугацааны тархалт ........ 26
Хүснэгт 14: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл хугацааны тархалт ........ 26
Хүснэгт 15: Хөрөнгийн багцын эргэн төлөгдөх хуваарь ........ 26
Хүснэгт 16: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшний тархалт ........ 27
Хүснэгт 17: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалтын харьцаа ........ 27
Хүснэгт 18: Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулах боломжтой санхүүгийн хэрэгслүүд ........ 34
Хүснэгт 19: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл ........ 36
Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн эхлэлийн тайлан, тэнцэл ........ 38
Хүснэгт 21: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл ........ 38
Хүснэгт 22: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл ........ 39
Хүснэгт 23: Үнэт цаас гаргагчийн зардлын төсөөлөл ........ 39
Хүснэгт 24: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний төсөөлөл ........ 40
Хүснэгт 25: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд ........ 43
Хүснэгт 26: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн танилцуулга ........ 46
Хүснэгт 27: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга ........ 47
Хүснэгт 28: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн удирдлагын багийн танилцуулга ........ 48
Хүснэгт 29: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлангийн гол лох үзүүлэлтүүд, тэрбум төгрөг ........ 50
Хүснэгт 30: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд ........ 51
Хүснэгт 31: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн удирдлага ........ 52
Хүснэгт 32 : Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага эрсдэл ........ 56
Хүснэгт 33: Монгол Улсын макро эдийн засгийн гол лох үзүүлэлтүүд ........ 60
Хүснэгт 34: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал ........ 61
Хүснэгт 35: Монгол Улсын инфляцын таамаглал ........ 61
Хүснэгт 36: Банк бус санхүүгийн салбарын санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг ........ 64
Хүснэгт 37: Банкны салбар болон Банк бус санхүүгийн салбарын харьцуулалт ........ 65
Хүснэгт 38: Банкны салбар болон Банк бус санхүүгийн салбарын харьцаа үзүүлэлт ........ 65
Хүснэгт 39: Андеррайтерийн байгууллагын удирдлагын багийн мэдээлэл ........ 75
Хүснэгт 40: Зээлийн шинжилгээ гаргагчийн удирдлагын багийн мэдээлэл ........ 78
Хүснэгт 41: Хуулийн фирмийн удирдлагын багийн мэдээлэл ........ 81


ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Компанийн хувьцаа эзэмшигчийн бүтэц ........ 15
Зураг 2: Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал ........ 20
Зураг 3: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдлийн тархалт ........ 25
Зураг 4: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огнооны тархалт ........ 25
Зураг 5: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий зураглал ........ 28
Зураг 6: Анхны үүрэг гүйцэтгэгчийн товч танилцуулга ........ 44
Зураг 7: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт ........ 45
Зураг 8: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн нэгдлийн бүтэц ........ 45
Зураг 9: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц ........ 52
Зураг 10: Зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2022 оны 8-р сар ........ 54
Зураг 11: Санхүүгийн салбарын оролцогчдын нийт хөрөнгө ........ 62
Зураг 12: Нийт хөрөнгийн жилийн дундаж өсөлт, 2016-2021 он ........ 62
Зураг 13: Санхүүгийн салбарын оролцогчдын цэвэр ашиг ........ 63
Зураг 14: Банк бус санхүүгийн байгууллагын салбарын онцлох үзүүлэлтүүд, 2022 оны 2-р улирал ........ 63
Зураг 15: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг ........ 66
Зураг 16: Хөрөнгийн зах зээлийн нийт арилжааны дүн, хөрвөх чадварын түвшин, тэрбум төгрөг ........ 66
Зураг 17: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь ........ 69
Зураг 18: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар ........ 71

## 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

# НЭГ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
2022 .11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№1.01

## ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд дараах нөхцөлийн дагуу санал болгож байна.

**Хүснэгт 1: Үнэт цаасны ерөнхий нөхцөл**

| **Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны ерөнхий нөхцөл** | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | ▪ "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | ▪ "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК |
| **Үнэт цаасны бүртгэл** | ▪ "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |
| **Үнэт цаасны төрөл** | ▪ Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| **Үнэт цаас гаргах валют** | ▪ Төгрөг |
| **Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ** | ▪ 100,000 төгрөг |
| **Үнэт цаасны тоо ширхэг** | ▪ 100,000 ширхэг хүртэл |
| **Үнэт цаасны нийт үнийн дүн** | ▪ 10,000,000,000 төгрөг хүртэл |
| **Үнэт цаасны хугацаа** | ▪ 24 сар |
| **Үнэт цаасны хүү** | ▪ 17.5% /жилийн/ |
| **Үнэт цаасны хүү төлөгдөх хэлбэр** | ▪ Улирал тутам |
| **Үнэт цаасны хүү тооцох суурь хоног** | ▪ 365 |
| **Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хэлбэр** | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш хагас жил тутам буюу<br>▪ 6 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 12 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 18 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 24 дэх сард үндсэн төлбөрийн 25%. |
| **Үнэт цаасны төлбөр төлөх эх үүсвэр** | ▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт болох үндсэн болон хүүгийн төлбөр |
| **Үнэт цаасны барьцаа** | ▪ Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө бүхий Хөрөнгийн багц, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд |
| **Үнэт цаасны хүүд ногдох орлогын албан татвар** | ▪ 5%*<br><br>**Монгол Улсад байрладаггүй гадаадын аж ахуйн нэгжийн хувьд 20% (Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ)* |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт** | ▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-аас Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан худалдан авах |
| **Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо** | ▪ "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК |
| **Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцын мэдээлэл** | |
| **Хөрөнгийн багцын үнийн дүн** | ▪ 11.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн тоо** | ▪ 761 зээл |
| **Хөрөнгийн багц дахь зээлдэгчдийн тоо** | ▪ 761 зээлдэгч |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур болон хөндлөнгийн байгууллагын дүгнэлт** | ▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлага болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо |

| | |
|---|---|
| | мөрддөг стандартаас дутуугүй шалгуур хангасан автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө байх бөгөөд ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан Санхүүгийн 24 болон Хуулийн 11 шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан сонгож авсан байна. (Бүлэг 4.6, 4.7) |
| **Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд оролцогч талууд** | |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч / Үйлчилгээ үзүүлэгч** | ▪ "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч** | ▪ "Юнайтед Айр Файнэнс" ХХК |
| **Аудитор** | ▪ "Ниямазон Аудит" ХХК |
| **Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлт цуглуулах данс байрших банк** | ▪ "Худалдаа, хөгжлийн банк" ХХК |
| **Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах данс байрших банк** | ▪ "Худалдаа, хөгжлийн банк" ХХК |
| **Бусад баримт бичгүүд** | |
| **Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой журмууд** | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;<br>▪ Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам;<br>▪ ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;<br>▪ Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам;<br>▪ Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;<br>▪ Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;<br>▪ Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам;<br>▪ Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;<br>▪ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам. |
| **Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогч талуудтай байгуулах гэрээнүүд** | ▪ Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ;<br>▪ Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ;<br>▪ Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээ;<br>▪ Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ. |
| **Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчидтой байгуулсан гэрээнүүд** | ▪ Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ;<br>▪ Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ. |
| **Бусад гэрээ** | ▪ Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Ажлын байр түрээслэх гэрээ. |

## 1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

**Хүснэгт 2: Үнэт цаасны давуу тал**

| Давуу тал | Хураангуй |
|---|---|

СЗХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ нь 2022 оны 8-р сарын байдлаарх банкны салбарын 2 жилийн хугацаатай шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад жилийн ойролцоогоор 5.7%-иар өндөр, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн түвшнээс 0.7-3.1%-иар өндөр байна.

**Тогтмол, өндөр хүүтэй хөрөнгө оруулалт**




**Бодит өгөөжийн түвшин өндөр**

Хөрөнгө оруулагч нь ХБҮЦ-ны **хүүгийн төлбөрийг улирал тутам** хүлээн авахаас гадна **үндсэн төлбөрийг хагас жил тутам** тэнцүү дүнтэйгээр хүлээн авч, дахин хөрөнгө оруулалт хийх замаар бодит өгөөжийн түвшингээ нэмэгдүүлэх боломжтой байна. Хаалттай бонд болон хадгаламжийн хүүгийн орлогоос 10%-ийг тооцож татварт суутгадаг бол нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар тооцож байгаа нь хөрөнгө оруулагчдад бий болгож буй бодит өгөөжийн түвшинг өндөр байлгахад нөлөөлж байна.

**Шалгуур үзүүлэлт хангасан Хөрөнгийн багц**

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг сонгохдоо Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шалгуур, шаардлагыг хангуулахаас гадна хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны эргэн төлөлтийг баталгаажуулах зорилгоор **Санхүүгийн 24 шалгуур** болон **Хуулийн 11 шалгуур** үзүүлэлтүүдийн дагуу сонгон авч, тухайн шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэхийг хөндлөнгийн хууль болон аудитын байгууллагаар түүвэрлүүлэн шалгуулж, хараат бус хөндлөнгийн дүгнэлт гаргуулан, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн чанарыг баталгаажуулсан.

**Эрсдэлийн түвшин багатай Хөрөнгийн багц**

**ХБҮЦ нь хэвийн төлөлттэй Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөөр баталгаажсан** бөгөөд энэ нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт нь хугацаа хэтрэхгүйгээр товлосон хугацаандаа орж ирэх, Үнэт цаасны хуваарьт төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх бололцоог бүрдүүлнэ. Хэрэв тухайн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн, Шалгуур үзүүлэлт хангахгүй болсон эсхүл ХБҮЦ-ны төлбөр төлөхөд хүндрэл учруулахаар нөхцөл байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах зохицуулалтууд холбогдох гэрээ хэлцлүүдэд тусгагдсан.

**Эргэн төлөлтийн найдвартай байдал**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу шилжүүлэх буюу худалдаж буй Хөрөнгийн багцын нийт үлдэгдэл 11.0 тэрбум төгрөг, жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 28 сар, жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувь мөн зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээний жигнэсэн дундаж харьцаа 56.2 хувь байгаа бөгөөд ТЗК-ийн мөнгөн урсгалын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт буюу **ТЗК-д орох мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны төлбөр болох хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг гүйцэтгэхэд хангалттай** түвшинд байна.

**Төлбөр төлөх ахлах дараалал**

Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасны дагуу ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөр буюу **ХБҮЦ-ны төлбөр нь ТЗК-ийн төлөх бусад төлбөрүүдээс хамгийн эхэнд буюу ТЭРГҮҮН ЭЭЛЖИД** төлөгдөхөөр зохицуулагдсан.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## 2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

ХОЁР

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

## 2.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ

### 2.1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ

Үнэт цаас гаргагч болох "Бичил Эй Би Эс Актив" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Компанийн тухай хуулийн 62 дугээр зүйлийн 62.1.16 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг болон Үүсгэн байгуулагчийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 5-р сарын 25-ны өдрийн "Шинээр охин компани үүсгэн байгуулах тухай" 22/04а/23 тоот тогтоолоор үүсгэн байгуулагджээ.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 8-р сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоор олгогдсон ТЗ 315/48 дугаартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Тусгай зориулалтын компани буюу "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК болж үйл ажиллагааны чиглэл болон компанийн нэршил өөрчлөгдсөн байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байна.

**Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл**

| Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл | |
|---|---|
| **Компанийн нэр** | ▪ "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо** | ▪ 2022.05.27 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | ▪ 9011840095 |
| **Регистрийн дугаар** | ▪ 6875351 |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл** | ▪ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан огноо** | ▪ 2022.08.10 |
| **Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар** | ▪ ТЗ 315/48 |
| **Биржид бүртгэлтэй эсэх** | ▪ Үгүй |

| Үнэт цаас гаргагчийн хаяг байршил | |
|---|---|
| **Хаяг** | ▪ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот |
| **Утас** | ▪ (976) 9911 9632 |
| **Вэб хуудас** | ▪ www.bichil.abs.mn |

### 2.1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХӨРӨНГӨ

**Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл**

| Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл | |
|---|---|
| **Зарласан хувьцааны тоо** | ▪ 1,000 ширхэг |
| **Гаргасан хувьцааны тоо** | ▪ 1,000 ширхэг |
| **Хувьцааны төрөл** | ▪ Энгийн эрхийн хувьцаа |
| **Нэрлэсэн үнэ** | ▪ 1,000.0 төгрөг |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ** | ▪ 1.0 сая төгрөг |
| **Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр** | ▪ "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК |
| **Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь** | ▪ 100 хувь буюу 1,000 ширхэг энгийн хувьцаа |

## 2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

### 2.2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ

Үүсгэн байгуулагч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 1,000 ширхэг энгийн эрхийн хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 100%-ийг дангаар эзэмших Үнэт цаас гаргагчийн цор ганц хувьцаа эзэмшигч байна.

**Зураг 1: Компанийн хувьцаа эзэмшигчийн бүтэц**




Зээл, факторингийн үйл ажиллагаа болон итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага.

Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд үүсгэн байгуулагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компани.

### 2.2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь 2008 онд үүсгэн байгуулагдсан ба 2013 онд Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. Тус компани 2022 оны эхний хагас жилийн байдлаар зээл, факторинг, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа ба төв оффис болон 16 салбар, 63 ажилтан, 5.5 мянган зээлдэгч, 6.5 мянган харилцагчтай томоохон санхүүгийн компани болон өргөжин тэлжээ.

**Хүснэгт 5: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл, хуулийн этгээдийн бүртгэл**

| | |
|---|---|
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хуулийн этгээдийн бүртгэл** | |
| **Компанийн нэр** | ▪ "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | ▪ 2008 он |
| **Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо** | ▪ 2013.07.17 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | ▪ 9015002106 |
| **Регистрийн дугаар** | ▪ 5729718 |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл** | ▪ Зээлийн үйл ажиллагаа<br>▪ Факторингийн үйл ажиллагаа<br>▪ Итгэлцлийн үйлчилгээ |
| **Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар** | ▪ ТЗ-101/307 |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хаяг байршил** | |
| **Хаяг** | ▪ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот |
| **Утас** | ▪ (976) 9911 6366 |
| **Э-шуудан** | ▪ info@bichilglobus.mn |
| **Вэб хуудас** | ▪ www.bichilglobus.mn |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хөрөнгийн мэдээлэл, 2022.II улирал** | |
| **Зарласан хувьцааны тоо** | ▪ 100 |
| **Гаргасан хувьцааны тоо** | ▪ 100 |
| **Хувьцааны төрөл** | ▪ Энгийн эрхийн хувьцаа |
| **Нэрлэсэн үнэ** | ▪ 50.0 сая төгрөг |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ** | ▪ 5.0 тэрбум төгрөг |

| | |
|---|---|
| **Өөрийн хөрөнгийн хэмжээ** | ▪ 21.9 тэрбум төгрөг |
| **Нийт хөрөнгийн хэмжээ** | ▪ 66.6 тэрбум төгрөг |

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хувь нийлүүлсэн хөрөнгөө мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн ба үүсгэн байгуулагдсанаас хойш хувь нийлүүлсэн хөрөнгөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

**Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл**

| № | Хорооны зөвшөөрөл олгосон огноо | Хорооны зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | ХНХ-ийн хэмжээ /сая төгрөг/ |
|---|---|---|---|
| 1 | 2013.10.23 | №379 | 400.0 |
| 2 | 2015.11.06 | №305 | 602.8 |
| 3 | 2017.02.21 | №133 | 882.4 |
| 4 | 2017.07.17 | №352 | 1,243.7 |
| 5 | 2018.06.04 | №390 | 5,000.0 |

## 2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### 2.3.1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компани тул бүтэц, зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эдлэх эрх, үүрэг нь Компанийн тухай хуулиас гадна Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам" бусад холбогдох хууль, тогтоомжоор нарийвчлан зохицуулагдана.

### 2.3.2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Холбогдох хууль, тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба 4.1.9 дэх заалтад дараах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэхээр заажээ. Үүнд:

- Хорооны зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Үнэт цаас гаргагчийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах ба энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Дүрэмд нэмэлт өөрчлөлтийг хөрөнгө оруулагчдад ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх;
- Үнэт цаас гаргагчийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Үнэт цаас гаргагчийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- Хууль тогтоомжинд заасан бусад асуудал.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 3.3 хэсэгт хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан холбогдох журам болон Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасантай зөрчилдөхгүй эрх эдэлж, үүрэг хүлээхээр заасан байна. Үүний

СЗХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ

хүрээнд, хувьцаа эзэмшигч нь дор дурдсан болон бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй;
- Үнэт цаас гаргагчийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Үнэт цаас гаргагчийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор аливаа хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Үнэт цаас гаргагчид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх эрхгүй;
- Хууль болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 8.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийг татан буулгахаар хүсэлт гаргах эрхгүй байна.

### 2.3.3. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.2.1 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүний хүрээнд, Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Компанийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч болон хөндлөнгийн аудиторыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох журмын дагуу сонгох;
- ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагыг сонгохгүй бөгөөд Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэнд Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, болон хөндлөнгийн аудитортой байгуулсан гэрээнд заасан эрх үүргийн дагуу тэдгээрт хяналт тавих, шаардлагатай тохиолдолд солих;
- Энэхүү Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- ТУЗ нь Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20-р зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулж, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлснээс хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хангуулах мөн хэрэгжүүлэх;
- ТУЗ-ийн шийдвэр, холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлээс нэмж, хасах, солих;
- Хөрөнгө оруулагчдад мэдээллийг тогтмол, цаг тухайд нь хүргэх;
- Хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, Компанийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг эрх хүлээн авагчийн эзэмшилд шилжүүлэх бөгөөд эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь эрх хүлээн авагчтай бүх талаар хамтран ажиллах;

СЗХ
2022 .11. 08
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Компанийн дүрэм, баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, баталгаат үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангах;
- Компанийн дүрэм, үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас гаргах өргөдлийг мөрдлөг болгон ТЗК байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хороо болон Биржээс баталсан журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- Хуульд заасан бусад.

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн ТЗК татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9-р сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот "Журам батлах тухай" тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба тус журмаар ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрх, зохион байгуулалттай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Тус журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр компани татан буугдах хүртэл хугацаатай томилох ба ТУЗ нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхаар тусгасан байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д заасан шаардлага болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нэмэлт шаардлагыг хангасан байхаар заажээ.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхаар заасан ба Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 1 ердийн гишүүн, 2 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Мөн, Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 7 сарын 05-ны өдрийн 22/23а/04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг, тус өдрийн 22/23а/05 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргыг тус тус томилсон байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

**Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|



**Ц. Азбаяр**
**ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн**

**Боловсрол**
- Хэнтий аймаг ӨЗБДС, Бүрэн дунд боловсрол;
- ИЗОУИС, Эрх зүйн бакалавр;
- ИЗОУИС, Хууль зүйн магистр
- СЭЗИС, Бизнесийн удирдлагын бакалавр;
- СЭЗИС, Бизнесийн удирдлагын доктурант.

**Ажлын туршлага**
- 2005-2011 - ИЗОУИС, Багш, Маркетингийн албаны дарга;
- 2011-2012 - УИХ-ын Тамгын Газар, УИХ-ын гишүүний зөвлөх;
- 2012-2014 - ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын ажлын албанд ахлах;
- 2014-2021 - "Хан Голомт" төв НҮТББ, Захирал;
- 2022-Одоо - Өмгөөллийн "Бизнес Ло" ХХН, Захирал.



**Б. Баасандорж**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**
- "Боловсрол цогцолбор", Бүрэн дунд боловсрол;
- МУИС-ХЗС, Эрх зүйн бакалавр;
- Төв Хятадын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Эрх зүйн магистр;
- СЭЗИС, Бизнесийн удирдлагын бакалавр.

**Ажлын туршлага**
- 2010-2011 - "Энержи Ресурс" ХХК, Хуулийн мэргэжилтэн;
- 2013-2022 – Өмгөөллийн "Батбаяр Энд Партнэрс" ХХН, Ахлах хуульч, Гишүүн өмгөөлөгч , Гүйцэтгэх захирал;
- 2016-Одоо – Өмгөөллийн "Баасандорж консалтинг" ХХК, Үүсгэн байгуулагч;
- 2019-Одоо – МУИС-ХЗС, Нийтийн эрх зүйн тэнхимийн Санхүү, татварын эрх зүйн багш.



**С.Отгонбат**
**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**
- 12-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;
- Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;
- МУИС, Олон улсын эдийн засгийн харилцааны магистр.

**Ажлын туршлага**
- 2006-2007 – "Оргил хотхон" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008-2009 – "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;
- 2013-Одоо – "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал.

Үнэт цаас гаргагч нь "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.12.5 дахь заалтын дагуу Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах хориотой тул Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг Үүсгэн байгуулагчтай байгуулсан "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ" болон Үнэт цаас гаргагчийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

## 2.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.4.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд үүсгэн байгуулагдсан "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК буюу Үнэт цаас гаргагчийн үнэт цаасжуулах хэлцлийн үйл ажиллагаа нь дараах ерөнхий зураглалын хүрээнд явагдана.

**Зураг 2: Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал**




**Тайлбар:**

1. Үнэт цаас гаргагчийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авахтай холбоотой түүнд тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс тогтоосон;
2. Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдалдан авч буй Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь талуудын тохиролцсон санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалгах зорилгоор хөндлөнгийн зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн зөвлөх компани нь тус тусын арга аргачлалаар зээлийн хөрөнгийг түүвэрлэн сонгон авах замаар бие даасан, хараат бус дүгнэлтийг гаргана;
3. Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн зөвлөхийн тайлан, шинжилгээнд үндэслэн шаардлага хангасан Хөрөнгийн багцыг "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн буюу худалдан авна;
4. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хүсэлтийг эрх бүхий зохицуулах байгууллагад хүргүүлнэ;
5. Эрх бүхий зохицуулах байгууллагаас зөвшөөрөл авсны хүрээнд хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг санал болгох замаар шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлнэ.
6. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн шилжүүлнэ.

СЭХ 2022 он 11 сар 09 өдөр БҮРТГЭВ № 01

### 2.4.2. ХӨРӨНГИЙН БАГЦ

#### 2.4.2.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд 2022 оны 9-р сарын 27-ны өдөр байгуулсан 22/499 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд Үнэт цаас гаргагч нь гэрээний хүрээнд тохиролцсон шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд буюу Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөхөөр заасан байна.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд тусгасан нөхцөл, Санхүүгийн 24 болон Хуулийн 11 шалгуур үзүүлэлтийг хангасан байх ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй талуудтай хамтран ажиллах үүрэг хүлээхээр тусгажээ.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Зээлийн шинжилгээ гаргагч байгууллага болох "Онч аудит" ХХК, Хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Хуулийн фирм болох Өмгөөллийн "Ди Би Энд Жи Ти Эс" ХХН шалгаж, бие даасан хараат бус дүгнэлт гаргасан байна.

**Хөндлөнгийн хууль зүйн шинжилгээний товч дүгнэлт**

Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахаар тохиролцсон Автомашины фидуци бүхий 761 зээлийн хөрөнгөөс 80 зээлийн хөрөнгийг түүвэрлэн авч, сонгогдсон зээлийн хөрөнгүүдийн хувьд хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалган баталгаажуулж 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/342 дугаар бүхий Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн.

**Хуулийн шалгуур үзүүлэлтүүд**

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь дараах 11 хуулийн шалгуур үзүүлэлт хангасан ба үүнээс 6 шалгуур нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд, 5 шалгуур нь түүний барьцаа хөрөнгийн хувьд тавигдсан шалгуур үзүүлэлтүүд байна.

**Хүснэгт 8: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур үзүүлэлтүүд**

| № | Хуулийн шалгуур үзүүлэлт |
|---|---|
| **I. Зээлийн хөрөнгийн хувьд** | |
| 1 | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаанд баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан байх |
| 2 | Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх |
| 3 | Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх |
| 4 | Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

| | |
|---|---|
| 5 | Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байх |
| 6 | Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байх |
| **II. Барьцаа хөрөнгийн хувьд** | |
| 1 | Үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан байх, уг барьцаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байх |
| 2 | Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх |
| 3 | Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх |
| 4 | Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх) |
| 5 | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүдийг ТЗК-д барьцаалах агуулга бүхий Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх |

## Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь дараах 24 санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан ба үүнээс 14 шалгуур нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд, 5 шалгуур нь түүний барьцаа хөрөнгийн хувьд, 4 шалгуур нь зээлдэгчийн хувьд, 3 шалгуур нь Хөрөнгийн багцын хувьд тавигдсан шалгуур үзүүлэлтүүд байна.

**Хүснэгт 9: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд**

| № | Санхүүгийн шалгуур үзүүлэлт |
|---|---|
| **I. Зээлийн хөрөнгийн хувьд** | |
| 1 | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаанд баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан байх |
| 2 | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөр, холбогдох хураамж, шимтгэл, төлбөрийг төлсөн байх |
| 3 | Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх |
| 4 | Зээлийн санхүүжилтийн дүн нь бүрэн олгогдсон байх |
| 5 | Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх |
| 6 | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх |
| 7 | Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байх |
| 8 | Зээлийн хүүгийн хэмжээ сарын 2.3%-иас багагүй, тогтмол төлөгдөх нөхцөлтэй байх |
| 9 | Тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн үлдэгдэл хугацаа 20 сараас доошгүй байх |
| 10 | Үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа өдрийн байдлаар зээлийн үлдсэн хугацаа нь зээлийн нийт хугацааны 60%-иас доошгүй байх |

| | | |
|---|---|---|
| | Тасалбар болгосон өдрөөрх жигнэсэн дундаж зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь 70%-иас хэтрэхгүй байх, тухайлсан зээлийн хувьд 75%-иас хэтрэхгүй байх<br>**Тухайлсан зээлийн ЗҮХ тоооцолол**:<br>$$\frac{\text{Анх олгосон эсвэл дахин санхүүжүүлсэн зээлийн хэмжээ}}{(\text{Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ} + \text{Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ})} \leq 75\%$$<br>**Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж ЗҮХ тоооцолол:**<br>$$\sum_{1}^{787} \text{Зээлийн багцын үлдэгдэлд тухайн зээлийн эзлэх хувь} * \text{Тухайн зээлийн ЗҮХ} \leq 70\%$$ |
| 11 | | |
| 12 | Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байх | |

**II. Зээлдэгчийн хувьд**

| | |
|---|---|
| 1 | Монгол Улсад оршин суудаг Монгол Улсын иргэн байх |
| 2 | Эрх зүйн чадамжтай, 18-аас дээш настай байх |
| 3 | Үндсэн зээлдэгч нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх. Үндсэн зээлдэгчийн орлого хүрэлцэхгүй тохиолдолд хамтран зээлдэгчийн орлогыг судлах |
| 4 | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа нь татварын өмнөх орлогын 55%-иас илүүгүй байх<br>**Тоооцолол:**<br>$$\frac{\text{Нийт зээлийн сарын төлбөр}}{\text{Өрхийн сарын орлого (Татварын өмнөх)}} \leq 55 \text{ хувь}$$ |

**III. Барьцаа хөрөнгийн хувьд**

| | |
|---|---|
| 1 | Үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан байх, уг барьцаа нь тэргүүн ээлжинд шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байх; |
| 2 | Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх; |
| 3 | Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх. |
| 4 | Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх, тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх |
| 5 | Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх |

**IV. Хөрөнгийн багцын хувьд**

| | |
|---|---|
| 1 | Тасалбар болгосон өдрөөрх олгосон зээлийн жигнэсэн дундаж хэмжээ 20 сая төгрөгөөс ихгүй байх<br>**Тоооцолол:**<br>$$\sum_{1}^{787} \text{Нийт зээлийн багцад тухайн зээлийн эзлэх хувь} * \text{Тухайн зээлийн үлдэгдэл} < 20 \text{ сая төгрөг}$$ |
| 2 | Жигнэсэн дундаж зээлийн хүүгийн хэмжээ сарын 2.8%-иас багагүй байх<br>**Тоооцолол:**<br>$$\sum_{1}^{787} \text{Зээлийн багцын үлдэгдэлд тухайн зээлийн эзлэх хувь} * \text{Тухайн зээлийн сарын хүү} \geq 2.8\%$$ |
| 3 | Тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 30 сараас доошгүй байх<br>**Тоооцолол:**<br>$$\sum_{1}^{787} \text{Зээлийн багцын үлдэгдэлд тухайн зээлийн эзлэх хувь} * \text{Тухайн зээлийн үлдэгдэл хугацаа} \geq 30 \text{ сар}$$ |

СЗХ 2022 он 11 сар 09 өдөр БҮРТГЭВ № 01

СЭХ
БҮРТГЭВ

### Зээлийн шинжилгээ гаргагчийн хараат бус дүгнэлт

"Өнч аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу Хөрөнгийн багцаас 119 зээлийн хөрөнгийг түүвэрлэн авч, сонгогдсон зээлийн хөрөнгүүдийн хувьд санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар хараат бус зээлийн шинжилгээг Хамааралтай Ажил Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400 "Харилцан Тохиролцсон Ажил Үйлчилгээ"-ний дагуу хийж гүйцэтгэсэн байна. Зээлийн шинжилгээ гаргагч нь 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Үр дүнгийн тайлан"-д сонгогдсон зээлийн хөрөнгүүд нь зээлийн хөрөнгө, зээлдэгч, барьцаа хөрөнгө болон зээлийн багцын хувьд тавигдаж байгаа нийт 24 санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар хөндлөнгийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна.

## 2.4.2.2. Хөрөнгийн багцын тойм

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны баталгаа болох Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багц нь 761 зээлдэгчийн нийт 11.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, Санхүү болон Хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан 761 зээлийн гэрээнээс бүрдсэн ба тасалбар болгох өдрийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт 10: Хөрөнгийн багцын тойм мэдээлэл**

| Тасалбар болгох өдрийн байдлаарх Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| **Үзүүлэлт** | **Дүн** |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн төрөл** | Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн чанар** | 100 хувь хэвийн төлөлттэй зээлийн хөрөнгө |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл дүн** | 10,963,908,275 төгрөг |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн** | 14,207,607,000 төгрөг |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн тоо** | 761 зээл |
| **Хөрөнгийн багц дахь зээлдэгчдийн тоо** | 761 зээлдэгч |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн дундаж үлдэгдэл** | 14,407,238 төгрөг |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| **Жигнэсэн дундаж хүү /сар/** | 2.8% |
| **Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа** | 37 сар |
| **Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа** | 28 сар |
| **Жигнэсэн дундаж LTV** | 56.2% |

### Хөрөнгийн багцын төвлөрөл

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл дүн нь нийт 11.0 тэрбум төгрөг байгаагаас, 10 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 1.2 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 10.7 хувийг, 10-20 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 6.4 тэрбум төгрөг буюу 58.0 хувийг, 20-30 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 3.1 тэрбум төгрөг буюу 27.9 хувийг, 30 сая төгрөгөөс дээш үлдэгдэл дүнтэй зээл 0.4 тэрбум төгрөг буюу 3.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
он 2022 сар 11 өдөр 01
БҮРТГЭВ
№ 01

**Зураг 3: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдлийн тархалт**




Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд багтах үнийн дүнгээр хамгийн том 1 зээл нь нийт багцын 0.5%, хамгийн том 10 зээл 3.5%, хамгийн том 50 зээл 12.5%-ийг тус тус бүрдүүлж байгаа нь Хөрөнгийн багцын төвлөрөл бага буюу төвлөрлийн эрсдэл бага байгааг харуулж байна.

**Хүснэгт 11: Хөрөнгийн багц дахь өндөр дүнтэй зээлийн хөрөнгийн үлдэгдлийн мэдээлэл**

| Үзүүлэлт | Нийт үлдэгдэл /Мянган төгрөг/ | Хөрөнгийн багцад эзлэх хувь |
|---|---|---|
| **Хамгийн их дүнтэй 1 зээл** | 52,092 | 0.5% |
| **Хамгийн их дүнтэй 10 зээл** | 383,744 | 3.5% |
| **Хамгийн их дүнтэй 50 зээл** | 1,375,753 | 12.5% |

### Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огноо

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн 14.2 тэрбум төгрөг байгаагаас 27.3 хувь нь 2021 оны 2 болон 3-р улиралд олгосон зээл, 42.8 хувь нь 2021 оны 4-р улиралд олгосон зээл, үлдсэн 29.8 хувь нь 2022 онд олгосон зээл байна. Өөрөөр хэлбэл, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүд нь олгосон хугацааны хувьд харьцангуй шинэ зээлүүд байна.

**Зураг 4: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огнооны тархалт**




**Хүснэгт 12: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огноо**

| Анх олгосон огноо | | Зээлийн тоо | | Анх олгосон зээлийн дүн | |
|---|---|---|---|---|---|
| | | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 4/1/2021 | 6/30/2021 | 69 | 9.1% | 946,440 | 6.7% |
| 7/1/2021 | 9/30/2021 | 139 | 18.3% | 2,430,040 | 17.1% |
| 10/1/2021 | 12/31/2021 | 326 | 42.8% | 6,127,943 | 43.1% |
| 1/1/2022 | 3/31/2022 | 171 | 22.5% | 3,349,697 | 23.6% |
| 4/1/2022 | 6/30/2022 | 30 | 3.9% | 739,982 | 5.2% |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7/1/2022 | 9/4/2022 | 26 | 3.4% | 613,505 | 4.3% |
| **Нийт** | | **761** | **100.0%** | **14,207,607** | **100.0%** |

### Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хугацаа

Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны баталгаа болох Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж анх олгосон хугацаа нь 37 сар байгаа ба хамгийн богино хугацаатай зээл нь 24 сар, хамгийн урт хугацаатай зээл нь 48 сарын хугацаатайгаар анх олгогдсон байна.

**Хүснэгт 13: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон хугацааны тархалт**

| Анх олгогдох үеийн хугацаа, сараар | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 12-18 | - | 0.0% | - | 0.0% |
| 18-24 | 1 | 0.1% | 24,500 | 0.2% |
| 24-30 | 1 | 0.1% | 15,300 | 0.1% |
| 30-36 | 721 | 94.7% | 13,269,472 | 93.4% |
| 36-42 | - | 0.0% | - | 0.0% |
| 42-48 | 38 | 5.0% | 898,335 | 6.3% |
| **Нийт** | **761** | **100.0%** | **14,207,607** | **100.0%** |
| **Хамгийн их** | **48** | | | |
| **Хамгийн бага** | **24** | | | |
| **Жигнэсэн дундаж сар** | **37** | | | |

**Хүснэгт 14: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл хугацааны тархалт**

| Зээлийн үлдэгдэл хугацаа, сараар | Зээлийн тоо | | Үлдэгдэл дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 12-18 | - | 0.0% | - | 0.0% |
| 18-24 | 177 | 23.3% | 1,929,568 | 17.6% |
| 24-30 | 523 | 68.7% | 7,688,326 | 70.1% |
| 30-36 | 23 | 3.0% | 513,508 | 4.7% |
| 36-42 | 6 | 0.8% | 111,058 | 1.0% |
| 42-48 | 32 | 4.2% | 721,449 | 6.6% |
| **Нийт** | **761** | **100.0%** | **10,963,908** | **100.0%** |
| **Хамгийн их** | **48** | | | |
| **Хамгийн бага** | **20** | | | |
| **Жигнэсэн дундаж сар** | **28** | | | |

### Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт дуусах огноо

Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн хуваарь тасалбар болгох өдрийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт 15: Хөрөнгийн багцын эргэн төлөгдөх хуваарь**

| Зээлийн хөрөнгийн эргэн төлөлт дуусах огноо | Зээлийн тоо | | Үлдэгдэл дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| **2024 он** | | | | |
| II улирал | 70 | 9.2% | 658,786 | 6.0% |
| III улирал | 141 | 18.5% | 1,728,880 | 15.8% |
| IV улирал | 319 | 41.9% | 4,582,235 | 41.8% |
| **2025 он** | | | | |
| I улирал | 170 | 22.3% | 2,647,993 | 24.2% |

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | | |
|---|---|---|---|---|
| II улирал | 12 | 1.6% | 268,576 | 2.4% |
| III улирал | 11 | 1.4% | 244,932 | 2.2% |
| IV улирал | 6 | 0.8% | 111,058 | 1.0% |
| **2026 он** | | | | |
| II улирал | 17 | 2.2% | 381,909 | 3.5% |
| III улирал | 15 | 2.0% | 339,40 | 3.1% |
| **Нийт** | **761** | **100.00%** | **10,963,908** | **100.0%** |

**Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшин**

Хөрөнгийн багц дахь нийт 14.2 тэрбум төгрөгийн анх олгосон дүнтэй, 761 зээлийн хөрөнгөөс 108 зээлийн хөрөнгө буюу анх олгосон дүнгээр 13.7 хувь нь сарын 2.0-2.5 хувийн хүүтэй, 601 зээлийн хөрөнгө буюу анх олгосон үнийн дүнгээр 79.7 хувь нь сарын 2.5-3.0 хувийн хүүтэй, үлдсэн 52 зээлийн хөрөнгө буюу анх олгосон үнийн дүнгээр 6.6 хувь нь сарын 3.0-3.5 хувийн хүүтэй байна.

Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувь, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүдийн хамгийн бага сарын хүү 2.3 хувь байгаа нь санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

**Хүснэгт 16: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшний тархалт**

| Хүүгийн түвшин | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 1.5-2.0% | - | 0.0% | - | 0.0% |
| 2.0-2.5% | 108 | 14.2% | 1,940,340 | 13.7% |
| 2.5-3.0% | 601 | 79.0% | 11,330,027 | 79.7% |
| 3.0-3.5% | 52 | 6.8% | 937,240 | 6.6% |
| **Нийт** | **761** | **100.0%** | **14,207,607** | **100.0%** |
| **Хамгийн их** | **3.5%** | | | |
| **Хамгийн бага** | **2.3%** | | | |
| **Жигнэсэн дундаж дүн** | **2.8%** | | | |

**Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалт**

Барьцаа хангалт буюу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь Хөрөнгийн багцын хувьд 56 хувь байгаа буюу багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

**Хүснэгт 17: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалтын харьцаа**

| LTV харьцаа | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 0-20% | 19 | 2.5% | 335,365 | 2.4% |
| 20-40% | 93 | 12.2% | 1,577,560 | 11.1% |
| 40-60% | 361 | 47.4% | 6,508,876 | 45.8% |
| 60-80% | 288 | 37.8% | 5,785,806 | 40.7% |
| 80-100% | - | 0.0% | - | 0.0% |
| **Нийт** | **761** | **100.0%** | **14,207,607** | **100.0%** |
| **Хамгийн их** | **75%** | | | |
| **Хамгийн бага** | **0%** | | | |
| **Жигнэсэн дундаж дүн** | **56%** | | | |

## 2.4.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛГААНЫ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

Үнэт цаас гаргагч болох "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь Үнэт цаасжуулах хэлцлийг амжилттай хэрэгжүүлснээр үндсэн үйл ажиллагаа нь дараах зураглалын хүрээнд явагдана.

**Зураг 5: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий зураглал**




**Тайлбар:**

1. Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсны хүрээнд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг Зээлдэгчдээс цуглуулан, Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд хуримтлуулна;
2. Үйлчилгээ үзүүлэгч сар бүр хуримтлагдсан зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах дансанд дараа сарын 15-ны дотор шилжүүлнэ;
3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасны төлбөр болон үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлнө;
4. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" байгуулах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээ болон Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" болон бусад журмуудад нийцүүлэн Үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэнэ;
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийг төлөөлж Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансыг барьцаалах бөгөөд Зээлийн эргэн төлөлт, Багцын эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана;
6. Үнэт цаас гаргагчийн холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу эрх бүхий байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад тогтоосон хугацаанд хүргэж ажиллах;
7. Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн аудитортой гэрээ байгуулах замаар үйл ажиллагаанд аудит хийлгэнэ.

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот тогтоолоор дараах үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах журмуудыг баталсан байна. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
- Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам.

## 2.4.4. ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.4.4.1. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн тогтоолоор "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ыг баталсан бөгөөд тус журмаар Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд гаргаж буй Автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн хангах фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөх болон Үнэт цаас гаргагчийн холбогдох хууль тогтоомж, журам, гэрээгээр хүлээх төлбөрийн үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна.

**Төлбөр цуглуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын ажил үүрэг**

Үйлчилгээ үзүүлэгч нь дараах голлох ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

- Журамд тусгасан нөхцөл болон ТЗК, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээг үзүүлэх;
- Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд Зээлдэгчтэй харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх;
- Зээлдэгчээс Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Зээлийн гэрээнд заасан дансанд Зээлийн эргэн төлөлтийг шилжүүлж, Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн зээлийн эргэн төлөлтийг цуглуулах зорилгоор тусгайлан нээсэн Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд сар бүр хуримтлуулах бөгөөд хуримтлагдсан Зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг бүтэн дүнгээр нь дараа сарын 15-ны өдрийн дотор Төлбөр цуглуулах дансанд шилжүүлнэ. Хэрэв тухайн өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн Ажлын өдөрт багтаан шилжүүлэх;
- Багцын эргэн төлөлтийг ТЗК-д шилжүүлэхээс бусад зорилгоор Зээлийн эргэн төлөлт цулгуулах дансан дахь мөнгөн хөрөнгийг аливаа байдлаар захиран зарцуулахгүй, зарлагын гүйлгээ хийхгүй байх, тус данс болон түүний мөнгөн хөрөнгийг Үнэт цаас гаргагчийг төлөөлж буй Хөрөнгө итгэмжлэн удирдагчид "Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээ"-ний дагуу барьцаалуулна;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө тус бүрийн хувьд Зээлийн эргэн төлөлт болон зээлийн хөрөнгийн үлдэгдлийг тооцоолон Зээлийн эргэн төлөлтийн графиктай нь тулган бүртгэсэн Зээлийн данс бүртгэлийн тайланг сар бүрийн сүүлд нэгтгэн гаргаж, сар эхэлснээс хойш Ажлын 3 өдрийн дотор ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх, тайлагнах;
- Зээлдэгч Зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн болон төлбөл зохих хуваарьт төлбөрөөс давуулан илүү төлсөн тохиолдолд тухай бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэн даруй мэдээлэх ба Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг баримтална.
- Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг хадгалах мөн ТЗК болон Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн шаардлагаар ТЗК-д үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гаргах, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг, Зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гарган хүргүүлэх, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу боловсруулах бөгөөд гаргасан дүгнэлтийн үнэн зөв, бүрэн гүйцэт байдлыг бие даан хариуцах;
- Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон энэхүү Журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;

- Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас ТЗК болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах;
- Хууль тогтоомж болон журамд заасан бусад.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөр цуглуулах үйл ажиллагаанд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах данс руу шилжүүлж буй Багцын эргэн төлөлтийг Зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулан, хяналт тавих;
- Үнэт цаас гаргагчийг төлөөлж шаардлагатай тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчээс Төлбөр цуглуулах үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гаргуулах, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг болон Зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гаргуулан авч түүнд хяналт тавих;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагч болон Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах өөрийн ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг Үнэт цаас гаргагч болон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх, хэрэв тухайн ажилтан өөрчлөгдсөн бол энэ талаар Үнэт цаас гаргагч болон Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх;
- Төлбөрийн дараалалын дагуу тус журмаар зөвшөөрсөн гүйлгээг хийж гүйцэтгэх, хяналт тавина.

**Үнэт цаас гаргагчийн төлбөрийн дараалал**

Тус журмын дагуу Үнэт цаас гаргагч нь төлбөр төлөхдөө дараах дараалалыг баримтлах ба тогтоосон хугацаанд нэг дор холбогдох төлбөрийг төлнө. Үүнд:

- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр
- Хөндлөнгийн аудитын төлбөр
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал
- Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр
- Бусад Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлууд
- Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д заасны дагуу сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг байршуулах

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

*Холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагуудад төлөх үүрэг хүлээж буй төлбөр болон Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулахтай холбоотой үүсэх зөрүүг Төлбөрийн дарааллыг харгалзахгүй тухай бүр төлж барагдуулна.*

### 2.4.4.2. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ

Үнэт цаас гаргагч нь Үйчилгээ үзүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нартай "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх" гурван талт гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээгээр нэг талаас Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлдэгчтэй харилцаж, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналтыг хэрэгжүүлж, зээл төлүүлэх ажиллагааг гүйцэтгэх, тус гэрээнд заасны дагуу Хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үзүүлэх болон нөгөө талаас Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг**

Үйлчилгээ үзүүлэгч нь тус гэрээний хүрээнд дараах чиг үүрэгтэй байхаар талууд харилцан тохиролцжээ. Үүнд:

- Тус гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч эсвэл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээг үзүүлэх;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд Зээлдэгчтэй харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, Зээлдэгчийн өмнө Үнэт цаас гаргагчийг төлөөлж, Зээлийн эргэн төлөлтийг Зээлийн эргэн төлөлтийн графикт заасан хугацаанд Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээ болон төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдөрт мэдэгдэх;
- Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг хадгалах мөн Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн шаардлагаар Үнэт цаас гаргагчид үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гаргах, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг, Зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гарган хүргүүлэх, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу боловсруулах бөгөөд гаргасан дүгнэлтийн үнэн зөв, бүрэн гүйцэт байдлыг бие даан хариуцах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон тус гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;
- Өөрийн үйл ажиллагааны улмаас Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах;
- Хууль тогтоомж болон журамд заасан бусад чиг үүрэг.

**Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээ**

Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд заасан Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх үүргийн гүйцэтгэлийн хангуулах зорилгоор Үйлчилгээ

үзүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай "Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээ"-г байгуулсан ба Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийг цуглуулахаар Худалдаа хөгжлийн банканд тусгайлан нээсэн Зээлийн эргэн төлөлт цуглуулах данс, түүний үлдэгдэл мөнгөн хөрөнгө болон ирээдүйд орж ирэх орлого, тэдгээрийг захиран зарцуулах эрхийг барьцаалах харилцааг нарийвчлан зохицуулжээ.

### 2.4.4.3. Үйлчилгээ үзүүлэгч

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгч буюу зээлдэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна" гэж тодорхойлсон ба мөн тус хуулийн 19 дугаар зүйлийн 19.8 дахь хэсэгт Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх боломжтой байхаар заажээ. Үүний хүрээнд, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/15 тоот "Оролцогч талуудтай байгуулах гэрээний төслийг батлах тухай" тогтоолоор Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-тай болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний төслийг баталсан ба тус гэрээний хүрээнд үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх бүрэн чадамжтай болох тухай баталгаа, мэдэгдлийг мөн тусгасан байна.

Үйлчилгээ үзүүлэгч нь "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй эсвэл холбогдох хууль, журамд заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй ба үүнтэй холбогдох харилцааг "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ", Үнэт цаас гаргагчийн "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам" болон бусад холбогдох хууль тогтоомж, журмаар нарийвчлан зохицуулжээ.

## 2.4.5. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.4.5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн тогтоолоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ыг баталсан ба тус журмаар Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах замаар Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах мөн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөр болон бусад үүргийг гүйцэтгэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн хадгалах, удирдахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчдын хоорондын харилцааг зохицуулсан байна.

**Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах**

Тус журамд заасны дагуу, Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан буюу шилжүүлэн авсан Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсвэл тус журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд дараах байдлаар өөрчлөлт оруулахаар зохицуулсан байна. Үүнд:

1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих,

СЗХ 2022 11 09 БҮРТГЭВ

СЭХ
он 2022 сар 11 өдөр 09
БҮРТГЭВ
№ 01

2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх;
3. Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс өдөр бүр ирүүлсэн Хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тулган баталгаажуулах замаар Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд хяналт тавьж ажиллах ба тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор энэ тухай Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэж, тус журамд тусгасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

**Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих нөхцөл**

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дээрх журамд заасны дагуу шаардлага хангасан хөрөнгөөр солих арга хэмжээг авна. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны төлбөр төлөх чадварт сөргөөр нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн;
- Шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн аль нэг баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь хуанлийн 31 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн;
- Зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

**Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх нөхцөл**

Тус журамд тусгасны дагуу дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба нэмэгдүүлэх зээлийн хөрөнгө нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах Шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх заалтад заасны дагуу Баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь мөн тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангахгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон.

**Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах нөхцөл**

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тус журамд заасны дагуу Шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солихуйц орлуулах хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гарган өгөх боломжгүй, эсвэл уг жагсаалтад байгаа зээлийн хөрөнгө нь орлуулах хөрөнгөд тавигдах шаардлага, шалгуурыг хэсэгчлэн хангахгүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Шаардлага хангахгүй

СЗХ
он 2022 сар 11 өдөр 09
БҮРТГЭВ
№ 01

- Хөрөнгийн солих боломжгүй байх;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 31 хоногоос дээш хугацаа хэтэрсэн;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд Хөрөнгийн багцыг буцаан худалдахаар талууд харилцан тохиролцсон.

**Үнэт цаас гаргагчийн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах дансанд хуримтлагдсан Багцын эргэн төлөлтөөс "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасан төлбөрийн дарааллын дагуу төлөгдөх төлбөрийн үүргүүдийг бүрэн гүйцэтгэснээр тус дансанд үлдэх сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн, Үнэт цаас гаргагчийн дүрэмд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс зөвшөөрөл авсан дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тогтоосон хязгаарлалтын хүрээнд байршуулах боломжтой байна.

**Хүснэгт 18: Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулах боломжтой санхүүгийн хэрэгслүүд**

| № | Зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгсэл |
|---|---|
| 1 | Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас |
| 2 | Арилжааны банкны харилцах, хадгаламж |
| 3 | Дотоодын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас |

Үнэт цаас гаргагчийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулахтай холбоотойгоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөжтэй холбоотой шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж, Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварт аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л хүчин чармайлтыг гарган ажиллах;
- Хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарьт өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө дуусахаар тохируулсан байх;
- Хөрөнгө оруулалтыг хийхийн өмнө болон хийснээс хойших хугацаанд тухайн хөрөнгө оруулалт нь аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсгэх, эрсдэл дагуулахаар байна гэж Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсвэл Үнэт цаас гаргагчийн ТУЗ үзсэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтыг зогсоож, шаардлагатай мөнгөн хөрөнгийг гарган авах үйл ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулах.

### 2.4.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, Талуудын эрх үүргийг тодорхойлох зорилгоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-г байгуулсан байна.

Тус гэрээний дагуу, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд түүний эргэн төлөлтийг Үйлчилгээ үзүүлэгчээс хүлээн авах, Үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөх, Үнэт цаас гаргагчийн хууль тогтоомж, журам болон гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгэх, Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах үйл ажиллагаа

СЗХ
2022 оны 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг удирдах, Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр харилцан тохиролцсон байна.

Уг гэрээнд зааасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдын өмнө дараах голлох үүргийг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагаанд тус гэрээ болон Үнэт цаас гаргагчийн батлан мөрдөж буй журмуудын холбогдох зохицуулалтыг тус гэрээнд нийцүүлэн дагаж мөрдөх;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгын хүрээнд Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Хөдлөх эд хөрөнгийн цахим мэдээллийн санд бүртгүүлэх;
- Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбогдох хугацаанд Хөрөнгийн багцад холбогдох өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчээс сар бүр Төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх Багцын эргэн төлөлтийг хүлээн авах, Үнэт цаас эзэмшигчдэд Үнэт цаасны төлбөр төлөх, хууль тогтоомж, журам, гэрээгээр хүлээсэн болон холбогдох бусад төлбөр тооцоог хийхтэй холбоотойгоор Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмыг баримтлан хэрэгжүүлэх;
- Улирал бүр Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д тайлагнах;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэх үед зөрчил гарвал нэн даруй Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д мэдэгдэх бөгөөд үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой хариуцах мэргэжилтнийг томилно;
- Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн Хөрөнгийн багцыг эзэмших, бүртгэх, хяналт тавих;
- Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн Хөрөнгийн багцыг удирдах.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд тус гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцалж, шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгож, гэрээ байгуулна.

### 2.4.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч

| | |
|---|---|
| ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС | **"Юнайтед Айр Файнэнс" ХХК** |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** | 2021.09.16 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011831586 |
| **Регистрийн дугаар:** | 2870657 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Хөрөнгө итгэмжлэн удирдах |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005 тоот |
| **Утас:** | (976) 8080 8888, 7012 2346 |
| **Э-шуудан:** | info@uaf.mn |
| **Вэб хуудас:** | www.uaf.mn |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь санхүүгийн удирдлага, компанийн засаглаар мэргэшсэн, хараат бус гишүүд бүхий Төлөөлөн удирдах зөвлөл болон бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10 гаруй жилийн арвин туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдсэн гүйцэтгэх удирдлагын баг бүхий мэргэшсэн хамт олон юм. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тус компани нь биржийн зах зээлд нээлттэй хүрээнд гарсан нийт 65.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж, гурван тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна.

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн бүтэц зохион байгуулалт дараах байдалтай байна.

**Хүснэгт 19: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
| <br>**Х. Маргад-Эрдэнэ**<br>Гүйцэтгэх захирал | **Х. Маргад-Эрдэнэ** нь Монгол Улсын Их Сургуулийг бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 13 жил ажилласан арвин туршлагатай билээ.<br>Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Х. Маргад-Эрдэнэ нь "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг гүйцэтгэж байна. |
| <br>**Ж. Онон**<br>Партнер | **Ж. Онон** нь Лондонгийн Эдийн Засгийн Их Сургуулийг банк, санхүүгийн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй төгссөн байна. Тэрээр "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн үүсгэн байгуулагч ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал, олон улсын санхүүжилтээр 13 дахь жилдээ ажиллаж буй арвин туршлагатай мэргэжилтэн билээ.<br>Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Ж. Онон нь тус компанид партнерийн үүргийг гүйцэтгэж байна. |
| <br>**Б. Буяннэмэх**<br>Менежер | **Б. Буяннэмэх** нь Монгол Улсын Их Сургуулийг эдийн засаг мэргэжлийн бакалаврын зэрэгтэй, бизнесийн удирдлага мэргэжлийн магистрийн зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, багцын удирдлага, зээлийн шинжилгээ, их өгөгдлийн удирдлагын чиглэлээр 9 дэх жилдээ ажиллаж байна.<br>Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Б. Буяннэмэх нь Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн менежерийн үүргийг гүйцэтгэж байна. |

## 2.4.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаас гаргагч нь дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот тогтоолоор батасны хүрээнд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

СЗХ 2022 он 11 сар 09 өдөр БҮРТГЭВ №01

**“Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”**

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх Үйлчилгээ үзүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, гэрээнд тусгах мэдээлэл, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**“Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам”**

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх Хөндлөнгийн аудиторт тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, гэрээнд тусгах мэдээлэл, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам**

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Тус журмын дагуу, Үнэт цаас эзэмшигчид болон Эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн Үнэт цаас гаргагчийн мэдээ, мэдээллийг үнэн зөв олон нийтэд хүргэх, үүргийн хэрэгжилтийг “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-ний үндсэн дээр Хөрөнгө итгэмжлэн удирдагч гүйцэтгэх ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь гэрээний хэрэгжилтийг хянана.

**Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам**

Тус журмаар Үнэт цаас гаргагч биржийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг Үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна. (Бүлэг 4.5)

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулагдсан тусгай зориулалтын компани тул бүтэц зохион байгуулалтын хувьд онцлог бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулиас гадна “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”, Хорооноос баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” болон Үнэт цаас гаргагчийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу нарийвчлан зохицуулагдахаар байна. (Бүлэг 2.3.3)

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.9 дэх заалт, Хорооноос баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам” болон Биржээс баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржээр дамжуулан анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг Үнэт цаас гаргагчийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам”-аар зохицуулсан байна. (Бүлэг 6)

**Мөнгө угаах тероризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам**

Үнэт цаас гаргагчийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааны журам" нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой ерөнхий харилцааг зохицуулсан байна.

## 2.5.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 5-р сарын 25-ны өдрийн 22/04a/23 тоот "Шинээр охин компани үүсгэн байгуулах тухай" тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Үнэт цаас гаргагч болох "Бичил Эй Би Эс Актив" ХХК-ийг үүсгэн байгуулсан байна. Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1,000 ширхэг зарласан болон гаргасан энгийн хувьцаа бүхий 1,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үүсгэн байгуулагджээ.

**Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн эхлэлийн тайлан, тэнцэл**

| № | Үзүүлэлт | Актив | Пассив |
|---|---|---|---|
| 1 | Мөнгөн хөрөнгө | 1,000,000 | - |
| 2 | Хувь нийлүүлсэн хөрөнгө | - | 1,000,000 |
| | **Тэнцэл** | **1,000,000** | **1,000,000** |

### 2.5.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23a/17 тоот "Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай" тогтоолоор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны буюу 2022-2024 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

#### 2.5.1.1. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлын тайланг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлтийг нэгтгэн дараах байдлаар төлөвлсөн байна.

**Хүснэгт 21: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл**

| Үзүүлэлт | Улирал | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 0 | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| Бэлэн мөнгө | 1.0 | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 | 1,041.8 |
| Нийт зээл | 10,963.9 | 10,486.9 | 9,558.2 | 8,409.0 | 7,114.0 | 5,733.3 | 4,320.5 | 3,073.1 | 2,042.1 |
| Эрсдэлийн сан | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **10,964.9** | **12,028.0** | **9,843.7** | **10,124.3** | **7,838.6** | **8,005.8** | **5,582.8** | **5,596.2** | **3,083.9** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 10,000.0 | 10,000.0 | 7,500.0 | 7,500.0 | 5,000.0 | 5,000.0 | 2,500.0 | 2,500.0 | - |
| Бусад өглөг | 963.9 | 1,700.5 | 1,686.5 | 1,661.0 | 1,626.9 | 1,586.4 | 1,509.6 | 1,394.3 | 1,297.9 |
| **Өр төлбөрийн дүн** | **10,963.9** | **11,700.5** | **9,186.5** | **9,161.0** | **6,626.9** | **6,586.4** | **4,009.6** | **3,894.3** | **1,297.9** |
| Хувьцаат капитал | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 |
| Хуримтлагдсан ашиг | - | - | 326.4 | 656.1 | 962.2 | 1,210.7 | 1,418.5 | 1,572.2 | 1,700.9 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Татварын дараах ашиг | - | 326.4 | 329.7 | 306.1 | 248.5 | 207.7 | 153.7 | 128.7 | 84.1 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **1.0** | **327.4** | **657.1** | **963.2** | **1,211.7** | **1,419.5** | **1,573.2** | **1,701.9** | **1,786.0** |
| **Өр төлбөр ба эзний өмч** | **10,964.9** | **12,028.0** | **9,843.7** | **10,124.3** | **7,838.6** | **8,005.8** | **5,582.8** | **5,596.2** | **3,083.9** |

### 2.5.1.2. Орлого, зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс сар бүр хүлээн авах Багцын эргэн төлөлтөөс орох орлого болон Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны төлбөр болон үйл ажиллагаатай холбоотой гарах зардлуудад үндэслэн орлого, зардал болон мөнгөн урсгалаа дараах байдлаар төлөвлөсөн байна.

**Хүснэгт 22: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл**

| Үзүүлэлт | Улирал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| Багцын эргэн төлөлтийн орлого | 948.9 | 895.5 | 758.2 | 689.0 | 538.4 | 461.2 | 312.5 | 252.9 |
| ХБҮЦ-ны төлбөр | (437.5) | (437.5) | (328.1) | (328.1) | (218.8) | (218.8) | (109.4) | (109.4) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **511.4** | **458.0** | **430.1** | **360.9** | **319.7** | **242.4** | **203.2** | **143.6** |
| Үйл ажиллагааны зардал | (148.7) | (91.7) | (90.0) | (84.8) | (88.8) | (71.6) | (60.2) | (50.1) |
| **Татварын өмнөх ашиг** | **362.7** | **366.3** | **340.1** | **276.1** | **230.8** | **170.8** | **143.0** | **93.5** |
| Татвар | (36.3) | (36.6) | (34.0) | (27.6) | (23.1) | (17.1) | (14.3) | (9.3) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **326.4** | **329.7** | **306.1** | **248.5** | **207.7** | **153.7** | **128.7** | **84.1** |

Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд шилжих буюу анх худалдан авах үед тавигдсан холбогдох шаардлага, шалгуурыг хангахгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ", Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" болон "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн хөрөнгийг холбогдох шаардлага, шалгуурыг хангасан зээлийн хөрөнгөөр солих, солих боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах үүрэгтэй билээ. Өөрөөр хэлбэл, Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хэвийн ангилал бүхий зээлийн хөрөнгөөс бүрдэх болно.

**Хүснэгт 23: Үнэт цаас гаргагчийн зардлын төсөөлөл**

| № | Зардлын зориулалт | Дүн | Давтамж |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр | Удирдаж буй хөрөнгийн нийт 0.5 хувь | Улирал бүр |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр | Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь | Улирал бүр |
| 3 | Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр | Жилд 10 сая төгрөг | Жил бүр |
| 4 | ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал | Нийт 24 сая төгрөг | Улирал бүр |
| 5 | Зээлийн програм хангамжийн төлбөр | Нийт 15.8 сая төгрөг<br>4.5 сая төгрөг* | Нэг удаа<br>Улирал бүр |
| 6 | Захиргааны зардал | Сард 1.5 сая төгрөг | Улирал бүр |

**Эхний 6 сар 50%-ийн хөнгөлөлттэй.*

### 2.5.1.3. Мөнгөн гүйлгээний төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн 2022-2024 оны буюу үйл ажиллагаа явуулах хугацааны мөнгөн урсгалын төлөвлөгөө дараах байдалтай байна.

**Хүснэгт 24: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний төсөөлөл**

| | Улирал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт** | **I** | **II** | **III** | **IV** | **V** | **VI** | **VII** | **VIII** |
| Хүүгийн орох мөнгөн урсгал | 922.8 | 830.5 | 728.9 | 615.0 | 493.8 | 369.8 | 254.4 | 159.2 |
| Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал | 2,241.4 | 2,187.8 | 2,122.1 | 2,027.7 | 1,912.1 | 1,745.0 | 1,405.5 | 1,095.8 |
| ХБҮЦ-ны үндсэн төлбөр | | (2,500.0) | | (2,500.0) | | (2,500.0) | | (2,500.0) |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр | (437.5) | (437.5) | (328.1) | (328.1) | (218.8) | (218.8) | (109.4) | (109.4) |
| Үйл ажиллагааны зардал | (148.7) | (91.7) | (90.0) | (84.8) | (88.8) | (71.6) | (60.2) | (50.1) |
| Татварын зардалд төлсөн төлбөр | (36.3) | (36.6) | (34.0) | (27.6) | (23.1) | (17.1) | (14.3) | (9.3) |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **2,541.8** | **(47.4)** | **2,398.9** | **(297.9)** | **2,075.2** | **(692.6)** | **1,476.0** | **(1,413.7)** |
| Хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүгийн орлого | 26.1 | 65.0 | 29.3 | 74.1 | 44.6 | 91.3 | 58.2 | 93.7 |
| Банкны хадгаламж | 9.8 | 24.4 | 11.0 | 27.8 | 16.7 | 34.2 | 21.8 | 35.2 |
| Үнэт цаасны хөрөнгө оруулалт | 16.3 | 40.6 | 18.3 | 46.3 | 27.9 | 57.1 | 36.4 | 58.6 |
| Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт | (1,026.8) | (1,273.1) | (998.5) | (766.8) | (572.0) | (408.9) | (273.3) | (161.3) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **(1,000.8)** | **(1,208.1)** | **(969.2)** | **(692.7)** | **(527.4)** | **(317.6)** | **(215.1)** | **(67.6)** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1.0 | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 | 1,041.8 |

## 2.6.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах дансыг удирдан, хяналт тавьж ажиллана.

- **"Төлбөр цуглуулах данс"** гэж ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчээс шилжүүлсэн Хөрөнгийн багцын эргэн төлөлтийг хүлээж авч, Үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр, ТЗК-ийн гэрээгээр болон холбогдох хууль тогтоомж, журмаар хүлээсэн төлбөрийн үүргүүдийг Төлбөрийн дараалын дагуу гүйцэтгэх зорилгоор Худалдаа, хөгжлийн банканд тусгайлан нээлгэсэн данс байна.

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад дансууд**

- **Харилцах данс** гэж Үнэт цаасны төлбөр болон Үнэт цаас гаргагчийн хууль, тогтоомж, гэрээгээр хүлээх төлбөрийн үүргийг гүйцэтгэхээр Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах данснаас улиралд нэг удаа багцлан шилжүүлэх зорилгоор нээсэн Үнэт цаас гаргагчийн Худалдаа, хөгжлийн банкан дахь харилцах данс байна.
- **Үнэт цаасны данс** гэж Үнэт цаас гаргагч нь биржийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хүлээн авах зорилгоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгэсэн данс байна.

## 2.7.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ТАТАН БУУГДАХ

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий тусгай зориулалтын компани тул Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны холбогдох журам болон Компанийн дүрэмд тусгасны дагуу дараах тохиолдолд татан буугдана. Үүнд:

- Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн
- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан
- Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан

Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн эсвэл баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан тохиолдолд татан буулгах шийдвэрийг Үнэт цаас гаргагч эсхүл Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч гаргана. Үнэт цаас гаргагч нь баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан тохиолдолд Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх татан буулгах шийдвэрийг гаргахаар байна.

Үнэт цаас гаргагч татан буугдах тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу түүний хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Татан буулгах үйл ажиллагааны зардал;
2. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
3. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
4. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
6. Аудитын үйлчилгээний төлбөр;
7. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалтай холбоотой зардал;
8. Бусад ТЗК-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу гарах зардал;
9. Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
10. Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

## 3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ / ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

# ГУРАВ

СЗХ
он 2022 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 3.1. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

**"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК** нь анх 2008 онд үүсгэн байгуулагдаж, бичил зээлийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор, 3 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар төв оффис болон 16 салбар, 63 ажилтан, 5.5 мянган зээлдэгч, 6.5 мянган харилцагчтай томоохон банк бус санхүүгийн байгууллага болон өргөжин тэлжээ. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тус компани нь зээл, факторингийн үйл ажиллагаа болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь автомашин худалдан авахад зориулсан зээл, автомашин, үл хөдлөх хөрөнгө болон утасны дугаар барьцаалсан зээл гэсэн үндсэн 4 төрлийн зээлийн үйлчилгээг харилцагчдадаа санал болгон, түргэн шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж байна.

**Хүснэгт 25: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | 2022 оны 2-р улирлын байдлаар |
|---|---|
| **Хураангуй үйл ажиллагааны үзүүлэлтүүд** | |
| **Харилцагчдын сегмент** | ▪ **Иргэдийн зах зээл** |
| **Үйл ажиллагааны чиглэл** | ▪ Зээлийн үйл ажиллагаа<br>▪ Итгэлцлийн үйлчилгээ<br>▪ Факторингийн үйл ажиллагаа |
| **Зээлийн гол бүтээгдэхүүн** | ▪ Автомашин барьцаалсан зээл<br>▪ Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл<br>▪ Автомашин худалдан авалтын зээл<br>▪ Утасны дугаар барьцаалсан зээл |
| **Салбарын тоо** | ▪ **Төв оффис** болон **16 салбар** (Улаанбаатар хот – 14, Дорнод аймаг – 1) |
| **Харилцагчдын тоо** | ▪ 6,500 харилцагч |
| **Зээлдэгчдийн тоо** | ▪ 5,504 зээлдэгч |
| **Нийт ажилтны тоо** | ▪ 63 ажилтан |
| **Хураангуй санхүүгийн үзүүлэлтүүд** | |
| **Нийт хөрөнгө** | ▪ 66.6 тэрбум төгрөг |
| **Эздийн өмч** | ▪ 21.9 тэрбум төгрөг |
| **Нийт зээлийн багц** | ▪ 61.2 тэрбум төгрөг |
| **Чанаргүй зээлийн хувь** | ▪ 0.7% /ББСБ салбарын дунджаас 9.6 дахин бага/ |
| **Нийт итгэлцлийн дүн** | ▪ 13.2 тэрбум төгрөг |
| **Хүүгийн орлого** | ▪ 9.3 тэрбум төгрөг |
| **Цэвэр ашиг** | ▪ 4.0 тэрбум төгрөг |

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь санхүүгийн салбарт шаталсан хэлбэрээр хөгжиж, дэмжих бизнесийг өргөжүүлэн, дэлхийн баялгийг Монгол улсдаа бий болгох эх оронч хүчирхэг нэгдэл байх эрхэм

зорилгын дор нэгдэн үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 2021 онд Хорооны "Шилдгийн шилдэг банк бус санхүүгийн байгууллага"-аар шалгарсан байна.

СЗХ 2022.11.09 он сар өдөр БҮРТГЭВ № 01

**Зураг 6: Анхны үүрэг гүйцэтгэгчийн товч танилцуулга**

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

Бид санхүүгийн салбарт шаталсан хэлбэрээр хөгжиж, дэмжих бизнесийг өргөжүүлэн, дэлхийн баялгийг Монгол улсдаа бий болгох эх оронч хүчирхэг нэгдэл байна.

**АЛСЫН ХАРАА**

Харилцагчийн хөгжлийг бизнесийн үнэ цэнэ болгосон хамт олон бүхий, компанийн зохистой засаглалтай хүчирхэг нэгдэл байна

**ҮНЭТ ЗҮЙЛС**

**Эрсдэлгүй ирээдүй** – Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэлийг тооцоолж, эрсдэлийн удирдлагыг сайжруулна.

**Хамтын өгөөж** – Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж, харилцагч болон түншүүддээ харилцан үр өгөөжтэй бизнесийн сонгодог загварыг хэрэгжүүлнэ.

**Нэгдмэл зорилго** – Байгууллагын хэтийн зорилго, ажилтны хүсэл тэмүүллийн нэгдлийг тэнцвэржүүлэн ажиллана.

**Харилцагчийн хөгжил** – Харилцагчийн хөгжил нь байгууллагын бизнес хөгжлийн салшгүй хэсэг байж, харилцан үнэ цэнийг нэмэгдүүлнэ. Санхүүгийн салбарын ёс зүйн хэм хэмжээг

### 3.1.1. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 21/01А/141 тоот тогтоолоор гүйцэтгэх удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг баталсан ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дотоод хяналт, бизнес хөгжил, санхүү бүртгэл, зээл, захиргаа удирдлага болон мэдээллийн технологийн гэсэн 6 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 7: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт




### 3.1.2. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт зааснаар "толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1 /хараат компани/, 6.3 /охин компани/, 6.8 /хараат болон охин компанийн үргэлжилсэн хэлхээ холбоо/-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ" гэж заасан байна. Энэхүү заалтын дагуу "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болон компанийн нэгдлийн бүтэц нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар дараах байдалтай байна.

Зураг 8: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн нэгдлийн бүтэц



СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

Хүснэгт 26: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн танилцуулга

| Хувьцаа эзэмшигч | Танилцуулга |
|---|---|
| Бичил Глобус<br>**“Бичил глобус” ХХК**<br><br>”Бичил глобус финанс ББСБ” ХХК-ийн<br>**100 ш буюу 100%** | **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн толгой компани болох Бичил глобус ХХК** нь 2010 онд байгуулагдсан бөгөөд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, гадаад худалдаа, бизнесийн болон менежментийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.<br>2022 оны 2-р улирлын байдлаар Бичил глобус ХХК нь 35.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй байна. |
| <br>**С.Отгонбат**<br>”Бичил глобус” ХХК-ийн<br>**9,440 ш буюу 94.4%** | **Толгой компанийн хувьцаа эзэмшигч С.Отгонбат** нь МУИС-ийн Олон Улсын эдийн засгийн харилцааны магистр, АНУ-ын Аризона мужийн Их сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус суралцсан. Тэрээр ажлын гараагаа 2006 онд “Оргил хотхон” ХХК-аас эхлэн улмаар 2008 онд бичил зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг анхлан санаачлан, иргэдийн бичил зээлийн хэрэгцээг хангах зорилготойгоор Бичил глобус группийг үүсгэн байгуулж, өнөөдрийг хүртэл компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. |
| <br>**Б.Хүрэлхүү**<br>”Бичил глобус” ХХК-ийн<br>**560 ш буюу 5.6%** | **Толгой компанийн хувьцаа эзэмшигч Б.Хүрэлхүү** нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрын зэрэгтэй ба Номин Констракшн Девелопмент группийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрбээр Бичил глобус группийн үүсгэн байгуулагч бөгөөд ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. |

### 3.1.3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7. дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнээс бүрдсэн байхаар заажээ. Үүний хүрээнд, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 19/01А/136 тоот шийдвэрээр ТУЗ-ийн 3 ердийн гишүүн болон 2 хараат бус гишүүнийг, тус өдрийн 19/01А/138 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргыг тус тус томилсон байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хорооны 2022 оны 3-р сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг өөрийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжүүлэхийг эрмэлзэж ажиллаж байгаа ба ТУЗ-ийн гишүүд Хорооны Компанийн засаглалын сургалтад бүрэн хамрагдсан байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

**Хүснэгт 27: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
| <br>**Б.Хүрэлхүү**<br>ТУЗ-ийн дарга | **Боловсрол**<br>▪ Дархан, 15-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ МУИС-ЭЗС, Эдийн засаг, нягтлан бодогч бакалавр;<br>▪ МУИС-ХЗС, Эрх зүйн бакалавр;<br>▪ МУИС-ХЗС, Хууль зүйн магистр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2003-2005 – "Номин Холдинг" ХХК, Дотоод аудитын газрын дарга;<br>▪ 2005-2012 – "Номин Реалтор" ХХК, Гүйцэтгэх захирал;<br>▪ 2012-Одоо – "Эн Си Ди Групп", Гүйцэтгэх захирал. |
| <br>**С.Отгонбат**<br>ТУЗ-ийн гишүүн<br>Гүйцэтгэх захирал | **Боловсрол**<br>▪ 12-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;<br>▪ МУИС, Олон улсын эдийн засгийн харилцааны магистр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2006-2007 – "Оргил хотхон" ХХК, Гүйцэтгэх захирал;<br>▪ 2008-2009 – "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;<br>▪ 2013-Одоо – "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал. |
| <br>**Д.Ганболор**<br>ТУЗ-ийн гишүүн | **Боловсрол**<br>▪ ДУА, Оюуны ирээдүй цогцолбор, Бүрэн дунд боловсрол;<br>▪ Сити их сургууль, Үйлдвэр удирдлагын менежмент;<br>▪ Сити их сургууль, Архитектур дизайны сургууль.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2009-2013 – "Нью Арена" ХХК, Захирал;<br>▪ 2013-2017 – "Ноёдын тууръ" ХХК, Зураг төслийн инженер;<br>▪ 2017-2019 – "Баянтөхөм шандат" ХХК, Зураг төслийн удирдах инженер. |
| <br>**Б.Хишигсүрэн**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн | **Боловсрол**<br>▪ Увс аймгийн Улаангом, 2-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ Их засаг их сургууль, Эрх зүйч.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2007-2009 – "Очир угалз солюшин" ХХК, Хуулийн зөвлөх;<br>▪ 2009-2015 – "Сод Монгол Групп", Хүний нөөцийн менежер;<br>▪ 2015-Одоо – "Бэрс финанс ББСБ" ХХК, Хүний нөөцийн менежер. |
| <br>**Н. Золжаргал**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн | **Боловсрол**<br>▪ Эрдэнэт, 5-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ Худалдаа үйлдвэрийн дээд сургууль, Референт;<br>▪ Худалдаа үйлдвэрийн дээд сургууль, Бизнесийн удирдлага.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2007-2008 – МУИС-ОАСС, Нарийн бичиг;<br>▪ 2008-2012 – "Умбайн шим" ХХК, Менежер;<br>▪ 2013-2016 – "Төрийн банк" ХХК, Захирлын туслах;<br>▪ 2017-Одоо – "Бэрс финанс ББСБ" ХХК, Бичиг хэргийн ажилтан. |

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

### 3.1.4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй байна.

**Хүснэгт 28: "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн удирдлагын багийн танилцуулга**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
| <br>**Б.Баярчимэг**<br>Дэд захирал | **Боловсрол**<br>▪ 24-р сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ СЭЗИС, Банк санхүүч, бакалавр;<br>▪ ХААИС, Бизнесийн удирдлага, магистр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2003-2017 – Төрийн банк ХХК, Хяналт шалгалтын газрын захирал;<br>▪ 2018-2019 – Голомт банк, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал;<br>▪ 2019-Одоо – Бичил Глобус Финанс ББСБ ХХК, Дэд захирал. |
| <br>**Б.Даваабат**<br>Бизнес хөгжлийн газрын захирал | **Боловсрол**<br>▪ 13-р дунд сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ Соёлын коллеж, Компьютер оператор, тусгай дунд;<br>▪ СУИС, Соёлын арга зүйч, бакалавр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2011-2012 – Хийморь принтинг ХХК, Ахлах дизайнер;<br>▪ 2012-2016 – Креатив пролайн ХХК, Брэнд менежер, Креатив директор;<br>▪ 2016-2021 – Бичил глобус ХХК, Маркетингийн менежер;<br>▪ 2020-Одоо – Оранж электроникс ХХК, Гүйцэтгэх захирал;<br>▪ 2020-Одоо – Бичил глобус финанс ББСБ ХХК, Бизнес хөгжлийн газрын захирал. |
| <br>**Я.Адъяахүү**<br>Санхүү бүртгэлийн газрын захирал | **Боловсрол**<br>▪ МУИС-ЭЗС, Банкны эдийн засагч, бакалавр;<br>▪ Сайтама Их Сургууль-Япон, Төрийн удирдлага, магистр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 1992-1997 – Зах зээл судлалын хүрээлэн, Судлаач;<br>▪ 1998-2009 – Худалдаа хөгжлийн банк, Эдийн засагч, ДХА, газрын ахлах;<br>▪ 2009-2015 – Хас Банк, Хэлтсийн захирал, газрын захирал;<br>▪ 2015-2017 – Глашиер ассет ХОМК, Гүйцэтгэх захирал;<br>▪ 2018-2020 – Нэткапитал ББСБ, Эрсдэлийн захирал, Дэд захирал;<br>▪ 2020-Одоо – Бичил глобус финанс ББСБ ХХК, Санхүү бүртгэлийн газрын захирал. |
| <br>**Н.Гантулга**<br>Зээлийн газрын захирал | **Боловсрол**<br>▪ Увс 1-р сургууль, Бүрэн дунд боловсрол;<br>▪ ШУТИС, Математик загварчлал, бакалавр;<br>▪ Газарчин ИС, Бизнес удирдлага, магистр.<br>**Ажлын туршлага**<br>▪ 2007-2013 – БНСУ, Гэрээний ажилтан;<br>▪ 2013-2014 – Аварга Соёо ХХК, Оффис менежер;<br>▪ 2015-2017 – Бичил глобус групп ХХК, Зээлийн менежер;<br>▪ 2017-2018 – Бичил глобус ХХК, Салбарын эрхлэгч; |

СЭХ
он . . . сар . . . өдөр
БҮРТГЭВ
№ 01

- 2018-2019 – Бичил глобус финанс ББСБ ХХК, Салбарын эрхлэгч;
- 2019-Одоо – Бичил глобус финанс ББСБ ХХК, Зээлийн газрын захирал.



**Г.Юмсүрэн**
Дотоод хяналтын газрын захирал

**Боловсрол**

- Говь-Алтай 1-р сургууль, Бүрэн дунд боловсрол;
- Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага, бакалавр;
- СЭЗИС, Бизнесийн удирдлага, магистр.

**Ажлын туршлага**

- 2011– Бичил глобус ХХК, Менежер;
- 2011-2017 – Бичил глобус групп ХХК, Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал, Зээлийн хэлтсийн захирал;
- 2019-Одоо – Добу кредит ХХК, Гүйцэтгэх захирал
- 2019-Одоо – Бичил глобус финанс ББСБ ХХК, Дотоод хяналтын газрын захирал



**У. Ундармаа**
Хүний нөөцийн менежер

**Боловсрол**

- Нийслэлийн 51-р сургууль, Бүрэн дунд боловсрол;
- Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Сэтгүүлч

**Ажлын туршлага**

- 2007-2018 – Скайтел ХХК, Харилцагч хариуцсан менежер
- 2018-2021 – Голомт банк, Хүний нөөцийн менежер
- 2021-Одоо – Бичил глобус финанс ББСБ ХХК, Хүний нөөцийн менежер

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494

## 3.2. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.2.1. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрх бүхий байгууллагын санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажилладаг бөгөөд эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

**Хүснэгт 29: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөг**




*Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлан, Санхүүгийн зохицуулах хороо*

## Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2022 оны эхний хагас жилийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт 30: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд**

**Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт**




**Санхүүгийн хөшүүрэг, хүү төлөх чадварын харьцаа**




**ББСБ салбартай харьцуулсан үзүүлэлт, 2022 оны II улирал**




*Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлан, Санхүүгийн зохицуулах хороо*

**Тус харьцаа үзүүлэлтийг 2022 оны 2-р улирлын цэвэр ашгийн түвшинд тооцоолов.*

## 3.3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэлийн засаглалын бүтцийн дагуу эрсдэлийн удирдлагын дараах “Гурван давхар хамгаалалтын шугам”–ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг байна.

**Зураг 9: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц**




**Хүснэгт 31: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн удирдлага**

| | |
|---|---|
| **Макро эдийн засгийн эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтмол хянан, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдал, эрсдэл даах чадварыг үнэлж, зээлийн багцын төвлөрлөөс сэргийлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуурыг хангах, мөн холбогдох журмуудыг мөрдлөг болгох зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг. Мөн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд оновчтой нэвтрүүлэх замаар тогтвортой орлогын суурийг бий болгон ажиллана. |
| **Хууль эрхзүйн орчин, зохицуулалтын эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдөх замаар эрхзүйн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. |
| **Зээлийн эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшинг тооцон, зээлийн үнэ цэнийн бууралт, чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэн ажилладаг. Мөн гаргасан зээлийн хувьд тогтмол хяналт тавин үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг. |
| **Хүүгийн эрсдэл** | Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээлийн хүүгийн нөхцөл байдлын шинжилгээ болон бусад зохистой харьцаа, хязгаар үзүүлэлтийг харгалзан зээлийн хүүг эх үүсвэрийн өртөгтэй уялдуулан тогтоодог. |
| **Үйл ажиллагааны эрсдэл** | Дотоод үйл ажиллагаа, хяналтын систем, хүний хүчин зүйл болон технологийн доголдлоос бий болж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг. |
| **Төлбөрийн болон хөрвөх чадварын эрсдэл** | Хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон дотоодын санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг. Мөн эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна. |



## 4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

# ДӨРӨВ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## 4.1.ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР

Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох хэсэгт үндэслэн, Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/12 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор нийт 10.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахаар тогтоож, үнэт цаасны ерөнхий нөхцөлийг баталсан байна.

## 4.2.ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮГИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад санал болгох хүүгийн түвшинг зах зээлийн нөхцөл байдал болон үнэт цаасны онцлог шинжтэй уялдуулан тогтоосон байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 9-р сарын 20-ны өдрийн хурлаар төв банкны бодлогын хүү 10.0 хувь байсныг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12.0 хувьд хүргэх шийдвэр гаргаад байна.

2022 оны 8 сарын байдлаар зах зээл дэх банкнуудын 2 жилийн хугацаатай хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү 9.8 хувь, 2 жилийн хугацаатай шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 11.8 хувь, нээлттэй зах зээлд гарсан 24 сарын хугацаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 15.2 хувь байв.

**Зураг 10: Зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2022 оны 8-р сар**




Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хүү нь 2022 оны 8-р сарын байдлаарх системийн нөлөө бүхий 5 банкнуудын 2 жилийн хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулахад жилийн ойролцоогоор 5.7%-иар өндөр, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн түвшнээс 0.7-3.1%-иар өндөр байна. Хөрөнгө оруулагч нь ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг улирал тутам хүлээн авахаас гадна үндсэн төлбөрийг хагас жил тутам тэнцүү дүнтэйгээр хүлээн авч, дахин хөрөнгө оруулалт хийх замаар бодит өгөөжийн түвшингээ нэмэгдүүлэх боломжтой байна. Хаалттай бонд болон хадгаламжийн хүүгийн орлогоос 10%-ийг тооцож суутгадаг бол нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар тооцож байгаа нь хөрөнгө оруулагчдад бий болгож буй өгөөжийн түвшинг өндөр байлгахад нөлөөлж байна.

Түүнчлэн, хөрөнгө оруулагч нь улирал тутам хүлээн авах ХБҮЦ-ны купон болон үндсэн төлбөрийг дахин хөрөнгө оруулах замаар өгөөжийн түвшингээ нэмэгдүүлэх боломжтой байна.

## 4.3.ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Үнэт цаасыг эзэмшигч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах;

- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах;
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

### 4.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн хуулийн дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
- Компанийн дүрэм, баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, баталгаат үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангах;
- Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл болон бусад хууль тогтоомж, Хороо, Биржээс баталсан журамд заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд тухай бүр Хороо, Бирж болон Үнэт цаас эзэмшигчдэд нээлттэй мэдээлэх;
- Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;
- Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол тухайн хөрөнгийн багцыг буцаан худалдан авах;
- Холбогдох хууль тогтоомж, журам, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

### 4.5. ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тодорхой Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт болох мөнгөн урсгалаар баталгаажсан байдгаараа бусад өрийн хэрэгсэлтэй харьцуулахад харьцангуй эрсдэлийн түвшин багатай хөрөнгө оруулалтад тооцогддог. Гэсэн хэдий ч эрсдэлгүй хөрөнгө оруулалт гэж хаана ч байхгүй бөгөөд их бага хэмжээгээр бүхий л хөрөнгө оруулалтын хэрэгслүүд эрсдэл дагуулж байдаг. Тэдгээр эрсдэлүүдийг оновчтой тодорхойлон, тэдгээр эрсдэлийг удирдах нь зайлшгүй шаардлагатай юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хувьд үнэт цаасжуулах үйл ажиллагаа, хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн онцлог, оролцогч талуудтай холбоотой тодорхой эрсдэлүүд үүсэх боломжтой байдаг. Иймд, Үнэт цаас гаргагч нь эдгээр эрсдэлүүдийг удирдах зорилгоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлага, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-ыг баталжээ. Тус журмын 2.1 дэх хэсэгт ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилан, тухайн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулжээ. Үүнд:

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №

**Хүснэгт 32 : Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага эрсдэл**

| | |
|---|---|
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл** | |
| Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэл | ▪ Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын хүрээнд зээлийн хяналтыг хэрэгжүүлэх, зээл төлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд Зээлийн хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээл олгох үйл ажиллагаанд дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн түвшин 2022 оны 2-р улирлын байдлаар 0.7 хувь байгаа нь ББСБ-ын салбараас 9.6 дахин бага буюу тус компани эрсдэлээ оновчтой удирддаг болохыг харуулж байна;<br>▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Шалгуур үзүүлэлт болон бусад шаардлагыг хангасан Орлуулах зээлийн хөрөнгөөр солихоор үүрэгжүүлсэн;<br>▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө бүрийг сонгоход тавигдсан шалгуур үзүүлэлтийн дагуу зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг тэргүүн ээлжид гаргуулах боломжтой байхаар тусгажээ. |
| Зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө эргэн төлөх эрсдэл | ▪ Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. |
| Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсантай холбоотой төлөвлөсөн хүүгийн орлого буурах эрсдэл | ▪ Зээлийн гэрээнд өөрчлөлт орох тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчид болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэхээр тусгасан бөгөөд "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-гээр энэхүү нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд тухайн зээлийн хөрөнгийг Шаардлага хангахгүй хөрөнгөд тооцон, Орлуулах хөрөнгөөр солихоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг үүрэгжүүлсэн. |
| **Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл** | |
| Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд тусгасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график болон үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн график дээр хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна. |
| Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Хөрөнгийн багц чанаргүйдэх эрсдэл | ▪ "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд тусгасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх, солих замаар өөрчлөлт оруулсан нь Хөрөнгийн багцийн үзүүлэлтийг өмнөхөөс дутуугүй байлгахаар заасан бөгөөд хэрэв Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгө ангилалд шилжсэн эсхүл Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх, солих үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулах замаар Хөрөнгийн багцыг хэвийн зээлийн ангилал бүхий зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхээр зохицуулсан. |
| **Оролцогч талуудтай холбоотой эрсдэл** | |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулах үүргээ биелүүлэхгүй | ▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх боломжгүй байх болон Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-д заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах эрхтэй байна; |

TDB SECURITIES

| | |
|---|---|
| эсхүл биелүүлэх боломжгүй байх төлбөрийн чадваргүй болох, татан буугдах/ | ▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасны дагуу уг Хөрөнгийн багцыг гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүхэлд нь худалдан борлуулах эрхтэй байна;<br>▪ Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний дагуу Үнэт цаас гаргагчид Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх бий болох бөгөөд гуравдагч этгээдэд худалдан борлуулаагүй зээлийн хөрөнгийн хувьд Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагаа эхлүүлнэ. |
| **Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Зээлийн эргэн төлөлтийг бүрэн гүйцэд, гэрээнд заасан хугацаанд цуглуулан, Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй байх, тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах/ | ▪ Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг Худалдаа, хөгжлийн банканд тусгайлан нээсэн зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийг төлөөлөн тус дансыг, түүнд орж ирэх орлогын хамт Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээгээр барьцаалж, тус дансанд тогтмол хяналт тавьж ажиллана;<br>▪ Төлбөр цуглуулах үйл ажиллагааг Үйлчилгээ үзүүлэгч нь цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгах ба учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Үйлчилгээ үзүүлэгч өөрийн хөрөнгөөр төлж барагдуулахаар зохицуулсан;<br>▪ Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцтай холбоотой түүний авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх буюу үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна. |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл** /Хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасныаас бусад зорилго, зориулалтаар буюу Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, гэрээнд заасан үүргийг зохих ёсоор биелүүлэхгүй байх, | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон түүний эргэн төлөлтийг удирдахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад холбогдох тайлан мэдээллийг тогтмол хүргэх бөгөөд хууль тогтоомж болон гэрээнд заасныаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй байна. Мөн, зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгасан байна;<br>▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг эрх бүхий зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна; |

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

| | |
|---|---|
| Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, татан буугдах, дампуурах эсвэл гэрээнд заасан үүргээ биелүүлэх чадваргүй болох/ | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон хөрөнгө итгэмжлэн удирдагчид Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө, түүний эргэн төлөлтөд хамаарах бүх баримт бичиг, данс, тооцоо, бэлэн мөнгө, тайлан зэргийг цахим болон бусад хэлбэрээр ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгөх үүрэгтэй байна. |
| **Хууль эрх зүйн орчинтой холбоотой эрсдэлийн удирдлага** | ▪ Хөндлөнгийн хуулийн зөвлөхийн дүгнэлтийн дагуу, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь аливаа хууль эрх зүйн зөрчилгүй байгаа ба цаашид хууль тогтоомж, журам, зохицуулалттай холбоотой эрсдэлийг удирдах үүднээс Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хөндлөнгийн хуулийн зөвлөхийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллахаар "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-д тусгасан байна. |
| **Зах зээл дэх хүүгийн түвшний эрсдэлийн удирдлага** | ▪ Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээ тогтмол байх хэдий ч үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар зах зээл дэх хүүгийн түвшнээс харьцангуй өндөр байна. Мөн хөрөнгө оруулагч нь энэхүү үнэт цаасанд хөрөнгө оруулснаар улирал тутам хүүгийн төлбөр, хагас жил тутам үндсэн төлбөрийг хүлээж авах ба үүнийг дахин хөрөнгө оруулах замаар хүүгийн түвшний эрсдэлээ бууруулах боломжтой байна. |
| **Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл** | ▪ Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс үүсэх эрсдэлтэй холбогдуулан Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллагыг хөлслөн ажиллуулах, эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулах;<br>▪ Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухай Үнэт цаас эзэмшигчдэд брокерийн компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, Үнэт цаас гаргагч болон Биржийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна. Мөн, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөхгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн үүрэг биелүүлэх хугацаа нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. |

# 5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

ТАВ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## 5.1. МАКРО ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

**Хүснэгт 33: Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Нэгж | 2019 | 2020 | 2021 | 2022.II |
|---|---|---|---|---|---|
| **Үндэсний тооцоо** | | | | | |
| ДНБ, оны үнээр | Тэрбум төгрөг | 37,839.2 | 37,453.3 | 43,555.5 | 23,019.8 |
| ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр | Тэрбум төгрөг | 27,928.3 | 26,655.4 | 27,091.7 | 12,791.0 |
| ДНБ, жилийн бодит өсөлт | Хувь | 5.6 | -4.6 | 1.6 | 1.9 |
| Нэг хүнд ногдох ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр | Мянган төгрөг | 8,750.3 | 8,264.8 | 8,252.7 | N/A |
| **Улсын нэгдсэн төсөв** | | | | | |
| Төсвийн орлого | Тэрбум төгрөг | 10,905.5 | 9,421.6 | 12,689.4 | 8,001.5* |
| Төсвийн зарлага | Тэрбум төгрөг | 11,661.7 | 13,960.8 | 15,598.1 | 8,191.9* |
| Төсвийн тэнцэл | Тэрбум төгрөг | (756.2) | (4,539.1) | (2,908.7) | (844.0) |
| Засгийн газрын нийт өр | Тэрбум төгрөг | 23,915.1 | 27,895.4 | 27,115.8 | N/A |
| **Гадаад худалдаа** | | | | | |
| Эргэлт | Сая ам.доллар | 13,747.1 | 12,875.2 | 16,095.8 | 9,256.4 |
| Экспорт | Сая ам.доллар | 7,619.6 | 7,576.3 | 9,247.1 | 5,308.3 |
| Импорт | Сая ам.доллар | 6,127.5 | 5,298.9 | 6,848.6 | 3,948.1 |
| Тэнцэл | Сая ам.доллар | 1,492.1 | 2,277.4 | 2,398.5 | 1,360.2 |
| **Мөнгөний нийлүүлэлт** | | | | | |
| Мөнгө М1 | Тэрбум төгрөг | 3,911.4 | 4,212.4 | 6,507.2 | 6,067.1 |
| Мөнгө М2 | Тэрбум төгрөг | 21,063.6 | 24,480.7 | 27,863.5 | 27,614.2 |
| **Хүүгийн түвшин** | | | | | |
| Инфляцын түвшин /жилийн/ | Хувь | 5.2% | 2.3% | 13.4% | 16.1% |
| Бодлогын хүү | Хувь | 11.0% | 6.0% | 6.0% | 10.0% |
| Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү | Хувь | 11.0% | 5.7% | 6.2% | 9.5% |
| Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/ | Хувь | 11.3% | 10.2% | 7.0% | 7.3% |
| Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/ | Хувь | 4.8% | 3.7% | 2.0% | 2.1% |
| Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/ | Хувь | 16.8% | 16.6% | 15.5% | 15.3% |
| Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/ | Хувь | 10.4% | 10.3% | 9.1% | 9.9% |
| Ам.долларын ханш /хугацааны эцэс/ | Төгрөг | 2,734.3 | 2,849.9 | 2,849.3 | 3,134.1 |
| **Хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого** | | | | | |
| Монгол Улсын нийт хүн ам | Мянган хүн | 3,296.9 | 3,357.5 | 3,409.9 | N/A |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | Хувь | 54.4 | 54.6 | 52.3 | 54.7 |
| Дундаж цалингийн хэмжээ /сарын/ | Мянган төгрөг | 1,124.3 | 1,220.6 | 1,279.4 | N/A |
| Өрхийн дундаж орлого /сарын/ | Мянган төгрөг | 1,375.1 | 1,424.6 | 1,642.9 | 1,787.5 |
| Өрхийн зарлага | Мянган төгрөг | 1,444.2 | 1,456.9 | 1,526.6 | 1,811.2 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк*

**2022 оны эхний хагас жилийн байдлаарх төсвийн тэнцвэржүүлээгүй орлого, зарлагын дүн*

СЗХ БҮРТГЭВ
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## Монгол Улсын эдийн засаг

### Дотоодын нийт бүтээгдэхүүн

2022 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн 23.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.9 хувь буюу 3.2 их наяд төгрөгөөр өсжээ. Харин, үнийн өсөлтийг арилгасан буюу 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсөж 12.8 их наяд төгрөгт хүрчээ. Бодит ДНБ-ий өсөлтийн хамгийн өндөр буюу 1.8 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбарын өсөлт бүрдүүлж байгаа бол уул уурхай, олборлолтын салбар -3.7 нэгж хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.7 нэгж хувь, үйлчилгээний салбар 2.9 нэгж хувь, бусад салбар 0.7 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсын эдийн засаг ирэх жилүүдэд дараах байдлаар өснө гэж таамаглаж байна.

**Хүснэгт 34: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал**

| Байгууллага | Эдийн засгийн өсөлтийн таамаглал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022F | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F |
| Дэлхийн банк | 2.5% | 5.8% | 6.8% | - | - | - |
| АХБ | 2.3% | 5.6% | - | - | - | - |
| ОУВС | 2.0% | 7.0% | - | - | - | 5.0% |
| Монголбанк | 2.4% | 5.9% | 6.5% | - | - | - |
| **Дундаж** | **2.3%** | **6.1%** | **6.6%** | **-** | **-** | **5.0%** |

*Эх сурвалж: Дэлхийн Банк "Монгол Улсын эдийн засгийн тойм, 2022.04",*
*Азийн Хөгжлийн Банк " Азийн хөгжлийн тойм 2022.04",*
*ОУВС "Дэлхийн эдийн засгийн тойм 2022.04",*
*Монголбанк "Инфляцын тайлан 2022.06".*

### Инфляцын түвшин

Монгол улсын инфляцын түвшин 2022 оны 7 дугаар сарын байдлаар зорилтот түвшнийг давж, улсын хэмжээнд 15.7 хувьд хүрээд байгаа ба үүний 40.1 хувийг хүнс, ундаа усны бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, 15.9 хувийг тээврийн үнийн өсөлт, 13.8 хувийг хувцас, бөс барааны үнийн өсөлт эзэлжээ. Түүнчлэн, нийт үнийн өсөлтийн 54.1 хувь буюу 15.7 нэгж хувь нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэлтэй байна. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон Монголбанкны зүгээс Монгол Улсын инфляцын түвшнийг ирэх жилүүдэд дараах байдлаар таамаглаж байна.

**Хүснэгт 35: Монгол Улсын инфляцын таамаглал**

| Байгууллага | Инфляцын таамаглал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022F | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F |
| Дэлхийн банк | 10.5% | 7.5% | 6.8% | - | - | - |
| АХБ | 12.4% | 9.3% | - | - | - | - |
| ОУВС | 15.5% | 14.5% | - | - | - | 6.5% |
| Монголбанк | 14.7% | 7.2% | 6.5% | - | - | - |
| **Дундаж** | **13.3%** | **9.6%** | **6.7%** | **-** | **-** | **6.5%** |

*Эх сурвалж: Дэлхийн Банк "Монгол Улсын эдийн засгийн тойм, 2022.04",*
*Азийн Хөгжлийн Банк " Азийн хөгжлийн тойм 2022.04",*
*ОУВС "Дэлхийн эдийн засгийн тойм 2022.04",*
*Монголбанк "Инфляцын тайлан 2022.06".*

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 5.2. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

### Банк бус санхүүгийн салбарын санхүүгийн салбарт эзлэх байр суурь

2021 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн салбарын нийт хөрөнгө 44.6 их наяд төгрөг, үүнээс банкны салбарын хөрөнгө 41.0 их наяд төгрөг буюу 92.1 хувь, банк бус санхүүгийн салбарын хөрөнгө 2.7 их наяд төгрөг буюу 6.1 хувь, даатгалын салбарын хөрөнгө 425.4 тэрбум төгрөг буюу 1.0 хувь, үлдсэн 406.6 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг үнэт цаас болон хадгаламж зээлийн хоршооны салбарын хөрөнгө бүрдүүлжээ.

Банк бус санхүүгийн салбарын хөрөнгө 2016 оны байдлаар санхүүгийн салбарын хөрөнгийн 3.0 хувь, банкнаас бусад санхүүгийн байгууллагын хөрөнгийн 65.6 хувийг бүрдүүлж байсан бол 2021 оны эцсийн байдлаар санхүүгийн салбарын хөрөнгийн 6.1 хувь, банкнаас бусад санхүүгийн салбарын хөрөнгийн 76.5 хувийг дангаараа бүрдүүлж байна.

**Зураг 11: Санхүүгийн салбарын оролцогчдын нийт хөрөнгө**




*Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж*

**Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүдийг татан буугдсан банкнуудыг оруулж тооцов*

Санхүүгийн салбарын нийт хөрөнгө сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 10.9 хувийн өсөлт үзүүлсэн байна. Үүнээс, банк бус санхүүгийн салбар хамгийн өндөр буюу 28.0 хувийн өсөлттэй ажилласан бол хадгаламж зээлийн хоршооны салбар 20.8 хувь, даатгалын салбар 15.3 хувь, банкны салбар 10.1 хувь, үнэт цаасны компаниуд 4.7 хувийн өсөлттэй тус тус ажиллажээ.

**Зураг 12: Нийт хөрөнгийн жилийн дундаж өсөлт, 2016-2021 он**




*Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

Санхүүгийн салбарын оролцогчид 2021 оны байдлаар нийт 792.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба үүнээс банкны салбар 542.0 тэрбум төгрөг, банк бус санхүүгийн салбар 210.0 тэрбум төгрөг, даатгалын салбар 25.2 тэрбум төгрөг, үнэт цаас болон хадгаламж зээлийн хоршооны салбар 14.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

**Зураг 13: Санхүүгийн салбарын оролцогчдын цэвэр ашиг**




*Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж*

**Банк бус санхүүгийн байгууллагын голлох үзүүлэлтүүд**

2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 527 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 59 ББСБ нь итгэлцлийн үйлчилгээ, 42 ББСБ нь факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Мөн үеийн байдлаар, салбарын нийт хөрөнгө 3.2 их наяд төгрөгт хүрсэн нь санхүүгийн салбарын хөрөнгийн 6.1 хувийг бүрдүүлжээ.

**Зураг 14: Банк бус санхүүгийн байгууллагын салбарын онцлох үзүүлэлтүүд, 2022 оны 2-р улирал**

**ББСБ-ын тоо**
**527**

**Нийт хөрөнгө**
**3,182.7**
**тэрбум төгрөг**

**Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын тоо**
**59**

**Санхүүгийн салбарт эзлэх хувь**
**6.1%**

**Факторингийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын тоо**
**42**

**Нийт зээлийн багц**
**2,497.8**
**тэрбум төгрөг**

**Зээлдэгчдийн тоо***
**1.7 сая зээлдэгч**

**Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**
**7.0%**

*Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж*
**2021 оны жилийн эцсийн байдлаар*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

2022 оны хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 40.6 хувийн өсөлт үзүүлж 3.2 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 27.6 хувийн өсөлт үзүүлж 2.0 их наяд төгрөг, цэвэр зээлийн хэмжээ 62.6 хувийн өсөлт үзүүлж 2.4 их наяд төгрөгт тус тус хүрсэн байна. Мөн, 2022 оны хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн салбар 149.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76.0 хувиар өссөн үзүүлэлт байна.

**Хүснэгт 36: Банк бус санхүүгийн салбарын санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг**



2022 оны эхний хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөг байгаагаас хэвийн зээл 2.2 их наяд төгрөг буюу 89.1 хувь, хугацаа хэтэрсэн зээл 98.1 тэрбум төгрөг буюу 3.9 хувь, чанаргүй зээл 174.2 тэрбум төгрөг буюу 7.0 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 37: Банкны салбар болон Банк бус санхүүгийн салбарын харьцуулалт**

**Банкны салбар болон банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн түвшин**




**Банк бус санхүүгийн салбарын зээлийн эрсдлийн сангийн хүрэлцээ**




Хорооны "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу анхаарал хандуулах ангилалтай зээлийн 25 хувиар, хэвийн бус зээлийн 50 хувиар, эргэлзээтэй зээлийн 75 хувиар, муу зээлийн 100 хувиар тооцон эрсдэлийн сангаа байгуулдаг бөгөөд 2022 оны эхний жилийн байдлаар салбарын эрсдэлийн сангийн хувь 74.9 хувь байна. Өөрөөр хэлбэл, банк бус санхүүгийн салбарын оролцогчид 2022 оны эхний хагас жилд нийт чанаргүй зээлийн 74.9 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулж ажиллажээ.

**Хүснэгт 38: Банкны салбар болон Банк бус санхүүгийн салбарын харьцаа үзүүлэлт**

**Банк бус санхүүгийн салбарын санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд, 2020-2021 он**




2021 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгийн өгөөж 8.9 хувь хүрч өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар, нийт эздийн өмчийн өгөөж 12.9 хувь хүрч өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар, цэвэр ашгийн ахиуц 49.8 хувь хүрч өмнөх оны мөн үеэс 4.0 нэгж хувиар тус тус өссөн байна.

СЗХ
БҮРТГЭВ
№

## 5.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2021 оны байдлаар Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 5,983 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 97.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг 2021 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулахад 13.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.7 пунктээр өссөн үзүүлэлт юм.

**Зураг 15: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг**




2021 оны байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 1.4 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 21.6 дахин өссөн үзүүлэлт байна. Үүнээс, 846.3 тэрбум төгрөг буюу 59.8 хувь нь анхдагч зах зээлийн арилжаа байсан бол 568.0 тэрбум төгрөг буюу 40.2 хувь нь хоёрдогч зах зээлийн арилжаа байжээ. Түүнчлэн, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар 5.1 хувь болж өмнөх онтой харьцуулахад 3.3 нэгж хувиар өссөн байна.

**Зураг 16: Хөрөнгийн зах зээлийн нийт арилжааны дүн, хөрвөх чадварын түвшин, тэрбум төгрөг**




## 5.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Монгол Улсад 2010 онд "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль", 2011 онд Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" батлагдсан нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хууль эрх зүйн орчин хөгжих суурь болжээ.

Улмаар, 2013 онд Хорооны "МИК Актив Нэг ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай" 512 тоот тогтоолын дагуу анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарсан байна.

**2010 он**

"Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль" батлагдав.

**2011 он**

Санхүүгийн Зохицуулах Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" батлагдав.

**2013 он**

"МИК Актив Нэг ТЗК" ХХК анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргав.

**2020 он**

"Инвескор Актив ТЗК" ХХК анхны нэлттэй, автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргав.

**2022 оны 8 сар**

2022 он гарснаас хойш нийт 65.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэгдээд байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх замаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээс гадна хөрөнгө оруулагчдад дараах нийтлэг давуу талыг бий болгодог байна. Үүнд:

- **Эрсдэлийн түвшин харьцангуй бага хөрөнгө оруулалт**
  Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.2 дахь хэсэгт "Тусгай зориулалтын компани нь хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн авах замаар баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших эрхтэйг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж тусгажээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч нь Тусгай зориулалтын компанийн эзэмшиж байгаа Хөрөнгийн багцаас бусад буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг хүлээхгүй тул компанийн бондтой харьцуулахад харьцангуй эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог.

- **Татварын хувь хэмжээ бага**
  Хөрөнгө оруулагч нь биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд гарч байгаа өрийн бичиг болон банкны хадгаламжаас орсон хүүгийн орлогоос 10%-ийн татварт төлдөг бол нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар тооцож байгаа нь хөрөнгө оруулагчдад бий болгож буй өгөөжийн түвшинг өндөр байлгахад нөлөөлж байна.

СЭХ БҮРТГЭВ № 01

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

## 6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ

# ЗУРГАА

## 6.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Биржийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаасан үнэт цаасны бүртгэлийн журам", Хорооны 2022 оны 6 сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам", болон Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан, Биржийн ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу явуулна.

Үнэт цаас гаргагч нь тус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 100 хувь олон нийтэд санал болгох бөгөөд Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн аргаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/12 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг бүрийн үнийг тогтоосон үнийн аргаар 100,000 төгрөг байхаар тогтоосон байна.

## 6.2. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

**Зураг 17: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь**




## 6.3. ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Хороо болон Биржид гаргаж, тус зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс өмнө энэ талаарх мэдэгдлийг Хороонд ажлын гурваас доошгүй хоногийн өмнө, Биржид ажлын 5 хоногийн өмнө гаргах бөгөөд тус мэдэгдлийг хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, анхдагч зах зээлийн арилжааг эхлэх, дуусгах өдрийг товлон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авч, арилжааг зохион байгуулан, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн бүртгэл хийх зөвшөөрөл болон Биржид үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь дээрх албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаасны бүртгэлийг хийж, Хороо болон Биржид мэдэгдэх ба Бирж нь бүртгэл хийгдсэн тухай мэдэгдэлд үндэслэн ажлын 2 өдрийн дотор үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

## 6.4. ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

Бирж болон Хороо нь үнэт цаасыг бүртгэж, үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдахыг зөвшөөрсний дараа Андеррайтер нь тухайн үнэт цаасны танилцуулах аяныг эхлүүлэх талаар мэдэгдлийг ажлын гурваас доошгүй хоногийн өмнө Хороонд хүргүүлж, үнэт цаасыг нийтэд мэдээлэх, танилцуулах аяныг ажлын арав хоногт багтан зохион байгуулна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэхээс өмнөх бэлтгэл үе шатанд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь түниш болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй хөрөнгө оруулалт татах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийж болох бөгөөд үүнийг үнэт цаасыг нийтэд санал болгосонд тооцохгүй.

## 6.5. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

Үнэт цаасыг нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай Хорооноос шийдвэр гаргасны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг тодорхойлж, Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3 хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг Хороонд хүргүүлж, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногт хүлээн авах ба ХБҮЦ-ны захиалгын бүртгэлийг Биржийн анхдагч зах зээлийн арилжааны програмаар дамжуулан зохион байгуулна.

## 6.6. ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9-р сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот "Журам батлах тухай" тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журмыг баталсан байна. Тус журамд хувьцааны хуваарилалт хийх үйл ажиллагааг Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөж, Биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ыг баримтлан хэрэгжүүлэх ба анхдагч зах зээлийн арилжааны хэлцэл биелүүлэх ажиллагааг Үнэт цаасны танилцуулга болон Андеррайтераас ирүүлсэн хүсэлтэд тусгасан хуваарилалтын нөхцөлийн дагуу Бирж гүйцэтгэнэ.

Хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын тоо хэмжээ Үнэт цаасны танилцуулгад тусгасан үнэт цаасны тоо хэмжээнд хүрсэн тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжааг хааж холбогдох хуваарилалтыг хийнэ.

Үнэт цаасны танилцуулгад тусгасан үнэт цаасны тоо хэмжээнээс давсан захиалгыг цуцална.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 6.7. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ, ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

Хөрөнгө оруулагч нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах заагрын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө байршуулах ба үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгнө.

**Зураг 18: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар**




- Үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэнэ.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээрх өөрийн нэр дээрх дансанд ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулна.
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид ХБҮЦ худалдан авах захиалга өгнө.
- Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, эрх бүхий байгууллага зөвшөөрснөөр хөрөнгө оруулагчийн нэр дээр ХБҮЦ шилжинэ.

### Мөнгөн хөрөнгө байршуулах

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэрийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулна.

### ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулах заавар

| | |
|---|---|
| Хүлээн авагчийн банк | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Хүлээн авагчийн нэр | Овог, нэр |
| Дансны дугаар | **** **** **** 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (Үйлчлүүлдэг ҮЦК-аас лавлах) |
| Үнийн дүн | ХБҮЦ үнэ + Шимтгэл |
| Гүйлгээний утга | "Бичил Эй Би Эс ТЗК" ХХК-ийн ХБҮЦ мөнгө, [Овог нэр, регистрийн дугаар] |

### Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн Үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллагын шимтгэл багтсан байна. Биржийн гишүүн Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг хөрөнгө оруулагч та бүхэн анхаарна уу.

**Албан татвар**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 21.2.4, 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна." гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нээлттэй хүрээнд биржийн зах зээлд гаргаж буй энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг эзэмшиж буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаад улсын иргэний хүүгийн орлогод 5 хувийн татвар ногдоно*. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн хувьд Монгол Улсын Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын дагуу ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 20 хувийн татвар төлөхөөр зохицуулагдсан байна.

** Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ*

**Валютын ханш**

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

## 6.8. АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дуусcанаас хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Үнэт цаас гаргагчийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг хийх болон Биржид үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны эрхийн бүртгэлийг хийх ба энэ талаар Хороо, Биржид мэдэгдэнэ. Бирж нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн ХБҮЦ-ны бүртгэлийг хийсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

# 7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

ДОЛОО

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

## 7.1. АНДЕРРАЙТЕР

### 7.1.1. АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА

**"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** | 2008.08.15 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011165033 |
| **Регистрийн дугаар:** | 5251494 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Брокер, андеррайтер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ; Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа, номинал данс эзэмших. |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Худалдаа, хөгжлийн банкны байр, 1401 тоот |
| **Утас:** | (976) 70100261, (976) 11 311914 |
| **Э-шуудан:** | info@tdbsecurities.mn |
| **Вэб хуудас:** | www.tdbsecurities.mn |

**"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК** нь анх "Ти Ди Би Капитал" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж, 2011 оноос эхлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй, зах зээлд тэргүүлэгч үнэт цаасны компаниудын нэг юм. Тус компани нь харилцагчдын хүсэл зорилгыг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүгийн шийдлийг мэргэжлийн дээд түвшинд хүргэсэн, үндэсний баялаг бүтээгчдийг дэмжигч, харилцагчдын найдвартай зөвлөх байхыг зорин ажиллаж байна.

Тус компани нь хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг харилцагчдадаа хүргэн, үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, хувьцаа, бонд, өрийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гарган санхүүжилт татах, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг. "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтран болон бие даан харилцагчдадаа нийт 3.6 тэрбум ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 2021 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 270 орчим тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг хийж гүйцэтгэжээ.

Өдрөөс өдөрт хөгжин өөрчлөгдөж буй дэлхийн санхүүгийн зах зээлийн орчинд харилцагчдынхаа хүсэл сонирхолд тулгуурласан өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж, Биржтэй шууд холболт хийгдсэн "Ти Ди Би Брокер" онлайн арилжааны системээ 2018 онд бүрэн шинэчилсэн билээ. Түүнчлэн, 2019 оноос эхлэн гадаад арилжааны үйл ажиллагаагаа эхлүүлж, гадаадын хөрөнгийн биржүүдээс хүссэн хувьцаа, бонд бусад төрлийн санхүүгийн хэрэгслийг худалдах авах боломжийг харилцагчдадаа нээсэн ба гадаад арилжааны хэмжээгээр зах зээлд тэргүүлэгчдийн нэг билээ.

Тус компани нь хөрөнгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн мэдлэг, боловсролыг дэмжих зорилгоор хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэг, арилжаанд оролцох болон үнэт цаас гаргахтай холбоотой интерактив хөтчүүдийг бэлтгэн олны хүртээл болгосноос гадна хөрөнгө оруулагчдыг мэдээлэл, судалгаатайгаар хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахад нь туслах зорилгоор хөрөнгийн зах зээлийн нэгдсэн статистик мэдээлэл, хувьцаат компаниудын тоон шинжилгээ болон долоо хоногийн зах зээлийн тойм цахим товхимлыг уламжлал болгон нийтэлж, харилцагчдаа зах зээлийн мэдээ мэдээллээр цаг алдалгүй ханган ажиллаж байна.

### 7.1.2. АНДЕРРАЙТЕРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Андеррайтерийн байгууллагын удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй байна.

**Хүснэгт 39: Андеррайтерийн байгууллагын удирдлагын багийн мэдээлэл**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
| <br>**С. Батчимэг**<br>Гүйцэтгэх захирал | **С.Батчимэг** нь СЭЗИС-ийг банк санхүү, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Их Британийн Вестминстерийн их сургуулийг хөрөнгө оруулалт, санхүүгийн эрсдэл чиглэлээр магистрын зэрэгтэй дүүргэж, London Stock Exchange Group Academy-д мэргэжил дээшлүүлжээ.<br><br>Тэрээр, Худалдаа, хөгжлийн банкинд 9 жил, Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК-д 11 жил ажиллаж байгаа бөгөөд корпорацийн санхүүжилт, байгууллагын зээл, уул уурхайн төслийн үнэлгээ судалгаа, өрийн болон хувьцааны санхүүжилт, төслийн удирдлага, хөрөнгө оруулалтын чиглэлээр арвин туршлагатай, мэргэшсэн үнэлгээчин. |
| <br>**Г. Энхбат**<br>Дэд захирал | **Д. Энхбат** нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг эдийн засаг, банкны чиглэлээр бакалаврын зэрэгтэй, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг санхүүч чиглэлээр мастерийн зэрэгтэй, Австрали улсын Гриффитийн Их Сургуулийг мөн санхүүч мэргэжлээр мастерийн зэрэгтэй дүүргэжээ.<br><br>Тэрээр, Худалдаа, хөгжлийн банкинд 13 жил ажилласан бөгөөд гадаад болон дотоодын хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалт, арилжааны чиглэлээр арвин туршлагатай билээ. |
| <br>**Д. Одмаа**<br>Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал | **Д.Одмаа** нь Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуулийг бакалаврын зэрэгтэй төгсөж, London Stock Exchange Group Academy-д мэргэжил дээшлүүлсэн бөгөөд Худалдаа, хөгжлийн банкинд 6 жил, Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК-д 11 дахь жилдээ ажиллаж байна. Тэрээр санхүүгийн шинжилгээ, төлөвлөлт, байгууллагын зээл, хөрөнгө оруулалтын шинжилгээ, судалгаа, төслийн үнэлгээний чиглэлээр арвин туршлагатай бөгөөд олон улсын зах зээлд гаргасан бондын төслүүдэд координатораар ажилласан туршлагатай, мэргэшсэн үнэлгээчин. |

СЭХ
он 2022 сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Б. Азжаргал**
Үнэт цаасны хэлтсийн захирал

**Б. Азжаргал** нь Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуулийг банкны эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлийн бакалавр зэрэгтэй төгссөн байна. Тэрээр Худалдаа, хөгжлийн банкинд 7 жил ажилласан ба Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК-д 5 дахь жилдээ ажиллаж байгаа ба гадаад болон дотоодын хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын чиглэлээр арвин туршлагатай билээ.

### 7.1.3. АНДЕРРАЙТЕРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч болон "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нар нь сонирхлын зөрчилгүй талууд бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн TDBS-345/2022, 22/457 дугаартай "Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ" болон 2022 оны 9-р сарын 28-ны өдрийн TDBS-386/2022, 22/501 дугаартай "Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээний нэмэлт гэрээ"-г байгуулсан байна.

Тус гэрээ нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх ба тус гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт цаас гаргах төслийн бэлтгэл ажлыг хангах, Үнэт цаас гаргагчаас шаардлагатай баримт бичгүүд, төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөгөө өгөх, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын боловсруулсан дүгнэлт, тайланд үндэслэн Үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, Үнэт цаасны танилцуулга, Андеррайтерийн мэдэгдэл, дүгнэлт болон Үнэт цаасны багц баримт бичгүүдийг боловсруулах андеррайтер, зуучлалын үйлчилгээг үзүүлэхээр тусгасан байна.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд нээлттэй хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төсөлд андеррайтер, зуучлалын үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай хууль тогтоомж, Эрх бүхий байгууллагын холбогдох дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулахаар харилцан тохиролцсон.

Түүнчлэн, Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтын дагуу хөрөнгө оруулагчид тухайн Үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхээр тус гэрээнд заажээ.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

## 7.2. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ

### 7.2.1. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

**"Онч-Аудит" ХХК**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** | ▪ 2006.06.28 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | ▪ 9018001003 |
| **Регистрийн дугаар:** | ▪ 2810743 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | ▪ Аудитын үйл ажиллагаа |
| **Хаяг:** | ▪ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ай Си Си цамхаг, 15 давхар |
| **Утас:** | ▪ (976) 7010 0450; (976) 7013 0450 |
| **Э-шуудан:** | ▪ www.onch.mn |
| **Вэб хуудас:** | ▪ info@onch.mn |

**"Онч Аудит" ХХК** нь дотоодын зах зээлийн тэргүүлэгч аудитын компаниудын нэг бөгөөд Хорооны 2013 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 53 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Тус компани нь 2012-2022 онд 175 гаруй жилийн түүхтэй, дэлхий даяар 150 гаруй улс оронд салбартай, дэлхийн хамгийн том дөрвөн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын нэг болох Деллоиттын сүлжээнд нэгдэж, Монгол дахь салбараар 10 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулсан байна. Энэ хугацаанд тус компани нь дотоодын аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж, туршлагаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ Хонг Конг, Австрали, Лондон, Сингапурын өрсөлдөөнт, шинэлэг, өндөр хөгжил бүхий зах зээл дэх бизнесүүдтэй хамтран ажиллаж олон улсын бизнесийн орчин, зах зээлийн арвин туршлага хуримтлуулжээ.

Түүнчлэн, Онч Аудит нь чанарын өндөр түвшин бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ суурь болсон мэргэжилтнүүдийнхээ боловсрол, өсөлт хөгжилд ихээхэн анхаарч ажилладаг ба Делойтт-ын Сингапур, Хонконг, Австрали, Их Британи дахь оффисуудад ажиллан, олон улсын туршлага хуримтлуулах боломжоор мэргэжилтнүүдээ хангаж ажилласан байна. Дэлхийн шилдэг аудитын компанийн ноу-хау-г үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, дотоодын болон олон улсын бизнес, хууль эрх зүйн орчинд ажилласан арвин туршлагатай мэргэжилтнүүд бүхий баг бүрэлдэхүүнтэй Онч Аудит ХХК нь үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлж, чанарын өндөр түвшний үйлчилгээг түргэн шуурхай, мэргэжлийн түвшинд харилцагч, аж ахуй нэгжүүдэд үзүүлсээр байна.

Тус компани нь Монголын Ипотекийн Корпорацийн 7 удаагийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон биржийн зах зээлд гарсан 10.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төсөлд ажилласан арвин таршлагатай билээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

### 7.2.2. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Зээлийн шинжилгээ гаргагчийн удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй байна.

**Хүснэгт 40: Зээлийн шинжилгээ гаргагчийн удирдлагын багийн мэдээлэл**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
|  **Д. Ончинсүрэн** Ерөнхий захирал Удирдах партнер | **Д. Ончинсүрэн** нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр 20 гаруй жил нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний салбарт ажилласан арвин туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч, татварын мэргэшсэн зөвлөх билээ. Д. Ончинсүрэн нь "Онч Аудит" ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар ерөнхий захирал, удирдах партнерын үүргийг гүйцэтгэж байна. |
|  **Ш. Норжинбат** Гүйцэтгэх захирал | **Ш. Норжинбат** нь Монгол Улсын Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй дүүргэсэн ба мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний салбарт 20 гаруй жилийн туршлага хуримтлуулжээ. Тэрээр "Онч Аудит" ХХК-ийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Гүйцэтгэх захирал бөгөөд зөвлөх үйлчилгээний партнерын үүргийг гүйцэтгэж байна. |
|  **Б. Анхтайван** Партнер | **Б. Анхтайван** нь Монгол Улсын Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй дүүргэжээ. Тэрээр "Онч Аудит" ХХК болон дэлхийн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг хамгийн том 5 компанийн нэг болох "Делоитт"-д 2008 оноос хойш ажиллах хугацаандаа дотоодын болон гадаадын жижиглэн, бөөний худалдаа, банк санхүү, барилга, хайгуул, уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл, дистрибютерийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудад аудит болон баталгаажуулалтын үйлчилгээг үзүүлж ажилласан байна. Тэрээр мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний салбарт 14 жил ажилласан арвин туршлагатай ба Делоиттийн Австрали дахь оффист 1 жилийн хугацаанд ажиллан олон улсын туршлага хуримтлуулжээ. Б. Энхтайван нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Аудит ба зөвлөх үйлчилгээ хариуцсан партнераар ажиллаж байна. |
|  **Б. Цэрэннадмид** Захирал | **Б. Цэрэннадмид** нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр менежментийн зөвлөх, эрсдэл, дотоод хяналт болон дотоод аудитын үйлчилгээг уул уурхай, хайгуул, жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гадаад болон дотоодын байгууллагуудад үзүүлж байсан туршлагатай.<br>Б. Цэрэннадмид нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний салбарт 14 жил ажилласан ба Делоиттийн Лондон дахь оффист 1 жилийн хугацаанд эрсдэл, дотоод хяналтын чиглэлээр ажиллан олон улсын туршлага хуримтлуулсан байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар |

СЗХ
2022 он .11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

тэрээр "Онч Аудит" ХХК-д Удирдлагын зөвлөх үйлчилгээ хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Б. Уранбилэг**
Захирал

**Б. Уранбилэг** нь Мандах Бүртгэл Дээд Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр банк санхүүгийн байгууллага, уул уурхай, үйлдвэрлэл болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдэд аудитын үйлчилгээ үзүүлж байсан арвин туршлагатай мэргэжилтэн билээ. Б. Уранбилэг нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний салбарт 14 жил ажилласан туршлагатай ба Делоиттийн Хонг Конг дахь оффист 1 жилийн хугацаанд банк санхүүгийн аудит чиглэлээр ажиллан олон улсын туршлага хуримтлуулсан байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тэрээр "Онч Аудит" ХХК-д татварын зөвлөх үйлчилгээ хариуцсан захирлын үүргийг гүйцэтгэж байна.



**Ж. Түвшин**
Захирал

**Ж. Түвшин** нь Отгонтэнгэр Их Сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй, Энэтхэг улсын Налсар Хуулийн Их Сургуулийг эрх зүйн магистрын зэрэгтэй төгссөн байна. Тэрээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, олон улсын татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжилтийн талаар зөвлөгөө өгөх чиглэлээр 14 жил ажилласан туршлагатай.
Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Ж. Түвшин нь "Онч Аудит" ХХК-д татварын зөвлөх үйлчилгээ хариуцсан захирлын үүргийг гүйцэтгэж байна.

### 7.2.3. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагчтай 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр зээлийн шинжилгээ гаргах тухай "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээ", 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр тус гэрээний Нэмэлт гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд, Аудитын байгууллага нь Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахаар төлөвлөж буй зээлийн хөрөнгүүдийн хувийн хэргийг харилцан тохиролсон ажил үйлчилгээний дагуу хянаж, харилцан тохиролсон ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэн тайлагнах ба тус үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон Олон улсын стандарт 4400 "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ"-д нийцүүлэн ажиллахаар заасан байна.

Аудитор нь тус гэрээ болон түүний хавсралтуудад заасан ажилт үүргийг Монгол Улсын болон олон улсын холбогох хууль тогтоомж стандартад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд хийж, гүйцэтгэх, гаргасан тайлангийн хүрээнд 3 жилийн хугацаанд Үнэт цаас гаргагч болон бусад гуравдагч этгээд, зохицуулагч байгууллагын өмнө тайлбар гаргах үүрэгтэй байхаар тусгасан.

Тус гэрээний дагуу, Зээлийн шинжилгээ гаргагч нь Үнэт цаас гаргагчийн тавьсан шаардлагын дагуу итгэлцлийн түвшин 95 хувь, хүлээгдэж буй алдаа 5 хувь, зөвшөөрөгдөх алдааны дээд хязгаар 10 хувь байхаар санамсаргүйгээр 119 автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг түүвэрлэн сонгож, шинжилгээ хийсэн байна.

## 7.3. ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

### 7.3.1. ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| DB&GTS | **Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН** |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** | 2019.01.15 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9022003045 |
| **Регистрийн дугаар:** | 6387942 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 7-р давхар |
| **Утас:** | (976) 9911 0961; (976) 9907 5047 |
| **Э-шуудан:** | info@dblaw.mn |
| **Вэб хуудас:** | www.dblaw.mn |

**Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН** нь анх "Жи Ти Эс Адвокатс" ХХН нэрээр үүсгэн байгуулагдаж байсан байна. Тус хуулийн фирм нь 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын анхны хувийн хуулийн фирмүүдийн нэг бөгөөд 2019 онд шинэчлэгдэн зохион байгуулагдсан билээ. Нөхөрлөлийн бүрэлдэхүүнд Монгол Улсад болон гадаадын олон оронд хууль, эрх зүйн анхан болон ахисан шатны боловсрол, мэдлэг эзэмшсэн хуульчид мэргэжлийн өндөр түвшинд ажиллан, хууль эрх зүйн зөвлөгөөг үзүүлэх чадвартай хуульч, эрх зүйчид ажилладаг томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд олон жилийн туршид хуримтлуулсан туршлага болон ноу-хау-ийг хуваалцан дараа үеийн хуульчдыг бэлтгэн ажиллаж байна. "Ди Би энд Жи Ти Эс" ХХН нь банк санхүү, хөрөнгийн зах зээл, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, олон улсын санхүү болон худалдаа, барилга байгууламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, компани нэгдэн, нийлэх болон худалдан авах, маргаан шийдвэрлэх, хөдөлмөр, оюуны өмч болон татварын төлөвлөлт зэрэг чухал салбаруудыг хамарсан хууль зүйн зөвлөгөөний цогц үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн, 2007 оноос Монгол Улсын болон Сингапур, Хонг Конг, Торонто, Лондонгийн хөрөнгийн биржүүдэд анхлан болон нэмж хувьцаа гаргах, өрийн бичиг гаргах арилжааны банк болон уул уурхайн томоохон компаниудын хэлцэл дээр хуулийн зөвлөхөөр тасралтгүй ажиллаж ирсэн туршлагатай. Тус хуулийн фирм нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12-р сарын 04-ний өдөр 336 тоот тогтоолын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх хэсэгт заасан Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн байна.

СЗХ
2022 11 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 7.3.2. ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллагын удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй байна.

**Хүснэгт 41: Хуулийн фирмийн удирдлагын багийн мэдээлэл**

| Нэр, албан тушаал | Мэдээлэл |
|---|---|
| <br>**Д. Золжаргал**<br>Гүйцэтгэх захирал | **Д. Золжаргал** нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйн бакалаврын зэрэгтэй, АНУ-ын Оклахома хотын Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, АНУ-ын Харвардын Их сургуулийг Хууль зүйн магистрын зэрэгтэй тус тус дүүргэжээ.<br><br>Тэрээр Монголын томоохон арилжааны банкинд хуулийн зөвлөхөөр 7 жил, үнэт цаасны зах зээлийн гэрээ хэлцэлд 15 жил тасралтгүй зөвлөж ирсэн туршлагатай, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн бөгөөд шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгч билээ.<br><br>Д. Золжаргал нь Chambers and Partners Asia Pacific-аас Бизнесийн салбарын тэргүүлэх хуульч, The Legal500-ийн тэргүүлэх хуульчаар шалгарсан байна. |
| <br>**Б. Баттүшиг**<br>Нөхөрлөлийн гишүүн | **Б. Баттүшиг нь** АНУ-ын Дикинсон Мужийн Их сургуульд Түүх, улс төрийн ухааны бакалавр зэрэгтэй төгсөж, АНУ-ын Кэнт-Чигаго Хуулийн сургуулийн “Хууль, эрх зүйн бакалаврын (J.D)” эрдмийн зэргийг хүртсэн байна.<br><br>Тэрээр АНУ-ын Иллиной мужын Барын холбооны гишүүн, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч бөгөөд Монгол Улсад хэрэгжүүлсэн өрийн баталгаа гаргах, үнэт цаас, банк, эрчим хүч, дэд бүтцийн салбарын гэрээ, хэлцэл болон Монгол Улсын Мянганы сорилтын санд ажиллаж байсан туршлагатай билээ. |
| <br>**Н. Мэнд-Амар**<br>Нөхөрлөлийн гишүүн | **Н. Мэнд-Амар** нь Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг Олон улсын эрх зүйн бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна. Тэрээр 2012 оноос хойш тасралтгүй өмгөөлөл, хууль зүйн салбарт ажиллаж байгаа бөгөөд уул уурхай, ашигт малтмал, газар, компани, хөдөлмөрийн эрх зүй, хөрөнгийн зах зээл, болон оюуны өмчтэй холбоотой эрх зүйн салбарт мэргэшсэн, гэрээ хэлцэл, хөдөлмөрийн харилцаа, гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой иргэний болон захиргааны хэрэг маргаанд үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж өмгөөлөгчөөр ажилладаг туршлагатай мэргэжилтэн юм.<br><br>Тэрээр Монгол хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуульч. |

СЗХ
2022 . 11 . 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 7.3.3. ХУУЛИЙН ЗӨВЛӨХТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байх бөгөөд тус гэрээгээр Үнэт цаас гаргагчийн зүгээс хөрөнгөөр батлагаажсан үнэт цаас гаргах хэлцэлд Хуулийн зөвлөхөөс Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн холбогдох заавах, дүрэм, журмын хүрээнд хууль зүйн зөвлөгөө буюу үйлчилгээг үзүүлэхээр тусгажээ.

Мөн тус гэрээний хүрээнд Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгосон нийт зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн данснуудад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн баталсан хуулийн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хуулийн дүгнэлт гаргахаар харилцан тохиролцсон байна.

Түүнчлэн, Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчтай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн түнш, харилцагчидтай холбоотой аливаа сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллах тухай тус гэрээнд тусгажээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9011110883
5251494

СЗХ
2022.11.09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

| Үнэт цаас гаргагч: | Андеррайтер: |
| --- | --- |
| **“Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК** | **“Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК** |
| Bichil ABS active | TDB SECURITIES |
| Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 705 тоот | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Худалдаа Хөгжлийн банкны төв байр |
| | (976) 7010 0261<br>(976) 11 311914 |
| www.bichil.abs.mn | info@tdbsecurities.mn<br>www.tdbsecurities.mn |
| **ТУЗ-ИЙН ДАРГА**<br>**Ц. АЗБАЯР** | **ДЭД ЗАХИРАЛ**<br>**Г. ЭНХБАТ** |
| **ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН**<br>**Б. БААСАНДОРЖ** | |
| **ТУЗ-ИЙН ГИШҮҮН**<br>**С. ОТГОНБАТ** | |

# ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

# Сонгогдсон зээлүүдэд гүйцэтгэсэн харилцан тохиролцсон ажил үйлчилгээний

## үр дүнгийн тайлан

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
онц сар өдөр
Б

Onch& Company

# ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**Бичил Глобус Финанс ББСБ ХХК-д,**

Бид харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу 2022 оны 5 сарын 15-ны (цаашид "тасалбар болгосон өдөр" гэх) байдлаарх Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн (цаашид "анхны үүрэг гүйцэтгүүлэгч" гэх) олгосон зээлүүдээс Хавсралт А-д заасан шалгууруудын дагуу сонгосон 119 зээлд хийсэн шалгалтын үр дүнг дор тайлагналаа. Бидний гүйцэтгэсэн ажил нь Хамааралтай Ажил Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400 'Харилцан Тохиролцсон Ажил Үйлчилгээ'-ний дагуу хийгдсэн болно. Бидний гүйцэтгэсэн процедурууд нь зөвхөн сонгогдсон зээлүүд нь Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн удирдлагаас тодорхойлсон дараах санхүүгийн шалгууруудыг хангаж байгаа эсэхийг үнэлэхэд та бүхэнд туслах зорилготойгоор хийгдсэн бөгөөд гүйцэтгэсэн процедуруудыг хураангуйлан үзүүлбэл доорхи байдалтай байна.

Доорхи гүйцэтгэсэн ажлууд болон үр дүн нь зөвхөн зээлийн хувийн хэрэгт хавсаргасан баримтууд дээр үндэслэсэн болно.

**Зээлийн файлуудыг шалгахад хийж гүйцэтгэсэн ажлууд**

*I. Зээлийн хөрөнгийн хувьд:*

1. Зээлийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 17-ны өдрийн 21/04А/68 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаандаа баримталдаг ерөнхий стандартаас дутуугүй шалгууруудыг хангасан, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан болохыг тодорхойлохын тулд бид зээлийн хувийн хэргүүдийг шалгасан.

2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөр, холбогдох хураамж, шимтгэл, төлбөрийг төлсөн эсэхийг шалгахдаа урьдчилгаа төлсөн банкны гүйлгээний баримтыг шалгасан.

3. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл болохыг тодорхойлохын тулд бид зээлийн гэрээ (цаашид "ЗГ" гэх)-г болон зээлийн дансны хуулгыг шалгасан.

4. Зээлийн санхүүжилтийн дүн нь бүрэн олгогдсон эсэхийг зээлийн санхүүжилт олгох үеийн анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн банкны харилцах дансны хуулга болон зээлдэгчийн зээлийн дансны хуулгыг шалгасан.

5. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээл нь зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусах эсэхийг тодорхойлохын тулд ЗГ-нд тусгагдсан сар бүрийн эргэн төлөлтийн хуваарийг шалгасан.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК

6. Зээл нь тасалбар болгосон өдрийн байдлаар хэвийн төлөлттэй бөгөөд сар бүрийн төлбөр ЗГ-нд тусгагдсан төлбөрийн хуваарийн дагуу бүрэн төлөгдөж байгааг тодорхойлохын тулд зээлийн дансны хуулга болон ЗГ-г шалгасан.

7. Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй гэдгийг тодорхойлохын тулд бид Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн "Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Бичил Эй Би Эс Актив ХХК-д өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй өр төлбөрийн үүрэггүй" гэсэн 2022 оны 8 сарын 23-ны 04/610 тоот албан бичгийг шалгасан.

8. Зээлийн хүүний хэмжээ сарын 2.3%-иас багагүй, тогтмол төлөгдөх нөхцөлтэй эсэхийг тодорхойлохын тулд бид ЗГ-г шалгасан.

9. Тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн үлдэгдэл хугацаа 20 сараас доошгүй байгаа эсэхийг ЗГ-ний эргэн төлөлтийн хуваариас шалгасан.

10. Үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа өдрийн байдлаар зээлийн үлдсэн хугацаа нь зээлийн нийт хугацааны 55%-иас доошгүй байгаа эсэхийг ЗГ-ний эргэн төлөлтийн хуваариас шалгасан бөгөөд үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа хугацааг 2022 оны 10 дугаар сарын 31-нээр тооцсон.

11. Тасалбар болгосон өдрөөрх жигнэсэн дундаж зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь 70%-иас хэтрээгүй, тухайлсан зээлийн хувьд зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь 75%-иас хэтрээгүй болохыг тодорхойлохын тулд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бэлтгэсэн үнэлгээний хуудас, шинэ автомашин худалдан авах зээлийн хувьд худалдах, худалдан авах гэрээ болон ЗГ-г шалгасан.

    *Жич:* ЗҮХ-г Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тодорхойлсон доорх томъёоны дагуу бодсон болно;

$$\text{ЗҮХ} = \frac{\text{Тасалбар болгосон өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн хэмжээ}}{\text{Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ} + \text{Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ}} \leq 75\%$$

12. Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд бид зээлийн хувийн хэргийн мэдээллийг зээлийн багцын мэдээлэлтэй тулгасан.

II. *Зээлдэгчийн хувьд*

1. Монгол Улсад оршин суудаг Монгол Улсын иргэн эсэхийг шалгахдаа зээлдэгчийн иргэний үнэмлэхний хуулбар болон оршин суугаа хаягийн тодорхойлолтыг шалгасан.

2. Эрх зүйн чадамжтай, 18-аас дээш настай эсэхийг тодорхойлохын тулд зээлдэгчийн иргэний үнэмлэхний хуулбарыг шалгасан.

3. Зээл олгосон өдрийн байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн албан хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн болохыг тодорхойлохын тулд дансны хуулга, хар дэвтэр, түрээсийн гэрээ, хамтын ажиллагааны гэрээ, нийгмийн даатгалын дэвтэр эсвэл Хур систем болон ТҮЦ машины лавлагаа зэргийг шалгасан.

Харилцагч нь бизнесийн орлоготой бол багадаа сүүлийн 6 сарын дансны хуулга, цалингийн орлоготой тохиолдолд ХУР системийн нийгмийн даатгалын мэдээллээр орлогыг баталгаажуулсан.

4. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) 55%-иас хэтрээгүй болохыг тодорхойлохын тулд зээлийн хувийн хэрэгт хавсаргасан ЗГ болон зээлдэгчийн гаргаж өгсөн орлого болон зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг шалгасан.

   Жич: ӨОХ-г Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тодорхойлсон доорх томъёоны дагуу бодсон болно.

$$\text{ӨОХ} = \frac{\text{Зээлийн сарын төлбөр} + \text{Бусад зээлийн сарын төлбөр}}{\text{Өрхийн сарын орлого (татвараас өмнөх)}} \leq 55\%$$

III. *Барьцаа хөрөнгийн хувьд*

1. Үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан байх, уг барьцаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байгаа эсэхийг тодорхойлохын тулд бид ЗГ болон барьцааны гэрээг шалгасан.

2. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой эсэхийг тодорхойлохын тулд ЗГ болон барьцааны гэрээг шалгасан.

3. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх гэсэн шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд ЗГ болон барьцааны гэрээг шалгасан.

4. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, үндсэн үүрэг гүйцэтгэгчийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн хувьд тээврийн хэрэгслийн даатгал хүчинтэй эсэхийг тодорхойлохын тулд гэрээт баталгааг хамгийн багадаа 2022 оны 5 дугаар сарын 15-ныг дуустал хүчинтэй эсэхийг шалгасан.

5. Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тогтоосон шалгуур (Фидуцийн зүйлийн үйлдвэрлэсэн он нь 2000 оноос хойш, импортолсон он нь 2010 оноос хойш, Япон болон Солонгос улсад үйлдвэрлэгдсэн суудлын тэрэг, 1,5 тонноос ихгүй ачааны тэрэг болох)-ыг тодорхойлохын тулд авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбарыг шалгасан.

*IV.Зээлийн багцын хувьд*

1. Тасалбар болгосон өдрөөрх олгосон зээлийн жигнэсэн дундаж хэмжээ 20 сая төгрөгөөс ихгүй байгааг тодорхойлохын тулд бид нийт зээлийн багцын хувьд тооцооллыг дахин тооцоолж шалгасан.
2. Жигнэсэн дундаж зээлийн хүүний хэмжээ сарын 2.8%-иас багагүй байгааг тодорхойлохын тулд бид нийт зээлийн багцын хувьд тооцооллыг дахин тооцоолж шалгасан.
3. Тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 30 сараас доошгүй байгааг тодорхойлохын тулд бид нийт зээлийн багцын хувьд тооцооллыг дахин тооцоолж шалгасан.

**Үр Дүн**

Ажлын үр дүнг тайлагнавал:

Дээр жагсаасан процедуруудын үр дүнг дэлгэрэнгүйгээр Хавсралт Б-д харуулав.

I. *Зээлийн хөрөнгийн хувьд:*

а) Нэгдүгээр шаардлагын хувьд, зээлийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 5-р сарын 17-ны өдрийн 21/04А/68 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаандаа баримталдаг ерөнхий стандартаас дутуугүй шалгууруудыг хангасан байсан.

б) Хоёрдугаар шаардлагын хувьд, зээлдэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөрийг төлсөн байсан. Гүйцэтгэх захирлын 2020 оны 3 сарын 10-ны өдрийн 20/04а/22 тоот тушаалын дагуу Ковид-19 цар тахлын дэгдэлтээс үүдэн зээлдэгчийн ашиг орлого буурсантай холбогдуулан зээлийн үйл ажиллагаанаас авч буй шимтгэл, хураамжийг 0 /тэг/ болгон түр хугацаанд зогсоосон ба нийт шалгасан 119 зээлдэгчээс 89 зээлдэгч зээлийн үйл ажиллагааны шимтгэл хураамжаас чөлөөлөгдөж, 30 зээлдэгч зээлийн үйл ажиллагааны шимтгэл хураамжийг төлсөн байсан.

в) Гуравдугаар шаардлагын хувьд, зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх хуваарьтай байсан.

г) Дөрөвдүгээр шаардлагын хувьд, зээлийн санхүүжилтийн дүн нь бүрэн олгогдсон байсан.

д) Тавдугаар шаардлагын хувьд, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг тусгасан, зээл нь зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар тусгасан байсан.

е) Зургаадугаар шаардлагын хувьд, зээл нь шинжилгээ хийх өдрийн байдлаар хэвийн төлөлттэй байсан.

ё) Долоодугаар шаардлагын хувьд, тасалбар болгох өдрийн байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байсан.

ж) Наймдугаар шаардлагын хувьд, зээлийн хүүний хэмжээ сарын 2.3%-иас багагүй, тогтмол төлөгдөх нөхцөлтэй байсан.

з) Есдүгээр шаардлагын хувьд, тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн үлдэгдэл хугацаа 20 сараас доошгүй байсан.

и) Аравдугаар шаардлагын хувьд, дараах 5 зээлээс бусад зээлийн хувьд үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа өдрийн байдлаар зээлийн үлдсэн хугацаа нь зээлийн нийт хугацааны 55%-иас доошгүй байна.

| Зээлийн дансны дугаар | Зээлийн үлдсэн хугацааны зээлийн нийт хугацаанд эзлэх хувь | Салбар |
|---|---|---|
| 2100130110002415 | 52% | ПРОВАН |
| 2100130110002489 | 53% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110002557 | 53% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110002662 | 54% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110002673 | 54% | МОСКВА |

й) Арваннэгдүгээр шаардлагын хувьд, тасалбар болгосон өдрийн байдлаар жигнэсэн дундаж зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь 70%-иас хэтрээгүй, сонгогдсон зээлүүдийн зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-иас хэтрээгүй байсан.

к) Арванхоёр дугаар шаардлагын хувьд, зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байсан.

*II. Зээлдэгчийн хувьд:*

а) Нэгдүгээр шаардлагын хувьд, зээлдэгчид нь монгол Улсад оршин суудаг Монгол Улсын иргэн байсан.

б) Хоёрдугаар шаардлагын хувьд, зээлдэгчид нь эрх зүйн чадамжтай, 18-аас дээш настай байсан.

в) Гуравдугаар шаардлагын хувьд, зээл олгосон өдрийн байдлаар дараах 1 зээлдэгчээс бусад үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажилласан ба хувиараа хөдөлмөр эрхэлдэг үүрэг гүйцэтгэгч нь сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байсан.

| Зээлийн дансны дугаар | Салбар |
|---|---|
| 2100130110004756 | ТӨМӨР ЗАМ |

г) Дөрөвдүгээр шаардлагын хувьд, тасалбар болгосон өдрийн байдлаар дараах 11 зээлдэгчээс бусад зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) 55%-с хэтрээгүй байсан.

| Зээлийн дансны дугаар | ӨОХ | Салбар |
|---|---|---|
| 2100130110004394 | 80% | МОСКВА |
| 2100130110003768 | 58% | МОСКВА |
| 2100130110003316 | 88% | ДА ХҮРЭЭ |
| 2100130110004756 | 121% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110002735 | 87% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110004500 | 62% | ТӨМӨР ЗАМ |
| 2100130110004672 | 147% | АВТО ХУДАЛДАА 22 |
| 2100130110002966 | 126% | АВТО ХУДАЛДАА 22 |
| 2100130110004175 | 68% | ДӨЧИН МЯНГАТ |
| 2100130110004724 | 64% | ДОРНОД |
| 2100130110002884 | 63% | ЖОБИ 72 |

III. *Барьцаа хөрөнгийн хувьд*

а) Нэгдүгээр шаардлагын хувьд, үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан, уг барьцаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байсан.

б) Хоёрдугаар шаардлагын хувьд, зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байдлаар гэрээнд тусгасан байсан.

в) Гуравдугаар шаардлагын хувьд, фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх талаар гэрээнд тусгасан байсан.

г) Дөрөвдүгээр шаардлагын хувьд, үндсэн үүрэг гүйцэтгэгчид нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал хийлгэсэн бөгөөд шинжилгээ хийх өдрийн байдлаар даатгалын гэрээ нь хүчин төгөлдөр байсан.

д) Тавдугаар шаардлагын хувьд, фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тогтоосон шалгуурыг хангасан байсан.

IV. *Зээлийн багцын хувьд*

а) Нэгдүгээр шаардлагын хувьд, тасалбар болгосон өдрөөрх олгосон зээлийн жигнэсэн дундаж хэмжээ 20 сая төгрөгөөс ихгүй байсан.

б) Хоёрдугаар шаардлагын хувьд, жигнэсэн дундаж зээлийн хүүний хэмжээ сарын 2.8%-иас багагүй байсан.

л) Гуравдугаар шаардлагын хувьд, тасалбар болгосон өдрөөрх нийт зээлийн жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 30 сараас доош байсан.

Бид та бүхэнтэй харилцан тохиролцон гүйцэтгэсэн процедурууд нь ажил үйлчилгээний хангалттай байдлын талаар ямар нэгэн мэдэгдэл гаргахгүй. Цаашлаад бид зөвхөн энэхүү тайлангийн үр дүнг тайлагнасан бөгөөд бид ямар нэгэн материаллаг зөрчил илрээгүй байх магадлалын талаар мэдэгдэл гаргахгүй.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүү болон нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг эрхэлсэн захирлууд болон удирдлага нь зээлүүдийн жагсаалт болон өгсөн мастер файлын мэдээллүүд нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүртгэл дэх дүнгүүдээс бэлтгэгдсэн болохыг бидэнд мэдэгдсэн.

Бидний гүйцэтгэсэн ажил нь Аудитын Олон Улсын Стандарт болон Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандартын дагуу аудит эсвэл хянах үйл ажиллагаанд тус тус хамаарахгүй тул бид сонгогдсон зээлүүдэд гүйцэтгэсэн процедуруудад аливаа баталгаа гаргахгүй болно.

Хэрэв бид нэмэлт процедур гүйцэтгэсэн эсвэл Аудитын Олон Улсын Стандарт эсвэл Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандартын дагуу зээлүүдэд аудит эсвэл хяналт хийсэн бол та бүхэнд тайлагнах өөр асуудлууд илэрч болох байсныг анхаарна уу.

Энэхүү тайлан нь зөвхөн дээр сонгогдсон зээлүүдтэй холбоотой ба анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн олгосон нийт зээлүүдтэй холбоогүй болно.

Шагдарсүрэнгийн Норжинбат
Гүйцэтгэх захирал
Онч Аудит ХХК
2022 оны 9-р сарын 27

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

Хавсралт А

**Түүвэр сонголт**

Бид нийт 708 зээлээс итгэлцлийн түвшин 95%, байж болох хамгийн их алдаа 10% (ББХИА), хүлээгдэж буй алдаа 5% гэсэн үзүүлэлтүүдийг авч үзсэний үр дүнд түүврийн хэмжээ болох 119 зээлийн тоог тодорхойлсон.

| | Итгэлцлийн түвшин 95% | | |
|---|---|---|---|
| | ББХИА 10% | ББХИА 15% | ББХИА 20% |
| Түүврийн хэмжээ | 119 | 52 | 32 |
| Алдааны дээд хэмжээ | 6 | 3 | 2 |

Зээлүүдийг сонгоход дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзсэн:

***Шалгуур үзүүлэлт – 1****:* Салбар бүрээс багадаа хоёр зээл хамрагдсан байх;

***Шалгуур үзүүлэлт – 2****:* Зээлийн үлдэгдлийн хэмжээг харгалзахгүй бөгөөд сонголтоос хамааран хөдөө орон нутагт олгосон түүвэрт сонгогдох боломжгүй тохиолдолд хамгийн их үлдэгдэлтэй зээлээс эхлэн сонгох;

***Шалгуур үзүүлэлт – 3****:* Түүврээр сонгогдсон зээлийн хөрөнгийн багц нь, Улаанбаатар хот болон орон нутагт олгогдсон зээлийн тоо нь нийт багцын бүтэцтэй ойролцоо байх;

***Шалгуур үзүүлэлт – 4****:* Зээл Үнэлгээний Харьцаа (ЗҮХ) өндөр зээлийн дансдыг түүвэрт аль болох ихээр хамруулах (75%-тай ойролцоо байх);

***Шалгуур үзүүлэлт – 5****:* Өр Орлогын Харьцаа (ӨОХ) өндөр зээлийн дансдыг түүвэрт аль болох ихээр хамруулах (55%-тай ойролцоо байх);

СЗХ
Onch& Company
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**Хавсралт Б**

**Зээлийн хувийн хэргүүдэд гүйцэтгэсэн ажлын хураангуй (I-III дугаар процедурууд)**

**Процедуруудын Хүснэгтчилсэн Хураангуй**

| № | Зээлийн дансны дугаар | I. Зээлийн хөрөнгийн хуьд | | | | | | | | | | | | II. Зээлдэгчийн хувьд | | | | III. Барьцаа хөрөнгийн хувьд | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 1 | 2 | 3 | 4 | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 61 | 2100130110004662 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 62 | 2100130110004784 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 63 | 2100130110002764 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 64 | 2100130110002972 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 65 | 2100130110003283 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 66 | 2100130110003962 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 67 | 2100130110004381 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 68 | 2100130110004408 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 69 | 2100130110004497 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 70 | 2100130110004673 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 71 | 2100130110003316 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 72 | 2100130110003629 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 73 | 2100130110003799 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 74 | 2100130110004373 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 75 | 2100130110004325 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 76 | 2100130110004278 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 77 | 2100130110004245 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 78 | 2100130110004771 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 79 | 2100130110004066 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 80 | 2100130110003993 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 81 | 2100130110002966 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 82 | 2100130110003057 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 83 | 2100130110004020 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 84 | 2100130110003463 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 85 | 2100130110003741 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 86 | 2100130110004672 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 87 | 2100130110004150 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 88 | 2100130110003527 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 89 | 2100130110004612 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 90 | 2100130110004693 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 91 | 2100130110004499 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 92 | 2100130110003431 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 93 | 2100130110003054 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 94 | 2100130110002817 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 95 | 2100130110004217 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 96 | 2100130110004248 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 97 | 2100130110004243 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 98 | 2100130110004724 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 99 | 2100130110004530 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 100 | 2100130110003954 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 101 | 2100130110003410 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 102 | 2100130110004536 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 103 | 2100130110004246 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 104 | 2100130110004018 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 105 | 2100130110002884 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 106 | 2100130110003720 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 107 | 2100130110004138 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 108 | 2100130110004413 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 109 | 2100130110004175 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 110 | 2100130110004021 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 111 | 2100130110003782 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 112 | 2100130110004076 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 113 | 2100130110002889 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 114 | 2100130110004361 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 115 | 2100130110004112 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 116 | 2100130110003841 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 117 | 2100130110004651 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 118 | 2100130110002977 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 119 | 2100130110004567 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |

СЗХ
он сар өдөр
2022 11 0?
БҮРТГЭВ
№ 01

DB&GTS

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

2022.09.28 № 01/342

**Хэнд:** "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК

**Хэнээс:** Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН

**Огноо:** 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр

**Утга:** Хуулийн дүгнэлт

**Нэг. Оршил**

А. Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 336 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх хэсэгт заасан Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн билээ.

Б. Монгол Улсын хуулийн этгээд болох "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК (цаашид "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга болон түүний дагалдах эрхүүдийг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК ("**Анхны үүрэг гүйцэтгүүлэгч**" эсвэл "**Үүсгэн байгуулагч**")-аас худалдан авч, тухайн худалдан авсан автомашины зээлийн хөрөнгө болон түүний дагалдах эрхүүдээр баталгаажсан үнэт цаас ("**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас**") гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" эсвэл "**Хороо**" гэх)-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолын Хавсралтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.4 дэх заалт (цаашид "**СЗХ-ны Бүртгэлийн Журам**" гэх), Монголын Хөрөнгийн бирж ТӨХК ("**Хөрөнгийн Бирж**")-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2020/06 тоот тогтоолын Хавсралтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" (цаашид "**Хөрөнгийн Биржийн Бүртгэлийн Журам**" гэх)-ын 2.5.5 дах хэсэгт заасныг удирдлага болгон "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-аас автомашины зээлийн хөрөнгө болон түүний дагалдах эрхүүдээр баталгаажсан үнэт цаас гарган нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулга болон эрх бүхий зохицуулах байгууллагуудын холбогдох дүрэм, журмын хүрээнд тодорхойлогдсон, хуулийн дүгнэлтэд тусгагдах мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн баримт бичигт хууль зүйн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргаж байна.

**Хоёр. Хуулийн дүгнэлтийн хамрах хүрээ**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Бүртгэлийн Журмын 10.4 дэх заалт, Хөрөнгийн Биржийн Бүртгэлийн Журам 2.5.5 дах хэсэгт тус тус заасны дагуу энэхүү Хуулийн дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд гаргаж байна болно. Үүнд:

Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН
Утас: +976 1133 1020, Факс: +976 7011 5060 И-мэйл: info@dblaw.mn www.dblaw.mn
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул Дүүрэг, 15-р хороо Чингисийн өргөн чөлөө - 33/2, Режис Плэйс Тауэрын 903 тоот

TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

(1) Тусгай зориулалтын компани ("**ТЗК**")-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх;

(2) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;

(3) ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;

(4) Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл, холбогдох этгээдүүдтэй байгуулсан гэрээ, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;

(5) Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;

(6) Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;

(7) Хөрөнгийн багцаас түүврийн аргаар сонгосон хөрөнгийн багц нь үнэт цаас гаргагчийн тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх;

(8) Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд, үүргийг гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх.

Бид энэхүү Хуулийн дүгнэлтэд дээр дурдсанаас гадна Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах хөрөнгө оруулагчид мэдвэл зохих зарим асуудлуудыг сайн дурын үндсэн дээр нэмж тусгасан болно. Үүнд:

(9) ТЗК-ийг Үүсгэн байгуулагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;

(10) Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага хангаж байгаа эсэх;

(11) Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй үнэт цаас, бусад хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус эд хөрөнгөд аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээсэн эсэх;

(12) Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;

(13) Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.

Бид энэхүү Хуулийн дүгнэлтээ гагцхүү хуулийн дүн шинжилгээ хийх хугацаанд бидэнд ил болсон, Анхны үүрэг гүйцэгүүлэгч болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллүүд болон төрийн зарим эрх бүхий байгууллагуудаас авсан лавлагаа, тодорхойлолт дээр үндэслэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн өнөөгийн байдлыг хууль зүйн үүднээс нь шинжлэн судалж, боловсруулсан мэдээллийг тусгасан болохыг анхаарна уу.



TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

Энэхүү Хуулийн дүгнэлтэд хэрэглэсэн нэр томъёоны тайлбарыг ***Хавсралт 1***-т тодорхойлсон болно.

**Хуулийн дүгнэлтийг хэрэглэх хүрээ**

(а) Энэхүү Хуулийн дүгнэлтийг зөвхөн автомашины зээлийн хөрөнгө болон түүний дагалдах эрхүүдээр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд зориулж бэлтгэсэн бөгөөд бидний урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Хуулийн дүгнэлтийг:

(i) аливаа бусад этгээд (Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, андеррайтер, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК, Санхүүгийн Зохицуулах Хорооноос бусад) ашиглах, эшлэл авах, бусад баримт бичигт оролцуулан дурдах, хувилахыг хориглоно;

(ii) бусад этгээдэд задруулахгүй, гэхдээ Үнэт цаас гаргагчийн ердийн бизнесийн үйл ажиллагааны явцад түүний баримт бичиг, бүртгэлтэй танилцах эрхтэй этгээдүүд цааш нь задруулахгүй байх нөхцөлтэйгөөр танилцаж болно;

(iii) засгийн газрын болон бусад төрийн байгууллага, агентлагуудад задруулахгүй, мөн олон нийтэд түгээж буй баримт бичигт аливаа хэлбэрээр иш татахгүй, дурдахгүй.

(б) Энэхүү Хуулийн дүгнэлт нь зөвхөн түүнд тусгагдсан асуудлуудаар хязгаарлагдах бөгөөд Хуулийн дүгнэлтэд тусгагдаагүй асуудлуудад хамаарахгүй. Хуулийн дүгнэлт нь түүнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийхэд шууд оролцсон өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН-ийн хуульчдын шинжлэн судалсан зүйлсийг агуулсан бөгөөд зөвхөн түүнд тусгагдсан мэдээллээр хязгаарлагдана.

(в) Энэхүү Хуулийн дүгнэлтийг бид холбогдох дүрэм, журмын шаардлагын хүрээнд гаргаж байгаа бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагааны хүрээнээс хамаарахгүй аливаа бусад хуулийн асуудлаар хөрөнгө оруулагчид өөрийн хуульч, хуулийн зөвлөхтэй зөвлөлдвөл зохино.

(г) Энэхүү Хуулийн дүгнэлтээр баримт бичгүүдийн эсхүл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой байж болох бүх хуулийн асуудлуудыг дэлгэрэнгүй судлан шинжлэх зорилго агуулаагүй бөгөөд зөвхөн Хуулийн дүгнэлтийн хамрах хүрээнд дурдсан гол асуудлуудыг тусгах зорилго агуулсан.

(д) Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН нь татвар, санхүү, хөрөнгийн үнэлгээний талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд биш болно.

(е) Бид татвар, хөрөнгийн үнэлгээ, санхүүгийн, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн этгээд биш тул эдгээр асуудлуудыг энэхүү Хуулийн дүгнэлтэд аливаа байдлаар дурдсан бол үүнийг зөвхөн хууль зүйн асуудлыг судлан шинжлэх явцад тэмдэглэх байдлаар Хуулийн дүгнэлтэд дурдсан гэж ойлгох бөгөөд санхүүгийн, нягтлан бодох бүртгэлийн асуудлаар зөвлөсөн эсхүл дүгнэлт хийсэн гэж үзэхгүй. Тодруулбал, холбогдох хөрөнгийн багцад тавигдах аливаа санхүүгийн шалгуур, тэдгээрийн үнэлгээг "Онч Аудит" ХХК хариуцан хийж, 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр "Үр дүнгийн тайлан"-г гаргасан бөгөөд бид гагцхүү тус тайланд найдсан болно. Түүнчлэн бид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үнэ, зах зээл болон маркетингийн аливаа мэдээллийг нягтлан шалгах үүрэггүй болно.

(ё) Энэхүү Хуулийн дүгнэлтийн агуулгад нөлөөлөх бидний мэдэхгүй өөр мэдээлэл, баримт бичгүүд байх боломжтой. Бидэнд ирүүлсэн мэдээлэл, баримт бичиг нь шаардлагатай буюу холбоотой байж болох бүх мэдээлэл, баримт бичгүүдийг бүрдүүлсэн гэж бид мэдэгдэж, батлах боломжгүй болно.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

(ж) Энэхүү Хуулийн дүгнэлт нь зөвхөн түүний үндсэн хэсэгт дурдагдсан мэдээлэл, баримт бичгүүдэд үндэслэгдсэн бөгөөд бидний танилцаж, шинжлэн судалсан баримт бичгүүдтэй зөрчилдөх эсхүл тэдгээрээс өөр мэдээлэл агуулсан бидний мэдэхгүй өөр бусад нэмэлт мэдээлэл, баримт бичгүүд байж болно. Тэдгээрийг бидэнд дэлгэн өгөөгүй, дүн шинжилгээнд хамруулаагүйн улмаас үүсэх хариуцлагыг Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан хүлээнэ.

(з) Энэхүү Хуулийн дүгнэлтийг уг Хуулийн дүгнэлтэд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бэлтгэсэн бөгөөд түүнээс хойш тэдгээр хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон, хүчингүй болсон бол нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй.

(ж) Энэхүү Хуулийн дүгнэлтийн агуулгад Үнэт цаас гаргагч болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу хүлээх үүргийн биелэлт хэвийн үргэлжилж байгаа эсэх талаар дүгнэлт хийгээгүй болно.

**Хуулийн дүгнэлтийн хүрээнд гаргах мэдэгдэл**

Хуулийн дүгнэлтийг бэлтгэхтэй холбогдуулан бид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичгүүдтэй танилцаж, Үнэт цаас гаргагчийн зөвшөөрсөн хүрээнд баримт бичгүүдийг хуулбарлан авч, тодорхой тооны баримт бичгүүдийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчаас бидэнд эх хувиар болон цахим шуудангаар илгээснээр тэдгээртэй танилцаж, шинжлэн судалсан болно. Бид Хуулийн дүгнэлтийг бэлтгэхдээ түүнд тусгайлан өөрөөр заагаагүй бол бидэнд хуулбарлан өгсөн, бидний танилцаж, шинжлэн судалсан бүх баримт бичиг:

(а) жинхэнэ, үнэн зөв, бүрэн, зохих ёсны баримт бичиг гэж;

(б) хүчин төгөлдөр бөгөөд хүчингүй болоогүй, цуцлагдаагүй, дуусгавар болоогүй гэж;

(в) зохих хууль, журмын дагуу үйлдэгдсэн, үүний дотор баримт бичиг дээрх гарын үсэг жинхэнэ бөгөөд үнэн зөв, эрх бүхий этгээд гарын үсэг зурсан гэж;

(г) эх хувь биш байх тохиолдолд аливаа хуулбар, хувийг эх хувьтай адил хувь гэж;

(д) баримт бичигтэй холбоотой бүхий л шийдвэр, зөвшөөрөл цуцлагдаагүй, өөрчлөгдөөгүй, хүчинтэй хэвээр байгаа, мөн уг шийдвэр, зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөх аливаа үйлдэл, эс үйлдэл хийгдээгүй гэж;

(е) мэдээлэл задруулсан этгээдийн баримт бичиг, мэдээлэлтэй холбоотой бүхий л мэдэгдэл нь үнэн зөв байсан бөгөөд үнэн зөв хэвээр байгаа гэж;

(ё) төрийн болон холбогдох бусад байгууллагуудаас хүлээн авсан албан бичиг, тодорхойлолт, лавлагаа, олон нийтэд нээлттэй бүртгэл, мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв гэж тус тус үзсэн болно.

## Гурав. Хуулийн дүгнэлт

**1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДАЖ, БҮРТГЭГДСЭН ЭСЭХ**

***1.1. Үүсгэн байгуулсан байдал:***

Үнэт цаас гаргагч нь Үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 22/04а/23 тоот шийдвэрээр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэйгээр үүсгэн байгуулагдаж, Компанийн тухай хуулийн 15 дугаар зүйлд

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

заасны дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр бүртгэгдсэн байна.

***1.2. Улсын бүртгэлд анх бүртгүүлсэн байдал:***

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хуулийн дагуу "төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа"-ны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр анх үүсгэн байгуулагдаж Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр албан ёсоор бүртгэгдсэн нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангаж байна.

9011840095 тоот улсын бүртгэлийн дугаар, 6875351 тоот регистрийн дугаартай Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу Монгол Улсын хуулийн этгээдийн бүртгэлд ийнхүү зохих ёсоор бүртгэгдсэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22900002003799 тоот лавлагаагаар баталгаажсан болно.

***1.3. Улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх эрх зүйн чадвар:***

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг тул Үнэт цаас гаргагч нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн дагуу өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадвартай хуулийн этгээд байна.

***1.4. Үнэт цаас гаргагчийн холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм, улсын бүртгэл, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх***

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 22/23а/06 тоот тогтоолоороо Үнэт цаас гаргагчийн "төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа" үйл ажиллагааны чиглэлийг "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах" болгон өөрчлөхөөр шийдвэрлэжээ. Мөн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхтэй холбогдуулан Үнэт цаас гаргагчийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тогтоолын хавсралтаар батлаж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авах эрхийг тодорхой этгээдэд олгосон байна.

Үүний дагуу Үнэт цаас гаргагч нь 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороонд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн албан бичгийг холбогдох баримт бичгийн хамт хүргүүлжээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоороо Үнэт цаас гаргагчид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосны дагуу "Бичил Эй Би Эс Актив" ХХК нь оноосон нэрээ "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК болгох өөрчлөлтийг тусгаж, 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан шинэчилсэн дүрмээ Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр бүртгүүлсэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22900002003799 тоот лавлагаагаар баталгаажсан. Иймд Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм нь энэхүү Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.

***2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх***

Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой дараах шийдвэр, тогтоолууд хүчин төгөлдөр, хууль тогтоомжид нийцэж байна. Үүнд:

(i) Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай" 22/23а/04 тоот тогтоол;

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ 03

(ii) Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн "Компанийн үйл ажиллагааны чиглэлт өөрчлөлт оруулах тухай" 22/23а/06 тоот тогтоол;

(iii) Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төсөлд оролцох зөвлөхүүдийг сонгох тухай" 22/23а/08 тоот тогтоол;

(iv) Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн "Компанийн оноосон нэрэнд өөрчлөлт оруулж, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай" 22/23а/09 тоот тогтоол;

(v) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төсөлд оролцох зөвлөхүүдийг сонгох, журам батлах тухай" 22/23а/07 тоот тогтоол;

(vi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай" 22/23а/05 тоот тогтоол;

(vii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 22/23а/14 тоот тогтоол;

(viii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 22/23а/12 тоот тогтоол;

(ix) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга батлах тухай" 22/23а/18 тоот тогтоол;

(x) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай" 22/23а/17 тоот тогтоол;

(xi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Оролцогч талуудтай байгуулах гэрээний төслийг батлах тухай" 22/23а/15 тоот тогтоол;

(xii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Журам батлах тухай" 22/23а/16 тоот тогтоол;

(xiii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл батлах тухай" 22/23а/19 тоот тогтоол.

### 3. ***ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, заавруud нь хууль тогтоомжид нийцсэн эсэх***

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь үндсэн үйл ажиллагаандаа ашиглах дор дурдсан дүрэм, журмуудын төслийг боловсруулж бидэнд ирүүлсэн. Бид тэдгээр дүрэм, журмын төслүүдийг хянаж үзээд Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэх байдлаар тодорхой саналуудыг тусгасан мөн тэдгээр хууль тогтоомжуудаар хориглосон аливаа заалт тусгагдаагүй байх тул Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглах дүрэм, журмууд нь хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж байна. Үүнд:

(i) **"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн дүрэм**. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоор "Бичил Эй Би Эс Актив" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгож, тусгай

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

зөвшөөрөл олгосонтой холбогдуулан компанийн эрхлэх үйл ажиллагаа, оноосон нэрд өөрчлөлт оруулан ажлын 15 хоногийн дотор улсын бүртгэлд мэдэгдэхийг "Бичил Эй Би Эс Актив" ХХК-ийн ТУЗ-ийн даргад даалгасан байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 22/23а/09 тоот тогтоолын Хавсралтаар "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталж, Үнэт цаас гаргагч нь шинэчилсэн дүрмээ 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсон бөгөөд "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн шинэчилсэн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйл болон бусад зүйлүүдэд нийцсэн байна.

(ii) **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталжээ. Тус журамд ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрх, үүрэг, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох, ТУЗ-ийн хурлыг хуралдуулах журам, цашилн урамшуулал, гишүүэд хүлээлгэх хариуцлагыг тусгасан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн засаглалын кодекст хориглосон зүйлсийг агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(iii) **Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 22/23а/07 тоот тогтоолын хавсралтаар "Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам"-ыг баталжээ. Нийт 8 бүлгээс бүрдэх энэхүү журам нь Үнэт цаас гаргагчид аудит хийх хөндлөнгийн аудиторыг сонгох, солих, тэдгээрт тавигдах шаардлага, гэрээ байгуулах, цуцлах болон бусад холбогдох үйл ажиллагааг зохицуулахаар байна. Тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Аудитын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлс агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(iv) **Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 7 дугаар хавсралтаар "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ыг баталжээ. Нийт 7 бүлгээс бүрдэх энэхүү журмын зорилго нь ТЗК-аас гаргах автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дах зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор үнэт цаас гаргагч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршиж байна. Тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлс агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(v) **Хөрөнгө итгэмжлэн удирдах журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 6 дугаар хавсралтаар хавсралтаар "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ыг баталжээ. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хасагчлэн болон бүтнээр нь буцаан худалдах замаар хөрөнгийн багцад



TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHAN
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

өөрчлөлт оруулах зэрэг хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны зарчим, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа, хэлцэл эрхлэн гүйцэтгэх үйл ажиллагаа, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна. Тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлс агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(vi) **Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам.** Тус журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан байна. Энэхүү журмын зорилго нь Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна. Тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлс агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(vii) **Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 5 дугаар хавсралтаар хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилго бүхий “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг баталсан байна. Энэхүү журмаар компанийн тайланг нийтэд мэдээлэх, мэдээлэл хүргэхэд тавих хязгаарлалт, нийтэд мэдээлсэн мэдээллийн архив бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа зэрэг зохицуулахаар төлөвлөсөн байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлс тус журамд агуулагдаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэв.

(viii) **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 4 дүгээр хавсралтаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үүсэх болох эрсдэлээс сэргийлэх зорилго бүхий “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан нь сайшаалтай байна.

(ix) **Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 7 дугаар хавсралтаар “Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих тухай журам”-ыг баталжээ. Нийт 6 бүлгээс бүрдэх тус журам нь үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавих шаардлага, тэдгээртэй гэрээ байгуулах, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих журмыг тусгасан байна. Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих тухай журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам,

СЭХ
2022 11 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлсийг агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

(x) **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 8 дугаар хавсралтаар "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам"-ыг баталсан байна. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулах анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар батлагджээ. Тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Хөрөнгийн биржийн бүртгэлийн журмаар хориглосон зүйлсийг агуулаагүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***4. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй болон холбогдох этгээдүүдтэй байгуулсан гэрээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх***

***4.1. Үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах гэрээний төслүүд***

(i) **Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл**

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн баталсан шалгуур үзүүлэлтийг хангасан автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга болон түүний дагалдах эрхүүдийг Үнэт цаас гаргагчид худалдан шилжүүлэх, Үнэт цаас гаргагч нь гэрээнд заасан үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар боловсруулагдсан байна.

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл нь хөрөнгө худалдах үндсэн нөхцөл, гэрээний үнэ, баталгаат үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө солих хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, зээлийн дансны бүртгэлийн мэдээлэл солилцох, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө буцаан худалдан авах, гэрээний зөрчил зэрэг нийт 14 бүлгээс бүрджээ. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл нь Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар хориглосон зүйлсийг агуулаагүй тул холбогдох хууль тогтоомжуудад нийцсэн гэж дүгнэж байна.

(ii) **Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ**

Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний төсөл нь хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлж буй автомашины зээлийн хөрөнгийн багц, түүгээр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор фидуцийн зүйлүүдийг болон түүнтэй холбоотой бусад эрхүүдийн хамт Үнэт цаас гаргагчид барьцаалуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар боловсруулагджээ.

Фидуцийн барьцааны гэрээний төсөл нь барьцааны зүйл, барьцааны нөхцөл, барьцаагаар үүргийн гүйцэтгүүлийг хангуулах, талуудын мэдэгдэл, баталгаа, гэрээний зөрчил, хариуцлага, маргаан шийдвэрлэх журам зэрэг 9 бүлгээс бүрдэж байна. Фидуцийн барьцааны гэрээний төсөл нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулиудад заасан зүйлсийг агуулсан байх тул холбогдох хууль тогтоомжуудад нийцсэн гэж үзэж байна.



ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

(iii) **Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 1 дүгээр хавсралтаар Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг баталсан байна. Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл нь үйлчилгээ үзүүлэгч Үнэт цаас гаргагчийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг гаргах замаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдаж авсан хөрөнгийн багц дах зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлох зорилготой байна.

Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл нь нийтлэг үндэслэл, үнэт цаасны төлбөр цуглуулах ажиллагаа, үйлчилгээний хөлс, баталгаа мэдэгдэл, гэрээ дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх журам, бусад зүйл гэсэн 9 зүйлээс бүрдэж байна. Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл нь Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиудад заасан зүйлсийг агуулсан байх тул хууль тогтоомжуудад нийцсэн гэж үзэж байна.

(iv) **Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээ**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 2 дугаар хавсралтаар Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээний төслийг баталсан байна. Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээний төсөл нь үйлчилгээ үзүүлэгч болон үнэт цаас гаргагчийн хооронд байгуулсан “Зээлийн эргэн төлөлт цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу зээлийн эргэн төлөлтийг хуримтлуулах төлбөр цуглуулах данс, уг дансанд цугларах зээлийн эргэн төлөлтийн орлогыг барьцаалах, Үнэт цаас гаргагчийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөр, үнэт цаас гаргагчийн гэрээгээр болон хууль тогтоомж, журмаар хүлээсэн төлбөрүүдийг төлөх зорилгоор Үнэт цаас гаргагчийн төлбөр гүйцэтгэх дансанд тохирсон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэх, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилготой байна.

Зээлийн эргэн төлөлт цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл нь нийтлэг үндэслэл, барьцааны зүйл, үүргийн гүйцэтгэлийн хангуулах үндэслэл, үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга, эрх олгох, үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа, үнэт цаас гаргагчийн үүрэг, хариуцлага, гэрээ дуусгавар болох, нууцлал, хариуцлага, маргаан шийдвэрлэх журам, бусад зүйл гэсэн 14 зүйлээс бүрдэж байна. Зээлийн эргэн төлөлт цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулиудад нийцсэн байна.

(v) **Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тогтоолын 3 дугаар хавсралтаар Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төслийг баталжээ. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний зорилгор нь Үнэт цаас гаргагчийн автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдагчаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлоход оршиж байна.



ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
өний сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төсөл нь Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар хориглосон зүйлсийг агуулаагүй байх тул хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж байна.

(vi) **Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ.** Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 408 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгогдсон “Ниямазон аудит” ХХК-тай Үнэт цаас гаргагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийх, санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргах харилцааг зохицуулах аудитын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээгээр аудитын үйлчилгээний цар хүрээ, гэрээний үнэ, талуудын хүлээх үүрэг, маргаан шийдвэрлэх журам болон бусад зохицуулалтуудыг тусгажээ.

(vii) **Захиргааны ажил гүйцэтгэх гэрээ.** Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагч Бичил Глобус Финанс ББСБ ХХК-тай Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой ажлын хийж гүйцэтгэх зорилго бүхий “Захиргааны ажил гүйцэтгэх гэрээ”-ний төслийг бэлтгэсэн байна. Тус гэрээний төсөлд “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК нь дараах ажил үйлчилгээг үзүүлэхээр заажээ. Үүнд:

(1) ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцтгэх ур чадвар, мэдлэг туршлага бүхий ажилтныг захиргааны үйлчилгээ үзүүлэгчээс санал болгосны хүрээнд, ТЗК-ийн ТУЗ-өөс томилсон тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажил үүргийг гүйцэтгэх, хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах;

(2) ТЗК-ийн бичиг хэргийн хөтлөлт буюу албан бичиг хүлээж авах, илгээх, түүнтэй холбоотой баримт бичгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;

(3) ТЗК-ийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг холбогдох стандарт, журам, зааврын дагуу хийх, санхүү, татвар, нийгмийн даатгал болон холбогдох бүх тайлан мэдээг хуульд нийцсэн хугацаанд тайлагнаж, хүргүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдагчид холбогдох тайлан мэдээг хүргүүлэх;

(4) Үнэт цаас эзэмшигчийн нэрээр хүүгийн орлогоос суутгасан албан татварыг төлж, тайлагнах, холбогдох тайлан мэдээг хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;

(5) ТЗК-ийн олон нийтэд хандсан цахим хуудсын хөгжүүлэлт, хөтлөлтийн ажлыг хариуцаж, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зааврын дагуу ажиллана;

(6) ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, талуудаас баримт бичиг цуглуулж, хөндлөнгийн аудитад хүлээлгэн өгөх, буцаан авах, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;

(7) Жил бүрийн үйл ажиллагааны төсвийн төслийг бэлтгэж, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зөвшөөрлийн дагуу ТУЗ-ийн хурлаар хэлцүүлэн батлуулах;

(8) ТЗК-ийн гэрээ, хэлцэл болон журамд өөрчлөлт оруулах тохиолдолд тэдгээрийн төслийг бэлтгэх, хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүлээлгэн өгөх;

(9) ТЗК-ийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг нэгтгэж, хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх.

“Захиргааны ажил гүйцэтгэх гэрээ” нь Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагч нарын хувьд Компанийн тухай хуулийн Арванхоёр дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож байна. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 22/23а/19 тоот тогтоолоороо сонирхлын зөрчилтэй хэлцлийг холбогдох хууль тогтоомжийн



TDB SECURITIES

СЗХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

хүрээнд хэлэлцэн тохирч, гарын үсэг зурж байгуулах зөвшөөрлийг ТУЗ-ийн дарга Ц.Азбаярт олгосон тул "Захиргааны ажил гүйцэтгэх гэрээ"-г Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулах зөвшөөрөл олгогдсон гэж үзэж байна.

### 4.2. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүтэй байгуулсан гэрээнүүд

Энэхүү Хуулийн дүгнэлт гарах үеийн байдлаар үнэт цаас гаргах ажиллагаад оролцогч этгээдүүдтэй байгуулсан дараах гэрээнүүд нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад нийцэж байх тул Үнэт цаас гаргагчийн одоогийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байхгүй гэж үзэж байна. Үүнд:

(i) **Андеррайтер-Зуучлалын үйлчилгээний гэрээ.** Үүсгэн байгуулагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 73 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай TDBS-22/457 тоот дугаартай Андеррайтер-Зуучлалын үйлчилгээний гэрээг 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр, Үнэт цаас гаргагч нь мөн "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай TDBS-386/2022 тоот дугаартай Андеррайтер-Зуучлалын үйлчилгээний гэрээний нэмэлт гэрээг 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр тус тус байгуулсан байна. Андеррайтер-Зуучлалын үйлчилгээний гэрээ болон түүний нэмэлт гэрээгээр Үнэт цаас гаргагчийн нийт 10,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд нээлттэй хүрээнд гаргах ажлыг зохион байгуулах, андеррайтер-зуучлалын үйлчилгээг үзүүлэх хэлбэр, хугацаа, үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангах зөвлөх үйлчилгээ, үйлчилгээний хөлсийг зуучлагчид төлөх, талуудын эрх үүрэг, маргаан шийдвэрлэх журам зэрэг харилцааг зохицуулж байна.

(ii) **Хамтран ажиллах ерөнхий гэрээ.** Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 тоот тогтоолоор хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл олгогдсон "Юнайтед Айр Файнэнс" ХХК-тай Хамтран ажиллах ерөнхий гэрээг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд хэлцлийн зөвлөх үйлчилгээ болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээг үзүүлэх бөгөөд эдгээр үйлчилгээний ерөнхий харилцааг зохицуулж байна.

(iii) **Гэрээт ажлын захидал**. Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 53 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгогдсон "Онч аудит" ХХК-тай Үнэт цаас гаргагчийн худалдан авахаар төлөвлөж буй зээлийн багцтай холбоотой мэдээлэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, аудитын үйл ажиллагааг Аудитын тухай хууль, Аудитын олон улсын стандартад нийцүүлэн явуулах харилцааг зохицуулсан гэрээт ажлын захидлыг байгуулсан байна. Гэрээтийн ажлын захидлаар аудитын үйлчилгээний цар хүрээ, үйлчилгээний хөлс, талуудын хүлээх үүрэг, маргаан шийдвэрлэх болон бусад зохицуулалтуудыг тусгажээ.

### 5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх

5.1. Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалтын дагуу аливаа "компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Үүнд:

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

(i) хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

(ii) хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

(iii) хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

5.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүд буюу "Юнайтед Айр Файнэнс" ХХК, "Онч аудит" ХХК, "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК, "Ниямазон аудит" ХХК-тай аливаа хууль тогтоомжоор хориглосон ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг шалгахдаа Үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ, хэлцлүүдийг хянаж үзсэн бөгөөд гэрээ байгуулсан талын мэдээллийг УБЕГ-ийн нээлттэй цахим сан буюу www.opendata.burtgel.gov.mn цахим хуудаснаас шалгаж, сонирхлын зөрчилтэй байж болох этгээдийн мэдээллийг нягталж үзсэн болно.

5.3. Ийнхүү шалгахад Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй аливаа хууль тогтоомжоор хориглосон ашиг сонирхлын зөрчилтэй байж болох нөхцөл байдал тогтоогдоогүй.

### ***6. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх***

6.1. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй холбогдох хууль тогтоомжоор хориглосон аливаа ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг шалгахдаа "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй байгуулсан гэрээ, хэлцлүүдийг хянаж үзсэн бөгөөд гэрээ байгуулсан талын мэдээллийг УБЕГ-ийн нээлттэй цахим сан буюу www.opendata.burtgel.gov.mn цахим хуудаснаас шалгаж, сонирхлын зөрчилтэй байж болох этгээдийн мэдээллийг нягталж үзсэн болно.

6.2. Ийнхүү шалгахад Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй аливаа хууль тогтоомжоор хориглосон ашиг сонирхлын зөрчилтэй байж болох нөхцөл байдал тогтоогдоогүй.

### ***7. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх***

Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан санхүүгийн тооцоолол, үнэлгээ, зах зээлийн төсөөлөл, татвар, Үнэт цаас гаргагчаас бусад этгээдийн талаарх мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн аливаа амлалт зэрэг хуулийн фирмийн зүгээс шалгаж, баталгаажуулах боломжгүй зүйлсээс бусад Үнэт цаас гаргагчийн талаарх хууль зүйн мэдээллүүд нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдсон бөгөөд аливаа худал, ташаа, үнэнийг гуйвуулсан зүйл агуулаагүй, хүчин төгөлдөр бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, холбогдох хууль журамд нийцэж байна.



ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

### 8. *Автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн худалдах авах хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуур хангагдсан эсэх*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 9 дүгээр дугаар сарын 27-ны өдрийн 22/23а/14 тоот тогтоолоор баталсан автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга болон түүний дагалдах эрхүүдийг баталгаажсан үнэт цаас гаргах хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцад тавигдах дараах хуулийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна. Үүнд:

| № | Хуулийн шалгуур үзүүлэлт |
|---|---|
| **I. Зээлийн хөрөнгийн хувьд** | |
| 1. | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаанд баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан |
| 2. | Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх |
| 3. | Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх |
| 4. | Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх |
| 5. | Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байх |
| 6. | Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байх |
| **Барьцаа хөрөнгийн хувьд** | |
| 7. | Үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан байх, уг барьцаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байх |
| 8. | Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх |
| 9. | Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх |
| 10. | Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх) |

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

| № | Хуулийн шалгуур үзүүлэлт |
|---|---|
| 11. | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүдийг ТЗК-д барьцаалах агуулга бүхий Фидуцийн барьцааны гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх. |

Үнэт цаас гаргагчийн худалдан авах зээлийн хөрөнгийн багц нь дээрх шаардлагыг хангаж байгаа эсэхийг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-аас баталсан Зээлийн үйл ажиллагааны журамд үндэслэн зээлийн дансны хувийн хэргүүд, тэдгээрт агуулагдаж байгаа бичиг баримтуудыг шалгасан болно. Ийнхүү шалгахдаа нийт зээлийн хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн данснуудаас дараах зарчмыг баримтлан санамсаргүй түүврийн аргаар сонгосон 80 зээлийн дансанд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

(i) Хамгийн өндөр болон хамгийн бага дүнтэй;
(ii) Хамгийн өндөр болон хамгийн бага хүүтэй;
(iii) Хамгийн урт хугацаатай болон хамгийн богино хугацаатай;
(iv) Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн Улаанбаатар хот болон орон нутаг дах салбар тус бүрээс олгосон зээл.

Бидний түүврийн аргаар сонгосон 80 зээлийн хувьд зээлийн шалгуурыг дараах байдлаар хангаж байна. Үүнд:

***Шалгуур 1. Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаанд баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан эсэх***

Үнэт цаас гаргагчийн худалдан авах зээлийн хөрөнгийн багц нь дээрх шаардлагыг хангаж байгаа эсэхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журамд үндэслэн зээлийн дансны хувийн хэргүүд, тэдгээрт агуулагдаж байгаа бичиг баримтуудын бүрдлийг хянаж үзсэн болно. Ийнхүү хянаж үзэхэд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 80 зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гүйцэтгэх захирлын баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу үүсгэгдсэн буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээл олгох үйл ажиллагаандаа баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д "зээлийн гэрээний дагуу зээлийг зээлдэгчийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгчийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно" гэж заасан. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зарим зээлийн данснуудын хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийг зээлдэгчийн амаар болон бичгээр өгсөн зөвшөөрлөөр зээлдэгчийн бус тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. Иймд зээлийн гэрээний дагуу зээлдэгчид олгосон мөнгөн хөрөнгийг зөвхөн зээлдэгчийн дансанд шилжүүлж байхыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид анхааруулж зөвлөх нь зүйтэй гэж үзэж байна.

***Шалгуур 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх***

Бид санамсаргүй түүврийн аргаар сонгосон 80 зээлийн хувийн хэргээс зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэж байгаа эсэх, шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой эсэх талаар нягталж үзсэн болно. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

зээлүүдийн хувьд Монгол Улсын Иргэний хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгө шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасан зүйлсийг агуулсан, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 231 дүгээр зүйлийн 231.1.6, 235 дугаар зүйлүүдэд заасан "үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ" буюу "фидуцийн гэрээ"-г байгуулахыг зөвшөөрсөн бөгөөд тус гэрээг бичгээр байгуулна гэж заасан. Үүний дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах гэрээг бичгээр байгуулах хуулийн шаардлага хангасан байна. Мөн барьцааны гэрээ (фидуци)-ний 1.7 болон 1.9-д зээлдэгч нь зээлийн гэрээний хугацаа дуусахад өр төлбөрийн үлдэгдэлтэй байх тохиолдолд фидуцийн зүйлийг хураан авч ажлын 5 өдрийн дотор мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүргүүлснээс хойш 15 хоногийн дараа барьцаалагч нь барьцаа хөрөнгийг бусдад худалдах болон бусад хэлбэрээр борлуулж хохирлоо барагдуулахаар заасан тул дээрх шалгуурыг хангаж байна гэж үзэж байна.

Гэхдээ анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор байгуулсан барьцааны гэрээ (фидуци)-нд заасан зүйлс нь хөдлөх эд хөрөнгийн барьцааны зохицуулалттай хольсон буюу төөрөгдөл үүсгэж болохуйц байгааг анхаарч фидуцийн гэрээний загварт цаашид өөрчлөлт оруулах шаардлагатай болохыг анхааруулж зөвлөсөн болно.

***Шалгуур 3. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх***

Бид дээрх шалгуур үзүүлэлт хангагдаж байгаа эсэхийг нягтлах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн үндсэн зээлдэгч, хамтран зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуци)-г талууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан эх хувийг, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбарыг шалгасан бөгөөд зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байгаа эсэх, анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээ ангид байгаа эсэхийг Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд хайлт хийж үзэхэд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн данснуудад хамаарах ямар нэг илэрц илрээгүй болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлүүдийн хувьд барьцааны гэрээ (фидуци)-ний дагуу фидуцийн зүйл болох автомашины өмчлөгчөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК бүртгэлтэй байх боловч Зээлдэгч фидуцийн зүйлийг эзэмшиж, ашиглаж байгаа нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.2-т заасанд нийцэж байна.

Фидуцийн зүйл буюу автомашин нь Зээлдүүлэгчийн өмчлөлд байх боловч Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг жолоодож байгаа жолооч нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээг заавал авч явах үүрэг хүлээсэн тул санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн хөрөнгө буюу автомашины тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээний эх хувийг бидэнд ирүүлэх боломжгүй байсан болно.

Мөн түүнчлэн Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын дагуу өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэдэг. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тасалбар болгох өдрийн байдлаар автомашиныг бусдын өмчлөлд шилжүүлэх аливаа хүсэлт гаргаагүй, бусад этгээдэд эрх олгоогүй гэдгээ 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн "Эрх бүхий албан тушаалтны батламж бичиг" баталгаажуулсан болно. Иймд дээрх шалгуур үзүүлэлт хангагдсан гэж үзэж байна.

***Шалгуур 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх***

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдийг шалгаж үзэхэд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн байгуулсан зээлийн гэрээнд шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглосон, аливаа байдлаар хязгаарласан эсэх талаар тодорхой зүйлс тусгаагүй байна. Иргэний хуулийн 123 дугаар зүйлд шаардах эрхээ шилжүүлэх талаар зохицуулсан байх бөгөөд 123.2-т хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно гэж заасан тул Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК нь зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах бусад эрхийн хамт гуравдагч этгээдэд шилжүүлэхэд харшлах зүйлгүй байна. Иймд дээрх шалгуур үзүүлэлт хангагдсан гэж дүгнэж байна.

***Шалгуур 5. Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн тухайн зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байх***

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй танилцахад тасалбар болгох байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн зээл нь Үнэт цаас гаргагчид худалдсан, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэг хүлээсэн аливаа нөхцөл байдал тогтоогдоогүй болно. Мөн түүнчлэн Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоор анх удаа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгосон тул түүнээс өмнө зээлийн хөрөнгө худалдан авсан байх хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Хэрэв Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгохоос өмнө аливаа хөрөнгийн багц худалдан авсан бол Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.11-т заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Иймд дээрх шалгуур үзүүлэлт хангагдсан гэж үзэж байна.

***Шалгуур 6. Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байх***

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн хувийн хэргүүдэд агуулагдаж байгаа мэдээлэл нь Үнэт цаас гаргагчийн бидэнд ирүүлсэн худалдан авах зээлийн хөрөнгийн багц дах мэдээлэлд нийцэж байна.

***Шалгуур 7. Үүргийн гүйцэтгэлийг хангах нэг буюу хэд хэдэн арга (хөдлөх эд хөрөнгийн барьцаа, фидуци, гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт г.м)-ыг ашигласан байх, уг барьцаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан байх***

Монгол Улсын Иргэний хуулийн 231 дүгээр зүйлд үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргуудыг заасан. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдийн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар зээлийн гэрээ болон “Барьцааны гэрээ (фидуци)”-г байгуулжээ. Фидуци нь үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээсэн үүргийн гүйцэтгэлийн хангах арга юм.

Фидуцийн гэрээгээр автомашины өмчлөл нь зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэх хүртэл хугацаанд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-д хадгалагдаж байгаа нь тэргүүн ээлжид шаардлага хангуулах эрхийг баталгаажуулсан дээрх шалгуурыг хангаж байна гэж үзэж байна.

***Шалгуур 8. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ***

***хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх***

Дээрх *Шалгуур* 2-т дурдсаны дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдийн хувьд байгуулсан зээлийн болон барьцааны гэрээ (фидуци)-ийн гэрээ нь хуульд нийцсэн, заавал биелэгдэх үүрэг үүсгэж байна. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрч зээлийн болон барьцааны гэрээ (фидуци)-ийн гэрээнд гарын үсэг зурсан байх тул талууд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийн хангуулахаар тохиролцсон гэж үзэж байна. Барьцааны гэрээ (фидуци)-ний 1.7 болон 1.9-д зээлдэгч нь зээлийн гэрээний хугацаа дуусахад өр төлбөрийн үлдэгдэлтэй байх тохиолдолд фидуцийн зүйлийг хураан авч ажлын 5 өдрийн дотор мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүргүүлснээс хойш 15 хоногийн дараа барьцаалагч нь барьцаа хөрөнгийг бусдад худалдах болон бусад хэлбэрээр борлуулж хохирлоо барагдуулахаар заасан тул дээрх шалгуурыг хангаж байна гэж үзэж байна.

***Шалгуур 9. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн, өмчлөл, эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх***

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдийг шалгаж үзэхэд фидуцийн гэрээг хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн ердийн практикт дагаж мөрддөг бүх дүрэм, журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөл, эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байсан болно.

***Шалгуур 10. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх)***

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдийн хувийн хэрэгт авагдсан баримт бичгүүдийг хянаж үзэхэд тасалбар болгох өдрийн байдлаар зарим фидуцийн зүйлийн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний хугацаа дууссан, зарим тохиолдод тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан эсэх баримт авагдаагүй байсан бөгөөд сунгагдсан талаар баримт авагдаагүй зөрчил илэрсэнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч залруулах арга хэмжээ авсан байна. Иргэний хуулийн 473 дугаар зүйлийн 473.2-т даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй гэж заасан тул Анхны үүрэг гүйцэтгүүлэгч фидуцийн зүйлийн хувьд тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан эсэхэд онцгой анхааруулах хандуулах, даатгалын гэрээний хуулбарыг цаг тухайд зээлдэгчдээс гаргуулан авч байхыг анхааруулж зөвлөсөн болно.

***Шалгуур 11. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүдийг ТЗК-д барьцаалах агуулга бүхий Фидуцийн барьцааны гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх.***

“Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний төслийн 2.6 дугаар зүйлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцийн авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор “Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ” байгуулахаа зөвшөөрсөн байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн зүйлийн болон түүнд дагалдах бусад эрхүүдийг Үнэт цаас гаргагчид барьцаалуулахыг зөвшөөрсөн нь Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасан нийцэж байх тул дээрх шалгуурыг хангасан гэж үзэж байна.



СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -11- 15 БҮРТГЭВ-03
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

***9. Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд, үүргийг гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх***

Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 80 зээлийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа зээлийн гэрээг шалгахад шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглосон, аливаа байдлаар хязгаарласан заалт тусгаагүй байна. Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл тусгаагүй тул шаардах эрх эзэмшигч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг эрхээ Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлахгүй тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр гуравдагч этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж болохыг зөвшөөрсөн тул үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгоогүй, шилжүүлэхийг хориглоогүй, хязгаарлаагүй байна.

***10. Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага хангаж байгаа эсэх***

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "*Компанийн ТУЗ нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна*" гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэй томилжээ. Үүнд:

| **№** | **Овог нэр** | **Албан тушаал** | **Томилсон шийдвэр** | **Засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний дугаар** | **Засаглалын гэрчилгээ авсан огноо** |
|---|---|---|---|---|---|
| 1. | Самдангийн Отгонбат | Ердийн гишүүн | 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/23а/04 тоот тогтоол | 0730735 | 2016.09.09 |
| 2. | Цээпэлийн Азбаяр | Хараат бус гишүүн | | 0521249 | 2022.04.22 |
| 3. | Баяраагийн Баасандорж | Хараат бус гишүүн | | 0520700 | 2018.05.27 |

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дах хэсэг, 79 дүгээр зүйлийн 79.1, 84 дүгээр зүйлийн 84.2, 84.3 дах хэсэг, Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагуудыг хангасан байх ёстой. Мөн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дах хэсэгт шаардсаны дагуу компанийн ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТУЗ-ийн гишүүдэд тавигддаг хууль тогтоомжийн шаардлага хангасан эсэх байдлыг доорх хүснэгтээс үзнэ үү. Үүнд:



ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

| № | Хуулийн шаардлага | ТУЗ-ийн гишүүний нэр | | |
|---|---|---|---|---|
| | | **Самдангийн Отгонбат** (*ердийн гишүүн*) | **Цээпэлийн Азбаяр** (*хараат бус гишүүн*) | **Баяраагийн Баасандорж** (*хараат бус гишүүн*) |
| | | **Шаардлага хангаж байгаа эсэх** | | |
| 1. | Хувь хүн байх | Тийм | Тийм | Тийм |
| 2. | Ял шийтгэл эдлээгүй байх | Тийм | Тийм | Тийм |
| 3. | Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авах эсэх | Тийм | Үгүй | Тийм |
| 4. | Хараат бус гишүүн нь өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компайн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх | *Ердийн гишүүний хувьд хамаарахгүй* | Тийм | Тийм |
| 5. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй байх | Тийм | Тийм | Тийм |
| 6. | Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх | Үгүй | Тийм | Тийм |
| 7. | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн биш | Үгүй | Тийм | Тийм |
| 8. | Албан татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх | Тийм | Тийм | Тийм |
| 9. | Мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай[1] | Тийм | Тийм | Тийм |

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д "*Тусгай зориулалтын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн байхыг хориглоно*." гэж заасан. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи нь буюу 2 гишүүн тус шаардлагыг хангаж байгаа тул ТУЗ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг зөрчихгүй гэж үзэж байна.

[1] СЗХ-ны "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичиг бүрдүүлэх заавар"-ын Хавсралт 1-р батлагдсан "Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний тодорхойлолт"-д үндэслэн ТУЗ-ийн гишүүний мэргэжил, боловсрол, ажлын туршлагыг тодорхойлов.



TDB SECURITIES

Иймд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжоор тавигдах шаардлагыг хангасан, Үнэт цаас гаргагчийн удирдах дадлага, туршлагатай этгээдүүд мөн гэж дүгнэв.

**Үүсгэн байгуулагчийн эрх бүхий албан тушаалтнууд.** Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно гэээд мөн хуулийн 84.2-т компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна. Үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь дүрэмдээ эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг тусгайлан батлаагүй байна.

Үүсгэн байгуулагчаас бидэнд ирүүлсэн мэдээллийг үзвэл дараах этгээдүүд нь Үүсгэн байгуулагчийн эрх бүхий албан тушаалтанд хамаарч байна. Үүнд:

1. Б.Хүрэлхүү – ТУЗ-ийн дарга;
2. С.Отгонбат – ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал;
3. Д.Ганболор – ТУЗ-ийн гишүүн;
4. Б.Хишигсүрэн – ТУЗ-ийн хараат бус гишүүн;
5. Н.Золжаргал – ТУЗ-ийн хараат бус гишүүн;
6. Б.Баярчимэг – Дэд захирал;
7. Б.Даваабат – Бизнес хөгжлийн газрын захирал;
8. Я.Адъяахүү – Санхүү бүртгэлийн газрын захирал;
9. Н.Гантулга – Зээлийн газрын захирал;
10. О.Батжаргал – Мэдээлэл технологийн хэлтсийн захирал;
11. Г.Юмсүрэн – Дотоод аудитын газрын захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
12. У.Ундармаа – Хүний нөөцийн менежер.

Бид Үүсгэн байгуулагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3.2 дах хэсэгт заасан ял шийтгэл эдэлж байгаа, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, мэдээллийг бие даан хөндлөнгөөс авах боломжгүй тул тэдгээр албан тушаалтнуудын "Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал (www.e-mongolia.mn) системээс өөрсдөө авч бидэнд ирүүлсэн "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт"-ийг үндэслэн шалгахад эрх бүхий албан тушаалтнуудын хэн нь ч ял шийтгэл эдлээгүй байх тул компанийн эрх бүхий албан тушаалтнууд дээрх шаардлагыг хангаж байна.

### *11. Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй үнэт цаас, бусад хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус эд хөрөнгөд аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээсэн эсэх*

Бид Үнэт цаас гаргагчийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөд аливаа барьцааны эрх үүсгэсэн эсэхийг Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сан (www.mpr.gov.mn)-нд бүртгүүлсэн эсэхийг шалгаж үзсэн. Хуулийн дүгнэлт гарах үеийн байдлаар цахим мэдээллийн санд Үнэт цаас гаргагчийн регистрийн дугаараар хайлт хийж үзэхэд ямар нэг илэрц олдоогүй болно.

Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь 2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-тай байгуулсан андеррайтерийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, бондын үндсэн төлбөр, бондын хүү, алданги болон андеррайтерийн гэрээтэй холбоотой бий болсон бусад төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд нийт энгийн эрхийн хувьцааны 30% буюу 30 ширхэг хувьцааг "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-д тэргүүн ээлжид шаардлага хангуулахаар барьцааны эрх үүсгэсэн байна.

12. ***Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх***

***12.1. Иргэний хэргийн тухайд:***

ШЕЗ-ийн Шүүхийн тусгай архивын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 1/2706 тоот албан бичгээр Үнэт цаас гаргагч нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаанд оролцоогүй болохыг тодорхойлсон.

ШЕЗ-ийн Шүүхийн тусгай архивын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 1/2707 тоот албан бичгээр Үүсгэн байгуулагч нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаанд хариуцагчаар оролцоогүй болохыг тодорхойлсон.

***12.2. Захиргааны хэргийн тухайд:***

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 2600 тоот албан бичигт Үнэт цаас гаргагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 2601 тоот албан бичигт Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон.

***12.3. Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаж байсан эсэх***

Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагч нар "Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал (www.e-mongolia.mn) системээс өөрсдөө авч бидэнд ирүүлсэн "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай" болон "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсанэсэх тодорхойлолт"-уудыг үндэслэн шалгахад Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагчийн аль нь ч эрүүгийн хариуцлага хүлээгээгүй буюу хүлээж байгаагүй байна.

***12.4. Монгол Улс дах арбитрын хэрэг маргааны тухайд***

Монголын Олон Улсын Арбитрийн 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 4/1492 болон 4/1493 тоот албан бичгүүд, Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрын 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн GS/2020/49 болон GS/2020/50 тоот албан бичгүүдэд Үнэт цаас гаргагч болон Үүсгэн байгуулагч нь тус арбитруудаар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон.

13. ***Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх***

***13.1. Татварын үлдэгдлийн тухайд:***

2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Монголын татварын албаны 22.1003.9dfbc961-d0bf-4210-9eb1-628d2a6e1b31 тоот татварын тодорхойлолтод Үнэт цаас гаргагч нь татварын үлдэгдэлгүй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.

2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Монголын татварын албаны 22.1003.aa5c5e24-1761-40eb-9796-d85d60625040 тоот татварын тодорхойлолтод Үүсгэн байгуулагч нь татварын 61,975,881.86 төгрөгийн үлдэгдэлтэй, 943,416.00 төгрөгийн илүү төлөлттэй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.



СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-11-15 БҮРТГЭВ-03

***13.2. Нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй эсэх***

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1708 тоот тодорхойлолтод Үнэт цаас гаргагч нь нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22.09.27.02 тоот тодорхойлолтод Үүсгэн байгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөртэй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.

***13.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх:***

ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 0002232 тоот тодорхойлолтод Үнэт цаас гаргагч нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.

ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 0002233 тоот тодорхойлолтод Үүсгэн байгуулагч нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй байна. Уг тодорхойлолтыг Хуулийн дүгнэлтийн Хавсралт 2-т хавсаргав.

Хүндэтгэсэн,

Д. Золжаргал
Гүйцэтгэх захирал

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД
БҮРТГЭВ

TDB SECURITIES

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 19,
Худалдаа, хөгжлийн банк #1401,
Улаанбаатар 14210, Монгол Улс

# АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК /цаашид "Андеррайтер" гэх/ нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2011 оны 3 дугаар сарын 28-ны өдөр олгосон Андеррайтерийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК /цаашид "Үнэт цаас гаргагч" гэх/ болон "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК /цаашид "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч" гэх/ -тай 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр TDBS 345/2022 тоот "Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ"-г, 9 дүгээр сарын 28-ны өдөр TDBS-386/2022 тоот "Андеррайтер-зуучлалын үйлчилгээний нэмэлт гэрээ"-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжаалах үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж байгаа болно.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч болох "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг 100 хувь олон нийтэд дараах нөхцөлийн дагуу санал болгож байна.

**Хүснэгт 1: Үнэт цаасны ерөнхий нөхцөл**

| Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны ерөнхий нөхцөл | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | ▪ "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | ▪ "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК |
| **Үнэт цаасны бүртгэл** | ▪ "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |
| **Үнэт цаасны төрөл** | ▪ Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| **Үнэт цаас гаргах валют** | ▪ Төгрөг |
| **Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ** | ▪ 100,000 төгрөг |
| **Үнэт цаасны тоо ширхэг** | ▪ 100,000 ширхэг хүртэл |
| **Үнэт цаасны нийт үнийн дүн** | ▪ 10,000,000,000 төгрөг хүртэл |
| **Үнэт цаасны хугацаа** | ▪ 24 сар |
| **Үнэт цаасны хүү** | ▪ 17.5% /жилийн/ |
| **Үнэт цаасны хүү төлөгдөх хэлбэр** | ▪ Улирал тутам |
| **Үнэт цаасны хүү тооцох суурь хоног** | ▪ 365 |
| **Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хэлбэр** | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш хагас жил тутам буюу<br>▪ 6 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 12 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 18 дахь сард үндсэн төлбөрийн 25%;<br>▪ 24 дэх сард үндсэн төлбөрийн 25%. |
| **Үнэт цаасны төлбөр төлөх эх үүсвэр** | ▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт болох үндсэн болон хүүгийн төлбөр |
| **Үнэт цаасны барьцаа** | ▪ Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө бүхий Хөрөнгийн багц, түүний авлагын |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

| | |
|---|---|
| | шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд |
| **Үнэт цаасны хүүд ногдох орлогын албан татвар** | ▪ 5%*<br>**Монгол Улсад байрладаггүй гадаадын аж ахуйн нэгжийн хувьд 20% (Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ)* |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт** | ▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-аас Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан худалдан авах |
| **Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо** | ▪ "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК |
| **Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцын мэдээлэл** | |
| **Хөрөнгийн багцын үнийн дүн** | ▪ 11.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн тоо** | ▪ 761 зээл |
| **Хөрөнгийн багц дахь зээлдэгчдийн тоо** | ▪ 761 зээлдэгч |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур болон хөндлөнгийн байгууллагын дүгнэлт** | ▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлага болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг стандартаас дутуугүй шалгуур хангасан автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө байх бөгөөд ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан Санхүүгийн 24 болон Хуулийн 11 шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан сонгож авсан байна. (Бүлэг 4.6, 4.7) |

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам", Монголын хөрөнгийн бирж ТӨХК /цаашид "Бирж" гэх/-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж байгаа болно.

Үнэт цаас гаргагч нь биржийн зах зээлд гаргаж буй автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасаа Хороо, Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Андеррайтертай гэрээ байгуулан ажиллахаас гадна дараах бэлтгэл ажлуудыг хангасан байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч болох "Бичил Эй Би Эс Актив" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Үүсгэн байгуулагч болох "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 5-р сарын 25-ны өдрийн 22/04а/23 тоот "Шинээр охин компани үүсгэн байгуулах тухай" тогтоолоор үүсгэн байгуулагдсан байна. Үнэт цаас гаргагч нь Хорооны 2022 оны 8-р сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоор олгогдсон ТЗ 315/48 дугаартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Тусгай зориулалтын компани буюу "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК болж үйл ажиллагааны чиглэл болон компанийн нэршил өөрчлөгдсөн байна.

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд гаргах хүрээнд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурал 2022 оны 9 сарын 27-ны өдөр хуралдаж, 22/23а/12 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоол болон 22/23а/14 тоот "Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай" тогтоолыг гаргажээ. Нөгөө талаас, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн 2022 оны 9 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/04а/59 тоот "Зөвшөөрөл олгох тухай" тогтоолын дагуу Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдахыг зөвшөөрсөн байна.
3. Үнэт цаас гаргагч нь Хорооны 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 53 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгогдсон "Онч аудит" ХХК-тай 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр зээлийн шинжилгээ гаргах тухай "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээ", 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр тус гэрээний Нэмэлт гэрээг байгуулж Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахаар төлөвлөж буй зээлийн хөрөнгүүдийн хувийн хэргийг харилцан тохиролсон ажил үйлчилгээний дагуу хянаж, харилцан тохиролсон ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэн тайлагнах ба тус үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон Олон улсын стандарт 4400 "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ"-д нийцүүлэн ажиллахаар тохиролцож, хөндлөнгийн хараат бус дүгнэлтийг гаргасан байна.
4. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтад заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болох Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН-тай 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулж, тус гэрээгээр Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн зүгээс ирүүлсэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгосон нийт зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн данснуудад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн баталсан хуулийн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, Хөрөнгөөр батлагаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд хуулийн дүгнэлт гаргахаар харилцан тохиролцож, хөндлөнгийн хараат бус хуулийн дүгнэлтийг гаргасан байна.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах ажлын хүрээнд дараах үндсэн чиглэлээр холбогдох судалгаа шинжилгээг хийсэн болно. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл;
2. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргахтай холбоотой эрх бүхий этгээдүүдийн шийдвэр;
3. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч;
4. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал;
5. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа;
6. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн шинжилгээ;
7. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийн үйл ажиллагаа, байгуулсан гэрээ;
8. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд дагаж мөрдөх болон үнэт цаас гаргах үйл ажиллагаанд дагаж мөрдөх холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, хууль эрхзүйн орчин;
9. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаа, дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө;
10. Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд гаргаж буй ХБҮЦ-тай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс болон эрсдэлийн удирдлага;
11. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүгнэлт гаргасан байгууллагуудын тайлан дүгнэлт;

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

12. Үүсгэн байгуулагч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн хуулийн этгээдийн бүртгэл, бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал, эрх бүхий этгээд, хүний нөөц;
13. Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, бизнесийн орчин;
14. Үүсгэн байгуулагчийн санхүүгийн түүхэн үзүүлэлт, санхүүгийн харьцаа үзүүлэлт;
15. Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс болон эрсдэлийн удирдлага.

**АНДЕРРАЙТЕР НЬ ДЭЭРХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ТУЛГУУРЛАН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭН, АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТИЙГ ГАРГАЖ БАЙГАА БОЛНО.**

## НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

**Хүснэгт 2: Үнэт цаасны онцлог, давуу тал**

| Давуу тал | Хураангуй |
|---|---|
| **Тогтмол, өндөр хүүтэй хөрөнгө оруулалт** | Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ нь 2022 оны 8-р сарын байдлаарх банкны салбарын 2 жилийн хугацаатай шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад жилийн ойролцоогоор 5.7%-иар өндөр, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн түвшнээс 0.7-3.1%-иар өндөр байна. |




| Давуу тал | Хураангуй |
|---|---|
| **Бодит өгөөжийн түвшин өндөр** | Хөрөнгө оруулагч нь ХБҮЦ-ны **хүүгийн төлбөрийг улирал тутам** хүлээн авахаас гадна **үндсэн төлбөрийг хагас жил тутам** тэнцүү дүнтэйгээр хүлээн авч, дахин хөрөнгө оруулалт хийх замаар бодит өгөөжийн түвшингээ нэмэгдүүлэх боломжтой байна. Хаалттай бонд болон хадгаламжийн хүүгийн орлогоос 10%-ийг тооцож татварт суутгадаг бол нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар тооцож байгаа нь хөрөнгө оруулагчдад бий болгож буй бодит өгөөжийн түвшинг өндөр байлгахад нөлөөлж байна. |
| **Шалгуур үзүүлэлт хангасан Хөрөнгийн багц** | Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг сонгохдоо Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шалгуур, шаардлагыг хангуулахаас гадна хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны эргэн төлөлтийг баталгаажуулах зорилгоор **Санхүүгийн 24 шалгуур** болон **Хуулийн 11 шалгуур** үзүүлэлтүүдийн дагуу сонгон авч, тухайн шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэхийг хөндлөнгийн хууль болон аудитын байгууллагаар түүвэрлүүлэн шалгуулж, хараат бус хөндлөнгийн дүгнэлт гаргуулан, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн чанарыг баталгаажуулсан. |
| **Эрсдэлийн түвшин багатай Хөрөнгийн багц** | **ХБҮЦ нь хэвийн төлөлттэй Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөөр баталгаажсан** бөгөөд энэ нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт нь хугацаа хэтрэхгүйгээр товлосон хугацаандаа орж ирэх, Үнэт цаасны хуваарьт төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх бололцоог бүрдүүлнэ. Хэрэв тухайн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн, Шалгуур үзүүлэлт хангахгүй болсон эсхүл ХБҮЦ-ны төлбөр төлөхөд хүндрэл учруулахаар нөхцөл байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах зохицуулалтууд холбогдох гэрээ хэлцлүүдэд тусгагдсан. |
| **Эргэн төлөлтийн** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагч уруу шилжүүлэх буюу худалдаж буй Хөрөнгийн багцын нийт үлдэгдэл 11.0 тэрбум төгрөг, жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 28 сар, жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувь мөн зээл, барьцаа хөрөнгийн |

TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**найдвартай байдал**

үнэлгээний жигнэсэн дундаж харьцаа 56.2 хувь байгаа бөгөөд ТЗК-ийн мөнгөн урсгалын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт буюу **ТЗК-д орох мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны төлбөр болох хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг гүйцэтгэхэд хангалттай** түвшинд байна.

**Төлбөр төлөх ахлах дараалал**

Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасны дагуу ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөр буюу **ХБҮЦ-ны төлбөр нь ТЗК-ийн төлөх бусад төлбөрүүдээс хамгийн эхэнд буюу ТЭРГҮҮН ЭЭЛЖИД** төлөгдөхөөр зохицуулагдсан.

## НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох хэсэгт үндэслэн, Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/12 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор нэг бүр нь 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий 100,000 ширхэг хүртэлх буюу нийт 10.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахаар тогтоож, үнэт цаасны ерөнхий нөхцөлийг баталсан байна.

Үнэт цаас гаргагч нь тус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 100 хувь олон нийтэд санал болгох бөгөөд Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн аргаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулна.

Андеррайтер нь Андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтад заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр үзүүлнэ.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд үүсгэн байгуулагдсан "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК буюу Үнэт цаас гаргагчийн үнэт цаасжуулах хэлцлийн үйл ажиллагаа нь дараах ерөнхий зураглалын хүрээнд явагдана.

**Зураг: Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал**




**Тайлбар:**

1. Үнэт цаас гаргагчийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авахтай холбоотой түүнд тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс тогтоосон;
2. Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч буй Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь талуудын тохиролцсон санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалгах зорилгоор хөндлөнгийн зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн зөвлөх компани нь тус тусын арга аргачлалаар

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

зээлийн хөрөнгийг түүвэрлэн сонгон авах замаар бие даасан, хараат бус дүгнэлтийг гаргана;

3. Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн зөвлөхийн тайлан, шинжилгээнд үндэслэн шаардлага хангасан Хөрөнгийн багцыг "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн буюу худалдан авна;
4. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хүсэлтийг эрх бүхий зохицуулах байгууллагад хүргүүлнэ;
5. Эрх бүхий зохицуулах байгууллагаас зөвшөөрөл авсны хүрээнд хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг санал болгох замаар шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлнэ.
6. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн шилжүүлнэ.

**Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага эрсдэл**

| | |
|---|---|
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл** | |
| Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэл | ▪ Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын хүрээнд зээлийн хяналтыг хэрэгжүүлэх, зээл төлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд Зээлийн хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээл олгох үйл ажиллагаанд дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн түвшин 2022 оны 2-р улирлын байдлаар 0.7 хувь байгаа нь ББСБ-ын салбараас 9.6 дахин бага буюу тус компани эрсдэлээ оновчтой удирддаг болохыг харуулж байна;<br>▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Шалгуур үзүүлэлт болон бусад шаардлагыг хангасан Орлуулах зээлийн хөрөнгөөр солихоор үүрэгжүүлсэн;<br>▪ Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө бүрийг сонгоход тавигдсан шалгуур үзүүлэлтийн дагуу зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг тэргүүн ээлжид гаргуулах боломжтой байхаар тусгажээ. |
| Зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө эргэн төлөх эрсдэл | ▪ Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. |
| Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсантай холбоотой төлөвлөсөн хүүгийн орлого буурах эрсдэл | ▪ Зээлийн гэрээнд өөрчлөлт орох тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчид болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэхээр тусгасан бөгөөд "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-гээр энэхүү нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд тухайн зээлийн хөрөнгийг Шаардлага хангахгүй хөрөнгөд тооцон, Орлуулах хөрөнгөөр солихоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг үүрэгжүүлсэн. |
| **Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл** | |
| Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд тусгасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график болон үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн график дээр хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

| | |
|---|---|
| Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Хөрөнгийн багц чанаргүйдэх эрсдэл | ▪ "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд тусгасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх, солих замаар өөрчлөлт оруулсан нь Хөрөнгийн багцийн үзүүлэлтийг өмнөхөөс дутуугүй байлгахаар заасан бөгөөд хэрэв Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгө ангилалд шилжсэн эсхүл Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх, солих үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулах замаар Хөрөнгийн багцыг хэвийн зээлийн ангилал бүхий зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхээр зохицуулсан. |
| **Оролцогч талуудтай холбоотой эрсдэл** | |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулах үүргээ биелүүлэхгүй эсхүл биелүүлэх боломжгүй байх төлбөрийн чадваргүй болох, татан буугдах/ | ▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх боломжгүй байх болон Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-д заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах эрхтэй байна;<br>▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасны дагуу уг Хөрөнгийн багцыг гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүхэлд нь худалдан борлуулах эрхтэй байна;<br>▪ Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний дагуу Үнэт цаас гаргагчид Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх бий болох бөгөөд гуравдагч этгээдэд худалдан борлуулаагүй зээлийн хөрөнгийн хувьд Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагааг эхлүүлнэ. |
| **Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Зээлийн эргэн төлөлтийг бүрэн гүйцэд, гэрээнд заасан хугацаанд цуглуулан, Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй байх, тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах/ | ▪ Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг Худалдаа, хөгжлийн банканд тусгайлан нээсэн зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийг төлөөлөн тус дансыг, түүнд орж ирэх орлогын хамт Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансны барьцааны гэрээгээр барьцаалж, тус дансанд тогтмол хяналт тавьж ажиллана;<br>▪ Төлбөр цуглуулах үйл ажиллагааг Үйлчилгээ үзүүлэгч нь цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгах ба учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Үйлчилгээ үзүүлэгч өөрийн хөрөнгөөр төлж барагдуулахаар зохицуулсан;<br>▪ Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцтай холбоотой түүний авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
20__ он __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх буюу үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.

| | |
|---|---|
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл** /Хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасНаас бусад зорилго, зориулалтаар буюу Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, гэрээнд заасан үүргийг зохих ёсоор биелүүлэхгүй байх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, татан буугдах, дампуурах эсвэл гэрээнд заасан үүргээ биелүүлэх чадваргүй болох/ | ▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон түүний эргэн төлөлтийг удирдахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчтай байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-ний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад холбогдох тайлан мэдээллийг тогтмол хүргэх бөгөөд хууль тогтоомж болон гэрээнд заасНаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй байна. Мөн, зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгасан байна;<br>▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг эрх бүхий зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна;<br>▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон хөрөнгө итгэмжлэн удирдагчид Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө, түүний эргэн төлөлтөд хамаарах бүх баримт бичиг, данс, тооцоо, бэлэн мөнгө, тайлан зэргийг цахим болон бусад хэлбэрээр ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгөх үүрэгтэй байна. |
| **Хууль эрх зүйн орчинтой холбоотой эрсдэлийн удирдлага** | ▪ Хөндлөнгийн хуулийн зөвлөхийн дүгнэлтийн дагуу, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь аливаа хууль эрх зүйн зөрчилгүй байгаа ба цаашид хууль тогтоомж, журам, зохицуулалттай холбоотой эрсдэлийг удирдах үүднээс Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хөндлөнгийн хуулийн зөвлөхийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллахаар “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-д тусгасан байна. |
| **Зах зээл дэх хүүгийн түвшний эрсдэлийн удирдлага** | ▪ Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээ тогтмол байх хэдий ч үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар зах зээл дэх хүүгийн түвшнээс харьцангуй өндөр байна. Мөн хөрөнгө оруулагч нь энэхүү үнэт цаасанд хөрөнгө оруулснаар улирал тутам хүүгийн төлбөр, хагас жил тутам үндсэн төлбөрийг хүлээж авах ба үүнийг дахин хөрөнгө оруулах замаар хүүгийн түвшний эрсдэлээ бууруулах боломжтой байна. |
| **Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл** | ▪ Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс үүсэх эрсдэлтэй холбогдуулан Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллагыг хөлслөн ажиллуулах, эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулах;<br>▪ Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухай Үнэт цаас эзэмшигчдэд брокерийн компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, Үнэт цаас гаргагч болон Биржийн цахим хуудсаар олон нийтэд |

TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна. Мөн, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөхгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн үүрэг биелүүлэх хугацаа нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч болох “Бичил Эй Би Эс Актив” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Компанийн тухай хуулийн 62 дугээр зүйлийн 62.1.16 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг болон Үүсгэн байгуулагчийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 5-р сарын 25-ны өдрийн “Шинээр охин компани үүсгэн байгуулах тухай” 22/04а/23 тоот тогтоолоор үүсгэн байгуулагдсан байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь Хорооны 2022 оны 8-р сарын 10-ны өдрийн 416 тоот тогтоолоор олгогдсон ТЗ 315/48 дугаартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Тусгай зориулалтын компани буюу “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК болж үйл ажиллагааны чиглэл болон компанийн нэршил өөрчлөгдсөн ба тус тусгай зөвшөөрлийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байхаар тогтоожээ.

### Хөрөнгийн багц ба түүнд тавигдах шалгуур үзүүлэлт

Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд 2022 оны 9-р сарын 27-ны өдөр байгуулсан 22/499 тоот “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-д Үнэт цаас гаргагч нь гэрээний хүрээнд тохиролцсон шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд буюу Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөхөөр заасан байна.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-нд тусгасан нөхцөл, Санхүүгийн 24 болон Хуулийн 11 шалгуур үзүүлэлтийг хангасан байх ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй талуудтай хамтран ажиллах үүрэг хүлээхээр тусгажээ.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Зээлийн шинжилгээ гаргагч байгууллага болох “Онч аудит” ХХК, Хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Хуулийн фирм болох Өмгөөллийн “Ди Би Энд Жи Ти Эс” ХХН шалгаж, бие даасан хараат бус дүгнэлт гаргасан байна.

Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд гаргаж буй ХБҮЦ-ны баталгаа болох Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багц нь 761 зээлдэгчийн нийт 11.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, Санхүү болон Хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан 761 зээлийн гэрээнээс бүрдсэн ба тасалбар болгох өдрийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт 4: Хөрөнгийн багцын тойм мэдээлэл**

| Тасалбар болгох өдрийн байдлаарх Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| Үзүүлэлт | Дүн |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн төрөл** | Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн чанар** | 100 хувь хэвийн төлөлттэй зээлийн хөрөнгө |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

| | |
|---|---|
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл дүн** | 10,963,908,275 төгрөг |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн** | 14,207,607,000 төгрөг |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн тоо** | 761 зээл |
| **Хөрөнгийн багц дахь зээлдэгчдийн тоо** | 761 зээлдэгч |
| **Хөрөнгийн багц дахь зээлийн дундаж үлдэгдэл** | 14,407,238 төгрөг |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| **Жигнэсэн дундаж хүү /сар/** | 2.8% |
| **Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа** | 37 сар |
| **Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа** | 28 сар |
| **Жигнэсэн дундаж LTV** | 56.2% |

## Хөрөнгийн багцын төвлөрөл

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдэл дүн нь нийт 11.0 тэрбум төгрөг байгаагаас, 10 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 1.2 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 10.7 хувийг, 10-20 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 6.4 тэрбум төгрөг буюу 58.0 хувийг, 20-30 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй зээл 3.1 тэрбум төгрөг буюу 27.9 хувийг, 30 сая төгрөгөөс дээш үлдэгдэл дүнтэй зээл 0.4 тэрбум төгрөг буюу 3.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

**Зураг 1: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үлдэгдлийн тархалт**




Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд багтах үнийн дүнгээр хамгийн том 1 зээл нь нийт багцын 0.5%, хамгийн том 10 зээл 3.5%, хамгийн том 50 зээл 12.5%-ийг тус тус бүрдүүлж байгаа нь Хөрөнгийн багцын төвлөрөл бага буюу төвлөрлийн эрсдэл бага байгааг харуулж байна.

## Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огноо

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн 14.2 тэрбум төгрөг байгаагаас 27.3 хувь нь 2021 оны 2 болон 3-р улиралд олгосон зээл, 42.8 хувь нь 2021 оны 4-р улиралд олгосон зээл, үлдсэн 29.8 хувь нь 2022 онд олгосон зээл байна. Өөрөөр хэлбэл, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүд нь олгосон хугацааны хувьд харьцангуй шинэ зээлүүд байна.

**Зураг: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огнооны тархалт**




ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
өдөр
БҮРТГЭВ
№

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

**Хүснэгт: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон огноо**

| Анх олгосон огноо | | Зээлийн тоо | | Анх олгосон зээлийн дүн | |
|---|---|---|---|---|---|
| | | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 4/1/2021 | 6/30/2021 | 69 | 9.1% | 946,440 | 6.7% |
| 7/1/2021 | 9/30/2021 | 139 | 18.3% | 2,430,040 | 17.1% |
| 10/1/2021 | 12/31/2021 | 326 | 42.8% | 6,127,943 | 43.1% |
| 1/1/2022 | 3/31/2022 | 171 | 22.5% | 3,349,697 | 23.6% |
| 4/1/2022 | 6/30/2022 | 30 | 3.9% | 739,982 | 5.2% |
| 7/1/2022 | 9/4/2022 | 26 | 3.4% | 613,505 | 4.3% |

### Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт дуусах огноо

Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн хуваарь тасалбар болгох өдрийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт: Хөрөнгийн багцын эргэн төлөгдөх хуваарь**

| Зээлийн хөрөнгийн эргэн төлөлт дуусах огноо | Зээлийн тоо | | Үлдэгдэл дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| **2024 он** | | | | |
| II улирал | 70 | 9.2% | 658,786 | 6.0% |
| III улирал | 141 | 18.5% | 1,728,880 | 15.8% |
| IV улирал | 319 | 41.9% | 4,582,235 | 41.8% |
| **2025 он** | | | | |
| I улирал | 170 | 22.3% | 2,647,993 | 24.2% |
| II улирал | 12 | 1.6% | 268,576 | 2.4% |
| III улирал | 11 | 1.4% | 244,932 | 2.2% |
| IV улирал | 6 | 0.8% | 111,058 | 1.0% |
| **2026 он** | | | | |
| II улирал | 17 | 2.2% | 381,909 | 3.5% |
| III улирал | 15 | 2.0% | 339,40 | 3.1% |
| **Нийт** | **761** | **100.00%** | **10,963,908** | **100.0%** |

### Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшин

Хөрөнгийн багц дахь нийт 14.2 тэрбум төгрөгийн анх олгосон дүнтэй, 761 зээлийн хөрөнгөөс 108 зээлийн хөрөнгө буюу анх олгосон дүнгээр 13.7 хувь нь сарын 2.0-2.5 хувийн хүүтэй, 601 зээлийн хөрөнгө буюу анх олгосон үнийн дүнгээр 79.7 хувь нь сарын 2.5-3.0 хувийн хүүтэй, үлдсэн 52 зээлийн хөрөнгө буюу анх олгосон үнийн дүнгээр 6.6 хувь нь сарын 3.0-3.5 хувийн хүүтэй байна. Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувь, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүдийн хамгийн бага сарын хүү 2.3 хувь байгаа нь санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

**Хүснэгт 5: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшний тархалт**

| Хүүгийн түвшин | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ /ширхэг/ | Хувь | Дүн /Мянган төгрөг/ | Хувь |
| 1.5-2.0% | - | 0.0% | - | 0.0% |
| 2.0-2.5% | 108 | 14.2% | 1,940,340 | 13.7% |
| 2.5-3.0% | 601 | 79.0% | 11,330,027 | 79.7% |
| 3.0-3.5% | 52 | 6.8% | 937,240 | 6.6% |
| **Нийт** | **761** | **100.0%** | **14,207,607** | **100.0%** |
| **Хамгийн их** | **3.5%** | | | |
| **Хамгийн бага** | **2.3%** | | | |
| **Жигнэсэн дундаж дүн** | **2.8%** | | | |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий зураглал**

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасжуулах хэлцлийг амжилттай хэрэгжүүлснээр үндсэн үйл ажиллагаа нь дараах зураглалын хүрээнд явагдана.

**Зураг: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий зураглал**




**Тайлбар:**

1. Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсны хүрээнд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг Зээлдэгчдээс цуглуулан, Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд хуримтлуулна;
2. Үйлчилгээ үзүүлэгч сар бүр хуримтлагдсан зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах дансанд дараа сарын 15-ны дотор шилжүүлнэ;
3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасны төлбөр болон үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлнө;
4. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" байгуулах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээ болон Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" болон бусад журмуудад нийцүүлэн Үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэнэ;
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийг төлөөлж Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлт цуглуулах дансыг барьцаалах бөгөөд Зээлийн эргэн төлөлт, Багцын эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана;
6. Үнэт цаас гаргагчийн холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу эрх бүхий байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад тогтоосон хугацаанд хүргэж ажиллах;
7. Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн аудитортой гэрээ байгуулах замаар үйл ажиллагаанд аудит хийлгэнэ.

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2022 оны 7 сарын 05-ны 22/23а/07 тоот болон 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/16 тоот тогтоолоор дараах үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах журмуудыг баталсан байна. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
- Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;

TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
- Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам.

**Үнэт цаас гаргагчийн төлбөрийн дараалал**

Тус журмын дагуу Үнэт цаас гаргагч нь төлбөр төлөхдөө дараах дарааллыг баримтлах ба тогтоосон хугацаанд нэг дор холбогдох төлбөрийг төлнө. Үүнд:

- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр
- Хөндлөнгийн аудитын төлбөр
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал
- Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр
- Бусад Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлууд
- Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д заасны дагуу сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг байршуулах

**Холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагуудад төлөх үүрэг хүлээж буй төлбөр болон Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулахтай холбоотой үүсэх зөрүүг Төлбөрийн дарааллыг харгалзахгүй тухай бүр төлж барагдуулна.*

**Үнэт цаас гаргагч татан буугдах тухай**

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий тусгай зориулалтын компани тул Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны холбогдох журам болон Компанийн дүрэмд тусгасны дагуу дараах тохиолдолд татан буугдана. Үүнд:

- Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн
- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан
- Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан

Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн эсвэл баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан тохиолдолд татан буулгах шийдвэрийг Үнэт цаас гаргагч эсхүл Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч гаргана.

Үнэт цаас гаргагч нь баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан тохиолдолд Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх татан буулгах шийдвэрийг гаргахаар байна.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 22/23а/17 тоот "Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай" тогтоолоор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны буюу 2022-2024 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

### Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлын тайланг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлтийг нэгтгэн дараах байдлаар төлөвлсөн байна.

**Хүснэгт: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл**

| Үзүүлэлт | Улирал | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 0 | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| Бэлэн мөнгө | 1.0 | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 | 1,041.8 |
| Нийт зээл | 10,963.9 | 10,486.9 | 9,558.2 | 8,409.0 | 7,114.0 | 5,733.3 | 4,320.5 | 3,073.1 | 2,042.1 |
| Эрсдэлийн сан | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **10,964.9** | **12,028.0** | **9,843.7** | **10,124.3** | **7,838.6** | **8,005.8** | **5,582.8** | **5,596.2** | **3,083.9** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 10,000.0 | 10,000.0 | 7,500.0 | 7,500.0 | 5,000.0 | 5,000.0 | 2,500.0 | 2,500.0 | - |
| Бусад өглөг | 963.9 | 1,700.5 | 1,686.5 | 1,661.0 | 1,626.9 | 1,586.4 | 1,509.6 | 1,394.3 | 1,297.9 |
| **Өр төлбөрийн дүн** | **10,963.9** | **11,700.5** | **9,186.5** | **9,161.0** | **6,626.9** | **6,586.4** | **4,009.6** | **3,894.3** | **1,297.9** |
| Хувьцаат капитал | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 |
| Хуримтлагдсан ашиг | - | - | 326.4 | 656.1 | 962.2 | 1,210.7 | 1,418.5 | 1,572.2 | 1,700.9 |
| Татварын дараах ашиг | - | 326.4 | 329.7 | 306.1 | 248.5 | 207.7 | 153.7 | 128.7 | 84.1 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **1.0** | **327.4** | **657.1** | **963.2** | **1,211.7** | **1,419.5** | **1,573.2** | **1,701.9** | **1,786.0** |
| **Өр төлбөр ба эзний өмч** | **10,964.9** | **12,028.0** | **9,843.7** | **10,124.3** | **7,838.6** | **8,005.8** | **5,582.8** | **5,596.2** | **3,083.9** |

### Мөнгөн гүйлгээний төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн 2022-2024 оны буюу үйл ажиллагаа явуулах хугацааны мөнгөн урсгалын төлөвлөгөө дараах байдалтай байна.

**Хүснэгт: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний төсөөлөл**

| Үзүүлэлт | Улирал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| Хүүгийн орох мөнгөн урсгал | 922.8 | 830.5 | 728.9 | 615.0 | 493.8 | 369.8 | 254.4 | 159.2 |
| Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал | 2,241.4 | 2,187.8 | 2,122.1 | 2,027.7 | 1,912.1 | 1,745.0 | 1,405.5 | 1,095.8 |

СЭХ
сар өдөр
БҮРТГЭВ
№

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХБҮЦ-ны үндсэн төлбөр | | (2,500.0) | | (2,500.0) | | (2,500.0) | | (2,500.0) |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр | (437.5) | (437.5) | (328.1) | (328.1) | (218.8) | (218.8) | (109.4) | (109.4) |
| Үйл ажиллагааны зардал | (148.7) | (91.7) | (90.0) | (84.8) | (88.8) | (71.6) | (60.2) | (50.1) |
| Татварын зардалд төлсөн төлбөр | (36.3) | (36.6) | (34.0) | (27.6) | (23.1) | (17.1) | (14.3) | (9.3) |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **2,541.8** | **(47.4)** | **2,398.9** | **(297.9)** | **2,075.2** | **(692.6)** | **1,476.0** | **(1,413.7)** |
| Хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүгийн орлого | 26.1 | 65.0 | 29.3 | 74.1 | 44.6 | 91.3 | 58.2 | 93.7 |
| Банкны хадгаламж | 9.8 | 24.4 | 11.0 | 27.8 | 16.7 | 34.2 | 21.8 | 35.2 |
| Үнэт цаасны хөрөнгө оруулалт | 16.3 | 40.6 | 18.3 | 46.3 | 27.9 | 57.1 | 36.4 | 58.6 |
| Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт | (1,026.8) | (1,273.1) | (998.5) | (766.8) | (572.0) | (408.9) | (273.3) | (161.3) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **(1,000.8)** | **(1,208.1)** | **(969.2)** | **(692.7)** | **(527.4)** | **(317.6)** | **(215.1)** | **(67.6)** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1.0 | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,541.0 | 285.5 | 1,715.2 | 724.7 | 2,272.5 | 1,262.3 | 2,523.1 | 1,041.8 |

### Орлого, зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс сар бүр хүлээн авах Багцын эргэн төлөлтөөс орох орлого болон Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны төлбөр болон үйл ажиллагаатай холбоотой гарах зардлуудад үндэслэн орлого, зардал болон мөнгөн урсгалаа дараах байдлаар төлөвлөсөн байна.

**Хүснэгт: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл**

| Үзүүлэлт | Улирал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII |
| Багцын эргэн төлөлтийн орлого | 948.9 | 895.5 | 758.2 | 689.0 | 538.4 | 461.2 | 312.5 | 252.9 |
| ХБҮЦ-ны төлбөр | 437.5) | (437.5) | (328.1) | (328.1) | 218.8) | (218.8) | 109.4) | 109.4) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **511.4** | **458.0** | **430.1** | **360.9** | **319.7** | **242.4** | **203.2** | **143.6** |
| Үйл ажиллагааны зардал | (148.7) | (91.7) | (90.0) | (84.8) | (88.8) | (71.6) | (60.2) | (50.1) |
| **Татварын өмнөх ашиг** | **362.7** | **366.3** | **340.1** | **276.1** | **230.8** | **170.8** | **143.0** | **93.5** |
| Татвар | (36.3) | (36.6) | (34.0) | (27.6) | (23.1) | (17.1) | (14.3) | (9.3) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **326.4** | **329.7** | **306.1** | **248.5** | **207.7** | **153.7** | **128.7** | **84.1** |

Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд шилжих буюу анх худалдан авах үед тавигдсан холбогдох шаардлага, шалгуурыг хангахгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” болон “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн хөрөнгийг холбогдох шаардлага, шалгуурыг хангасан зээлийн хөрөнгөөр солих, солих боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах үүрэгтэй билээ. Өөрөөр хэлбэл, Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хэвийн ангилал бүхий зээлийн хөрөнгөөс бүрдэх болно.

**Хүснэгт: Үнэт цаас гаргагчийн зардлын төсөөлөл**

СЗХ
сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

| № | Зардлын зориулалт | Дүн | Давтамж |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр | Удирдаж буй хөрөнгийн нийт 0.5 хувь | Улирал бүр |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр | Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь | Улирал бүр |
| 3 | Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр | Жилд 10 сая төгрөг | Жил бүр |
| 4 | ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал | Нийт 24 сая төгрөг | Улирал бүр |
| 5 | Зээлийн програм хангамжийн төлбөр | Нийт 15.5 сая төгрөг | Нэг удаа |
| | | Сард 4.5 сая төгрөг | Улирал бүр |
| 6 | Захиргааны зардал | Сард 1.5 сая төгрөг | Улирал бүр |

*Эхний 6 сар 50%-ийн хөнгөлөлттэй.*

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ / АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

**"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК** нь анх 2008 онд үүсгэн байгуулагдаж, бичил зээлийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор, 3 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар төв оффис болон 16 салбар, 63 ажилтан, 5.5 мянган зээлдэгч, 6.5 мянган харилцагчтай томоохон банк бус санхүүгийн байгууллага болон өргөжин тэлжээ. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тус компани нь зээл, факторингийн үйл ажиллагаа болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь автомашин худалдан авахад зориулсан зээл, автомашин, үл хөдлөх хөрөнгө болон утасны дугаар барьцаалсан зээл гэсэн үндсэн 4 төрлийн зээлийн үйлчилгээг харилцагчдадаа санал болгон, түргэн шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж байна.

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрх бүхий байгууллагын санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажилладаг бөгөөд эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

**Хүснэгт: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөг**

**Нийт хөрөнгө**




**Өөрийн хөрөнгө**




**Цэвэр зээл**

**Хүүгийн орлого**

СЗХ
2022 оны 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 0

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03







**Цэвэр хүүгийн орлого**

**Цэвэр ашиг**







*Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлан, Санхүүгийн зохицуулах хороо*

**Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2022 оны эхний хагас жилийн байдлаар дараах байдалтай байна.

**Хүснэгт 6: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд**

**Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт**




**Санхүүгийн хөшүүрэг, хүү төлөх чадварын харьцаа**



СЗХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

**ББСБ салбартай харьцуулсан үзүүлэлт, 2022 оны II улирал**




*Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн тайлан, Санхүүгийн зохицуулах хороо*
**Тус харьцаа үзүүлэлтийг 2022 оны 2-р улирлын цэвэр ашигийн түвшинд тооцоолов.*

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлага**

**Хүснэгт: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн удирдлага**

| | |
|---|---|
| **Макро эдийн засгийн эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтмол хянан, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдал, эрсдэл даах чадварыг үнэлж, зээлийн багцын төвлөрлөөс сэргийлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуурыг хангах, мөн холбогдох журмуудыг мөрдлөг болгох зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг. Мөн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд оновчтой нэвтрүүлэх замаар тогтвортой орлогын суурийг бий болгон ажиллана. |
| **Хууль эрхзүйн орчин, зохицуулалтын эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдөх замаар эрхзүйн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. |
| **Зээлийн эрсдэл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшинг тооцон, зээлийн үнэ цэнийн бууралт, чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажилладаг. Мөн гаргасан зээлийн хувьд тогтмол хяналт тавин үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг. |
| **Хүүгийн эрсдэл** | Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээлийн хүүгийн нөхцөл байдлын шинжилгээ болон бусад зохистой харьцаа, хязгаар үзүүлэлтийг харгалзан зээлийн хүүг эх үүсвэрийн өртөгтэй уялдуулан тогтоодог. |
| **Үйл ажиллагааны эрсдэл** | Дотоод үйл ажиллагаа, хяналтын систем, хүний хүчин зүйл болон технологийн доголдлоос бий болж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг. |
| **Төлбөрийн болон хөрвөх чадварын эрсдэл** | Хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон дотоодын санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг. Мөн эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна. |

TDB SECURITIES

ДҮГНЭЛТ

Андеррайтер болох "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд өөрсдийн хийсэн судалгаа, шинжилгээ, тооцоолол болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төслийн хүрээнд хөндлөнгийн зөвлөх байгууллагууд болох Зээлийн шинжилгээ гаргагч аудитын байгууллагын тайлан, Хуулийн зөвлөхийн хуулийн дүгнэлт болон холбогдох бусад баримт материалд үндэслэн "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий 100,000 ширхэг хүртэлх ХБҮЦ-ыг биржийн зах зээлд гаргах боломжтой буюу нийт 10.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэн энэхүү тодорхойлох захидлыг гаргалаа.

Энэхүү тодорхойлох захидал нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, Үнэт цаасны танилцуулга, холбогдох эрсдэл, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

**ТОДОРХОЙЛОХ ЗАХИДЛЫГ ГАРГАСАН**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ОДМАА

ДЭД ЗАХИРАЛ Г. ЭНХБАТ

2022 .11. 09 өдөр
БҮРТГЭВ
01

2022 -11- 15
БҮРТГЭВ-03

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000260063

2022.05.27
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011840095
/ Хувийн хэргийн дугаар /

6875351
/ Регистрийн дугаар /

Бичил Эй Би Эс актив ТЗК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2022.05.25 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 66300 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
|---|---|
| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 1 | 1,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 705 тоот, Утас1: 99119632, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тэмдэг/ С.МӨНХСАНЧИР /гарын үсэг/

МОНГОЛ УЛС 376 MONGOLIA МОНГОЛ УЛС

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 08 сар 26 өдөр

138

СЗХ
ҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн Огноо | Бүртгэсэн Ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| 1 | *Самдан овогтой Отгонбат-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2022.05.27* | *Н.Энхтуяа* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2022.08.26* | *С.Мөнхсанчир* |
| 3 | *Шинэчилсэн дүрэм бүртгэв.* | *2022.10.31* | *Т.Зулзаяа* |

МОНГОЛ УЛС
MONGOLIA
376
МОНГОЛ УЛС

2022 он 11 сар 10 сдор Бүртгэлийн № 2784
Нийслэлийн тойргийн нотариатч
М.Хишигбаатар би энэ хуулбарын
үнэн зөвийг гэрчилэв.
Нотариатч ....................

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000260063

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
2022 .. сар .. өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БҮРТГЭГЧ 575
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар 9011840095
2022 оны 10 сарын 31 өдөр
Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэгчийн гарын үсэг

# “БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494

МОНГОЛ УЛС
MONGOLIA
376

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. **“Бичил Эй Би Эс Актив ТЗК”** ХХК /цаашид **“Компани”** эсхүл **“ТЗК”** гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид **“Дүрэм”** гэх/, Санхүүгийн Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа явуулах эрхтэй, бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж үүрэг хүлээх хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2. Компанийн оноосон нэр:

1.2.1. Монгол хэл дээрх бүтэн нэр: **“Бичил Эй Би Эс актив Тусгай Зориулалтын Компани”** ХХК, товчилсон нэр нь **“Бичил Эй Би Эс актив ТЗК”** ХХК

1.2.2. Англи хэл дээрх бүтэн нэр: **“Bichil ABS Active Special Purpose Company”** LLC , товчилсон нэр нь **“Bichil ABS Active SPC”** LLC

1.3. Компанийн оршин байгаа газар:

- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот
- Харилцах утасны дугаар: 99119632

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

| Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|
| “Бичил глобус финанс ББСБ” ХХК | 5729718 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот | 99119632 |

1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Компани нь ажилтан авч ажиллуулахгүй бөгөөд өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тоогоор илэрхийлэгдэх ба тэдгээрийг боломжит эх үүсвэрээр хангах боломжтой байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан тусгай зориулалтын компани байх бөгөөд эрхлэх цорын ганц үйл ажиллагаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө худалдан авах, автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах болон тухайн баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой буюу тэдгээрийн дагуу хийгдэх Дүрмийн 2.6-д зааснаас бусад үйл ажиллагаа байна.

2.2. Компани нь үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтална.

2.3. Компанийн зорилго: Компани нь автомашин барьцаалсан зээлүүдийг багцлан худалдан авч, тэдгээрийг ТЗК-ийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан Автомашин барьцаалсан зээлүүдийн төлбөрийг төлөх үүднээс автомашин барьцаалсан зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргана.

2.4. Компани нь хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн авах замаар баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших эрхтэйг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.5. Компани нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

2.5.1. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах;
2.5.2. Автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах;
2.5.3. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах болон автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой гэрээ, хэлцлийг байгуулах;
2.5.4. Баталгаат үнэт цаас гаргаснаар түүний төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг байгуулах;
2.5.5. Компанийн бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад гэрээг байгуулах;
2.5.6. Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт заасан компанийн аливаа үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
2.5.7. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн эрсдэлийг удирдах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
2.5.8. Мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, дотоодын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаасыг худалдан авах, худалдах, шалгуур хангасан банкны хадгаламж, харилцах дансанд байршуулах;
2.5.9. Шаардлагатай тохиолдолд үнэт цаасны эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ авах;
2.5.10. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдах;
2.5.11. Үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан баримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай холбогдох шийдвэр гарсанаас хойш 10 жилийн хугацаанд өөр дээрээ хадгалах;
2.5.12. Хууль болон Дүрэмд заасан бусад;

2.6. Компани дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

2.6.1. Хууль болон Дүрэмд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх;
2.6.2. Хууль болон Дүрэмд зааснаас бусад үйл ажиллагаатай холбоотой үүрэг бусдын өмнө хүлээх, өр үүсгэх;
2.6.3. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;
2.6.4. Хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно;
2.6.5. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дуусаагүй байх үед Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;
2.6.6. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;
2.6.7. Хорооны зөвшөөрөлгүйгээр Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
2.6.8. Хуульд заасан бусад.

## ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БА ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

3.1. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000 (нэг мянга) ширхэг хувьцаа зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх нийт 1,000,000 (нэг сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно.

3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах байдлаар гаргасан хувьцааг эзэмшинэ. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчийн нэр, регистр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/ | | |
| | | Нэгжийн үнэ | Бүгд үнэ | |
| "Бичил глобус финанс ББСБ" ХХК /РД: 5729718/ | 1,000 | 1,000 | 1,000,000 | 100% |
| **Нийт** | **1,000** | **1,000** | **1,000,000** | **100%** |

3.3. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам болон энэ Дүрэмд заасантай зөрчилдөхгүй эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.4. Компанийн хувьцаа эзэмшигч нь Санхүүгийн зохицуулах хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

3.5. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багагүй байна.

3.6. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор аливаа хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл хууль болон Дүрмийн 8.2-т зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "ХЭХ" гэх/:

4.1.1. Компанийн эрх барих, удирдах дээд байгууллага нь ХЭХ байх ба хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хууль заасан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журамд заасанбүрэн эрхийг энэхүү Дүрмийн 3.2-т заасан хувьцаа эзэмшигчдээс төлөөлөх эрх олгогдсон этгээд хэрэгжүүлнэ.
4.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна
4.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэгт заасны дагуу жил бүр, ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэж хуралдуулна.
4.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гарснаас хойш 5-аас доошгүй хоногийн дараа ХЭХ-ыг хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд уг хугацаанаас өмнө хуралдуулж болно.
4.1.5. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрх нь түүний эзэмшиж буй хувьцааны хувьтай хувь тэнцүү байна.

4.1.6. ХЭХ-ын зар мэдээг хурал хуралдахаас өмнө 3-аас доошгүй хоногийн өмнө хүргэнэ.
4.1.7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн олонх оролцсоноор ХЭХ хүчин төгөлдөр болно.
4.1.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг Компанийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
4.1.9. Дараах асуудлыг зөвхөн ХЭХ-аар шийдвэрлэнэ. Үүнд:
4.1.9.1. Хорооны зөвшөөрлийг үндэслэн Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах ба энэ тохиолдолд Компани нь Дүрэмд нэмэлт өөрчлөлтийг хөрөнгө оруулагчдад ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх;
4.1.9.2. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
4.1.9.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
4.1.9.4. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
4.1.9.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
4.1.9.6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
4.1.10. Хуульд заасан бусад.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/:

4.2.1. Компанийн ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн ТУЗ хэрэгжүүлнэ.
4.2.2. Компанийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
4.2.3. Компанийн ТУЗ нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.
4.2.4. Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.
4.2.5. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн дийлэнх олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүн байна.
4.2.6. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр нөхөн сонгоно.
4.2.7. ТУЗ-ийн гишүүдэд тавих шаардлага болон ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх болон ТУЗ-ийн үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулна.
4.2.8. Компанийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хэдийд ч хуралдуулж болно.
4.2.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор шийдвэр хүчин төгөлдөр болно.

1.2.20. **“Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ”** гэж Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн Баталгаат үнэт цаас гаргах замаар худалдаж авсан Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлохоор байгуулсан гэрээг;

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

1.2.21. **“Үнэт цаасны танилцуулга”** гэж Үнэт цаас гаргагчаас Баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, арилжаалах зорилгоор холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулсан үнэт цаасны танилцуулгыг;

1.2.22. **“Фидуцийн гэрээ”** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчид олгох Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгын хүрээнд байгуулсан хөдлөх эд хөрөнгө болох автомашиныг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх гэрээг;

1.2.23. **“Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ”** гэж энэхүү Гэрээний 2.5.1 дэх хэсэгт заасан Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээг;

1.2.24. **“Фидуцийн зүйл”** гэж Зээлдэгчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн автомашиныг;

1.2.25. “**Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн сан**” гэж Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хуулийн 35-р зүйлийн 35.1-т заасан хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх улсын бүртгэлийн байгууллагын цахим мэдээллийн санг;

1.2.26. **“Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хууль”** гэж Монгол Улсын Их хурлаас 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хуулийг;

1.2.27. **“Хөрөнгө”** гэж Гэрээний 2.1.1 дэх заалтад тодорхойлсон Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүдийг;

1.2.28. **“Хөрөнгийн багц”** гэж Гэрээний 2.1.1 дэх заалтад заасан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдаж буй Хөрөнгийг багц болгосныг;

1.2.29. **“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”** гэж Үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан этгээдийг;

1.2.30. **“Хөрөнгийн жагсаалт”** гэж энэхүү Гэрээний Хавсралт 2-т тусгагдсан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдаж буй Хөрөнгийн жагсаалтыг;

1.2.31. **“Хөрөнгө оруулалтаас татан төвлөрүүлэх дүн”** гэж Үнэт цаас гаргагч нь Баталгаат үнэт цаасыг гаргаж, анхдагч зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах замаар татан төвлөрүүлэх 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүнг;

1.2.32. **“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”** гэж Монгол Улсын Их хурлаас 2010 оны 4-р сарын 23-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг;

1.2.33. **“Хэлцэл”** гэж Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгад заасан Баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах замаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгийн багц худалдан авахад шаардлагатай мөнгөн дүнг хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх үйл ажиллагааг;

1.2.34. **“Хэлцэл биелэх үнэ”** эсхүл **“Үнэ”** гэж Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийг худалдан авах үнэ нь Үнэт цаас гарагч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг гаргаж, анхдагч зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах замаар хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн дүн байх ба 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх хэмжээтэй байна;

1.2.35. **“Хэлцэл биелэх өдөр”** гэж Үнэт цаас гарагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Гэрээний 3.1.1 дэх заалтад заасны дагуу Үнийг төлж, Гэрээний 2.4 дэх хэсэгт заасны дагуу Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцох өдрийг;

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

1.2.36. **“Шаардлага хангахгүй хөрөнгө”** гэж Гэрээний 4.2.1 дэх заалтад заасан нөхцөл бүхий хөрөнгийг;

1.2.37. **“Шалгуур үзүүлэлт”** гэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг;

1.2.38. **“Хороо”** гэж Санхүүгийн зохицуулах хороог;

1.2.39. **“Бирж”** гэж Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг;

1.2.40. **“Эрх бүхий байгууллага”** гэж Хороо, Бирж, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид “Төвлөрсөн хадгаламжийн төв” гэх), “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК (цаашид “Төлбөр тооцооны байгууллага” гэх), нээлттэй зах зээлд үнэт цаас гарган арилжаалахтай холбоотой ажилд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа болон бусад төрийн эрх бүхий байгууллагыг.

## ХОЁР. ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ ҮНДСЭН НӨХЦӨЛ

**2.1. Худалдах хөрөнгө**

2.1.1. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр дор дурдсан Хөрөнгийг Хөрөнгийн багц болгон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч, энэхүү Гэрээнд заасан Үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдахаар харилцан тохиролцов. Үүнд:

2.1.1.1. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлийн хөрөнгийн хувьд түүний авлагын шаардах эрх буюу Зээлийн гэрээний дагуу Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү зэрэг төлбөрийг шаардах, төлбөр цуглуулах, нэхэмжлэл гаргах, Зээлийн төлөлтийг хүлээж авахтай холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхүүд, мөн холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд;

2.1.1.2. Автомашины зээлийн авлагын шаардах эрхийг баталгаажуулж буй Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлүүдийн өмчлөх эрхийг барьцаалах, энэхүү Гэрээнд заасан барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж, захиран зарцуулахтай холбоотой бүхий л эрх;

2.1.1.3. Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хохирол нөхөн төлөхийг шаардах эрх;

2.1.1.4. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлийн хөрөнгөтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, Эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, Зээлдэгч болон түүний хамтран зээлдэгч бусад Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдэд холбогдуулан шаардлага гаргах, шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх;

2.1.1.5. Зээлийн хөрөнгөтэй холбоотой бүхий л баримт бичгүүд, үүнд зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ, Фидуцийн хөрөнгөтэй холбоотой баримт бичиг болон бусад зээл, барьцаа, батлан даалтын хөрөнгөтэй холбоотой баримт бичгүүдийг шилжүүлэн авч, хадгалах эрх.

**2.2. Худалдах хөрөнгийн хэмжээ**

2.2.1. Энэхүү Гэрээний дагуу худалдах Хөрөнгийн хэмжээг Хэлцэл биелэх өдрийн байдлаарх Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох ба уг дүн нь Хэлцэл биелэх үнээс багагүй байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**2.3. Хөрөнгөд тавигдах шалгуур**

2.3.1. Хөрөнгийн жагсаалтад тусгасан Автомашины зээлийн хөрөнгө болон Хөрөнгийн багц нь энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц болон Автомашины зээлийн хөрөнгө нь энэхүү Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан нөхцөл болон 2.3.1 дахь заалтад заасан Шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг Хэлцэл биелэх өдрөөс өмнө баталгаажуулах зорилгоор Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, зээлийн шинжилгээ гаргагч, андеррайтер, хуулийн зөвлөх болон бусад шаардлагатай этгээдтэй хамтран ажиллана.

**2.4. Хөрөнгө шилжүүлэх буюу худалдах**

2.4.1. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээнд заасан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн төлж, энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийг энэхүү Гэрээний 2.5.1 дэх заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагчийн өмчлөлд бүрэн шилжүүлнэ.

2.4.2. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдрөөс хойш Ажлын 3 өдөрт багтаан Гэрээний 2.5.1 дэх заалтад заасан Хөрөнгийн бүртгэлийг хийнэ.

2.4.3. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдрөөс хойш Ажлын 3 өдөрт багтаан Гэрээний 2.6 дахь хэсэгт заасан барьцаа хөрөнгийн бүртгэлийг Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

2.4.4. Энэхүү Гэрээний 2.4.3 дахь заалтад заасан Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой гарах зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч төлөх үүрэгтэй.

2.4.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцын бүх эрх, ашиг сонирхол, үр ашгийн цорын ганц, эрхийн доголдолгүй эцсийн өмчлөгч тул Хэлцэл биелэх өдрийн байдлаар болон уг өдрөөс хойших хугацаанд аливаа эрхийн доголдолгүй Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжүүлнэ.

**2.5. Хөрөнгийн бүртгэл**

2.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу Үнэт цаас гаргагчид худалдсан Хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд холбогдох эрхүүдийн хамт шилжүүлэн бүртгэх үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлнэ.

2.5.2. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний Хавсралт 2-т заасан Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн бүртгэлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлнэ. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай бүр Хөрөнгийн жагсаалтыг шинэчилнэ.

**2.6. Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа**

2.6.1. Үнэт цаас гаргагч нь худалдан авч буй Хөрөнгийн багц дахь Автомашины зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийг баталгаажуулах зорилгоор Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг гэрээний хүрээнд худалдаж буй Хөрөнгийн багц дахь Автомашины зээлийн хөрөнгийн Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчид барьцаалуулна. Ингэхдээ Зээлдэгчээс зөвшөөрөл

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

авах шаардлагатай бол Анхны үүрэг уг зөвшөөрлийг авах ажлыг өөрийн зардлаар, бие даан хариуцна.

2.6.2. Талууд нь энэхүү Гэрээний 2.6.1 дэх заалтад заасан Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний хавсралтаар Фидуцийн зүйл болох автомашинуудын жагсаалтыг баталж, Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний 2.4.3 дахь заалтад заасны дагуу холбогдох бүртгэлийг эрх бүхий байгууллагад хийлгүүлэх бөгөөд уг жагсаалтад тусгагдсан Фидуцийн зүйлийн мэдээлэл болон холбогдох бүртгэлийг Хөрөнгийн багцад өөрчлөлт орох тухай бүрт шинэчилнэ. Бүртгэлийг хийлгүүлэхтэй холбоотой гарах зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.

2.6.3. Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасны дагуу Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг үл маргах журмаар шилжүүлэн авах эрхтэй бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг өмчлөх эрхийн дагуу Фидуцийн гэрээнд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүхий л эрхийг хэрэгжүүлж, фидуцийн зүйлийг захиран зарцуулах эрхтэй байна.

2.6.4. Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл үүссэн тухай мэдсэн даруй Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдсоноор тухайн мэдэгдэлд заасан хугацааны дотор Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэх буюу шилжсэнд тооцож, эрх бүхий байгууллагын Хөрөнгийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажиллагааг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хийж гүйцэтгэх эрхтэй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон бусад шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэхүү үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

2.6.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасан Фидуцийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэхгүй, барьцаалахгүй болон бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй, түүний эрхийн байдлыг доройтуулахгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлээс барьцааны шаардлагыг хангуулах эрхтэй цор ганц эрх бүхий этгээд байна.

## ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

**3.1. Хөрөнгө худалдан авах үнэ**

3.1.1. Энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийг худалдан авах үнэ нь Үнэт цаас гарагчийн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах замаар хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн дүн байх буюу 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх хэмжээтэй байна. Үнэ нь энэхүү Гэрээний 2.2 дахь хэсэгт заасны дагуу Хэлцэл биелэх өдрийн байдлаарх Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээс ихгүй байна.

**3.2. Үнэ төлөх хугацаа**

3.2.1. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулалтаас татан төвлөрүүлэх дүнг амжилттай татан төвлөрүүлсэн тохиолдолд хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш Ажлын 3 өдөрт багтаан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

3.2.2. Эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн дүн Үнэт цаас гаргагчийн дансанд шилжээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Үнийг хугацаанд нь шилжүүлээгүйтэй холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй.

СЗХ
он 2022 сар 11 0 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар**

3.3.1. Энэхүү Гэрээний дагуу Хөрөнгийн багцыг худалдан авахад төлсөн Үнэ нь НӨАТ-гүй дүн байх ба Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14 дэх заалтад заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

**3.4. Хөрөнгө оруулалтаас татан төвлөрүүлэх дүн хүрэхгүй байх**

3.4.1. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн дүн нь энэхүү Гэрээний 3.1.1 дэх заалтад тусгасан хэмжээнд хүрэхгүй байх тохиолдолд Хэлцэл амжилтгүй болсон гэж үзэх ба Хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

3.4.2. Энэхүү Гэрээний 3.4.1 дэх заалтад заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг буцаан олгох ажиллагааг хийнэ.

3.4.3. Энэхүү Гэрээний 3.4.1 дэх заалтад заасан нөхцөл байдал бүрдсэний улмаас Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээ болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь мөн адил энэхүү Гэрээ болон бусад гэрээний үүргийн зөрчил гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчид учирсан хохирлыг хариуцахгүй.

**3.5. Гэрээ хэрэгжүүлэх зардал**

3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээг хэрэгжүүлж, Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой зардлыг хариуцна. Уг зардалд андеррайтерийн үйлчилгээний хөлс, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс, Хорооны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахтай холбоотой үйлчилгээний хөлс, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлс, Биржийн бүртгэл хүлээн авч хянах хөлс, үнэт цаасны бүртгэлийн хураамж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаасны бүртгэл, хадгалалт болон арилжааны шимтгэл хураамж, улсын тэмдэгтийн хураамж, бусад энэхүү Гэрээг хэрэгжүүлэх болон Үнэт цаас гаргахтай холбоотой зардлууд багтана.

## ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

**4.1. Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:**

4.1.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих;

4.1.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх;

4.1.3. Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах.

**4.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих**

4.2.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой дараах нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд (цаашид “Шаардлага хангахгүй хөрөнгө” гэх) Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Шалгуур үзүүлэлт болон холбогдох шаардлагыг хангаж буй өөр Хөрөнгө буюу Хөрөнгийн багц(цаашид “Орлуулах хөрөнгө” гэх)-аар солих үүрэг хүлээнэ. Үүнд:

4.2.1.1. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь хуанлийн 31 болон түүнээс дээш хоногоор хэтэрсэн;

4.2.1.2. Зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн (Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон,

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ 03

зээл болон фидуцийн зүйлтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн, Зээлдэгчээс гомдол, санал гарсан гэх мэт);

4.2.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд Үнэт цаас гаргагчид мэдэгдэх бөгөөд энэ нь Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн;

4.2.1.4. Шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Гэрээний 8 дугаар зүйлд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн.

4.2.2. Энэхүү Гэрээний 4.2.1 дэх заалтад заасан Орлуулах хөрөнгө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.2.2.1. Энэхүү Гэрээний 2.3 дахь хэсэгт заасны дагуу Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа, мөн Орлуулах хөрөнгийг нийт Хөрөнгийн багцад шилжүүлсэнтэй холбоотой түүнд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байх;

4.2.2.2. Орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүн нь Шаардлага хангахгүй хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүнгээс багагүй буюу тэнцүү байх;

4.2.2.3. Орлуулах хөрөнгө дэх Зээлийн хөрөнгүүдийн хувьд үлдэгдэл хугацаа нь Үнэт цаасны эргэн төлөлт хийгдэж дуусах хугацаанаас багагүй байх;

4.2.2.4. Орлуулах хөрөнгийн хувьд Сарын хуваарьт төлбөр нь Шаардлага хангахгүй хөрөнгийн Сарын хуваарьт төлбөрийн нийлбэрээс багагүй дүнтэй байх.

4.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шилжүүлсэн Орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь Шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн дүнгээс багагүй байх бөгөөд үүнтэй холбоотой зөрүүг тооцоо нийлсэн актад тусган баталгаажуулж, тухай бүр барагдуулна. Үнэт цаас гаргагч нь Орлуулах хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс өөрийн бүртгэлд шилжүүлэн авсан өдрөөс эхлэн тухайн хөрөнгөөс орж ирэх орлогыг хүлээн авна.

4.2.4. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын дагуу Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлнэ.

4.2.5. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө солих тухай мэдэгдлийн дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Орлуулах хөрөнгийн жагсаалтыг ирүүлэх байдлаар Талууд харилцан тохиролцсоны хүрээнд "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" болон бусад баримт бичигт заасан шаардлагыг хангасан Орлуулах хөрөнгийг энэхүү Гэрээний 2.5.1 болон 2.6.2 дахь заалтад заасны дагуу бүртгэж, холбогдох акт, баримт бичгийг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцох бөгөөд Үнэт цаас гаргагч нь Шаардлага хангахгүй хөрөнгийг өөрийн бүртгэлээс хасах байдлаар өмчлөх эрхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих үйл ажиллагаа дуусгавар болно.

4.2.6. Талууд энэхүү Гэрээний 4.2.4 дэх заалтад заасан үйл ажиллагаатай холбогдон Хөрөнгө солих тухай мэдэгдэл, Орлуулах хөрөнгийн жагсаалт болон холбогдох бусад баримт бичгийг биет болон биет бус хэлбэрээр хадгалж, хамгаална.

**4.3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх**

4.3.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болно. Үүнд:

СЭХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

4.3.1.1. Хөрөнгийн багцаас орох орлого нь Үнэт цаасны төлбөрийн үүргийг бүрэн гүйцэтгэхэд хүрэлцэхээргүй болсон;

4.3.1.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас бага болсон;

4.3.1.3. Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хүүгийн хувь хэмжээ нь үнэт цаасны хүүгийн түвшнээс бага болсон;

4.3.1.4. Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хугацаа нь үнэт цаасны дундаж хугацаанаас бага болсон;

4.3.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтад заасны дагуу ТЗК нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;

4.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг хүлээн авсан тохиолдолд Хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ.

4.3.3. Энэхүү Гэрээний 4.3.1 дэх заалтад заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нэмэгдүүлэх хөрөнгө (цаашид “**Нэмэгдүүлэх хөрөнгө**” гэх) нь 4.2.2 дахь заалтад заасан Орлуулах хөрөнгөд тавигдах шаардлагыг хангасан байна.

4.3.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шилжүүлсэн нэмэгдүүлэх хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь Компаниас шаардсан нэмэгдүүлэх шаардлагатай дүнгээс багагүй байх бөгөөд үүнтэй холбоотой зөрүүг тооцоо нийлсэн актад тусган баталгаажуулж, тухай бүр барагдуулна. Үнэт цаас гаргагч нь Нэмэгдүүлэх хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс өөрийн бүртгэлд шилжүүлэн авсан өдрөөс эхлэн тухайн хөрөнгөөс орж ирэх орлогыг хүлээн авна.

4.3.5. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын дагуу Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлнэ.

4.3.6. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө нэмэгдүүлэх тухай мэдэгдлийн дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалтыг ирүүлэх байдлаар Талууд харилцан тохиролцсоны хүрээнд “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам” болон бусад баримт бичигт заасан шаардлагыг хангасан Нэмэгдүүлэх хөрөнгийг энэхүү Гэрээний 2.5.1 болон 2.6.2 дахь заалтад заасны дагуу бүртгэж, холбогдох акт, баримт бичгийг үйлдсэнээр хөрөнгийг нэмж бүртгэсэнд тооцож, Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа дуусгавар болно.

4.3.7. Талууд энэхүү Гэрээний 4.3.5 дахь заалтад заасан үйл ажиллагаатай холбогдон Хөрөнгө нэмэгдүүлэх тухай мэдэгдэл, Нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт болон холбогдох бусад баримт бичгийг биет болон биет бус хэлбэрээр хадгалж, хамгаална.

**4.4. Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах**

4.4.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой дараах нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах эрхтэй байна. Үүнд:

4.4.1.1. Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн нь түүний анхны үнийн дүнгийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тохиролцон багцыг буцаан худалдах;

4.4.1.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол тухайн хөрөнгийн багцын буцаан худалдах;



TDB SECURITIES

4.4.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний 4.2 дахь хэсэгт заасны дагуу Шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солихуйц Орлуулах хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гаргаж өгөх боломжгүй эсхүл уг жагсаалтад буй хөрөнгө нь энэхүү Гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хэсэгчлэн хангахгүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Шаардлага хангахгүй хөрөнгийн солих боломжгүй хэсгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;

4.4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах шаардлагыг хүлээн авсан тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн Хөрөнгийн багцыг буцаан худалдан авах үүрэг хүлээнэ.

4.4.3. Энэхүү Гэрээний 4.4.5 дахь заалтад заасан Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах үнэ нь мэдэгдэлд заасан тасалбар болгох өдрөөрх буцаан худалдах Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүдийн шаардах эрх бүхий үндсэн төлбөр, хуримтлагдсан хүүгийн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон бусад зээлийн хөрөнгөтэй холбоотой төлбөрийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

4.4.4. Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын дагуу Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлнэ.

4.4.5. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах тухай мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлд Буцаан худалдах хөрөнгийн жагсаалт болон Үнийн саналыг тусгана. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь мэдэгдлийн хүрээнд харилцан тохиролцсон үнийг Үнэт цаас гаргагчид шилжүүлж, Талууд "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" болон бусад баримт бичигт заасан холбогдох бүртгэлд өөрчлөлт оруулж, акт, баримт бичгийг үйлдсэнээр Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг буцаан худалдах үйл ажиллагаа дуусгавар болно.

4.4.6. Талууд энэхүү Гэрээний 4.4.5 дахь заалтад заасан үйл ажиллагаатай холбогдон Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах тухай мэдэгдэл болон холбогдох бусад баримт бичгийг биет болон биет бус хэлбэрээр хадгалж, хамгаална.

4.4.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний 4.4.2 дахь заалтад заасны дагуу Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг Хөрөнгийн багцыг гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүхэлд нь худалдан борлуулах эрхтэй байна. Үнэт цаас гаргагч нь гуравдагч этгээдэд Хөрөнгийн багцыг худалдан борлуулсантай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор гарсан зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс нэхэмжлэх эрхтэй байна.

4.4.8. Энэхүү Гэрээний 4.4.7 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагч нь гуравдагч этгээдэд Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь худалдан борлуулсан нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг энэхүү Гэрээний 4.4.2 дахь заалтад заасан үүргээс чөлөөлөхгүй байна.

## ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Худалдагч нь энэхүү Гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

5.1.1. Биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийн бүртгэлд энэхүү Гэрээний 2.4.3 болон 2.5.1 дэх заалтад заасны дагуу холбогдох өөрчлөлтийг



СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-11-15

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

оруулсан тохиолдолд энэхүү Гэрээний 3.2.1 дэх заалтад заасны дагуу харилцан тохиролцсон Үнийг Үнэт цаас гаргагчаас нэхэмжлэх;

5.1.2. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэх;

5.1.3. Холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээгээр тодорхойлсон бусад эрх.

**5.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Худалдагч нь энэхүү Гэрээний хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

5.2.1. Аливаа биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичиг бүхий энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдах буюу шилжүүлэх;

5.2.2. Хөрөнгийн багцыг худалдах буюу шилжүүлэхтэй холбоотойгоор тухайн багцыг Үнэт цаас гаргагчийн өмчлөлд бүрэн шилжүүлж, энэхүү Гэрээний 2.4.3 болон 2.5.1 дэх заалтад заасны дагуу холбогдох бүртгэлд өөрчлөлт оруулах;

5.2.3. Барьцаа хөрөнгийн бүртгэлийн Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой гарах зардлыг төлөх;

5.2.4. Үнэт цаас гаргагчид худалдаж байгаа Хөрөнгийн багцтай холбоотой Зээлийн хувийн хэрэг, баримт бичиг болон холбогдох мэдээ, мэдээллийг үнэн зөв, бүрэн гарган өгөх;

5.2.5. Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдах замаар хүлээн авсан Үнийг зээлийн үйл ажиллагаанд бүрэн зарцуулах;

5.2.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасан Фидуцийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэхгүй, барьцаалахгүй болон бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй, түүний эрхийн байдлыг доройтуулахгүй байх;

5.2.7. Энэхүү Гэрээний 2.6.3 дахь заалтад заасны дагуу Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг үл маргах журмаар Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, түүнтэй холбоотойгоор эрх бүхий байгууллагын Хөрөнгийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажиллагааг Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлэх;

5.2.8. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.2.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Орлуулах хөрөнгөөр солих, тус үйл ажиллагааг энэхүү Гэрээний 4.2.5 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг төлөх;

5.2.9. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.3.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүсэж, Үнэт цаас гаргагчаас Хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг ирүүлсэн тохиолдолд тус үйл ажиллагааг энэхүү Гэрээний 4.3.5 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг төлөх;

5.2.10. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.4.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах, тус үйл ажиллагааг энэхүү Гэрээний 4.4.4 дэх заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг төлөх;

5.2.11. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний 4.4.7 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргач нь Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь гуравдагч этгээдэд худалдан борлуулсантай холбоотойгоор гарсан зардлыг төлөх;

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

5.2.12. Энэхүү Гэрээний 3.5 дахь хэсэгт заасны дагуу энэхүү Гэрээг хэрэгжүүлж, Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой зардлыг хариуцан төлөх;

5.2.13. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас гаргагч болон гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг нөхөн төлөх;

5.2.14. Энэхүү Гэрээний 2.6.3 дахь заалтад заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд энэ талаар зээлдэгчид Зээлдэгчид мэдэгдэх;

5.2.15. Энэхүү Гэрээнд заасан баталгаа, мэдэгдлийг хангах, хэрэв зөрчигдсөн тохиолдолд Үнэт цаас гаргагчаас тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд хангаж, зөрчлийг арилгах, түүнтэй холбогдон Үнэт цаас гаргагч болон бусад этгээдэд учирсан бодит хохирлыг барагдуулах;

5.2.16. Холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

**5.3. Үнэт цаас гаргагч буюу Худалдан авагч нь энэхүү Гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

5.3.1. Биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичиг бүхий энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийн багцыг худалдаж буюу шилжүүлэн авах;

5.3.2. Хөрөнгийн багцыг худалдан буюу шилжүүлэн авахтай холбоотойгоор тухайн багцыг өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлж, энэхүү Гэрээний 2.4.3 болон 2.5.1 дэх заалтад заасны дагуу холбогдох бүртгэлд өөрчлөлт оруулах;

5.3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Эрх бүхий этгээдийн баталсан аливаа дүрэм, журам, Үнэт цаасны танилцуулгад заасны дагуу энэхүү Гэрээний 5.3.1 дэх заалтад заасан эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх гэрээ болон бусад гэрээ байгуулах;

5.3.4. Энэхүү Гэрээний 2.6.3 дахь заалтад заасны дагуу Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг үл маргах журмаар шилжүүлэн авах, түүнтэй холбоотойгоор эрх бүхий байгууллагын Хөрөнгийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажиллагааг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хийж гүйцэтгэх, уг өмчлөх эрхийн дагуу Фидуцийн гэрээнд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүхий л эрхийг хэрэгжүүлэх, фидуцийн зүйлийг захиран зарцуулах;

5.3.5. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.2.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Орлуулах хөрөнгөөр солих, тус үйл ажиллагааг энэхүү Гэрээний 4.2.5 дахь заалтад заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс нэхэмжлэх;

5.3.6. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.3.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах, тус үйл ажиллагааг энэхүү Гэрээний 4.3.5 дахь заалтад заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс нэхэмжлэх;

5.3.7. Хөрөнгийн багц дахь Зээлийн хөрөнгөтэй холбоотой энэхүү Гэрээний 4.4.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах, тус үйл ажиллагаа

СЭХ
20__ он __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ 03

энэхүү Гэрээний 4.4.4 дэх заалтад заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарсан зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс нэхэмжлэх;

5.3.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас гаргагч болон гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэх;

5.3.9. Энэхүү Гэрээнд заасан баталгаа, мэдэгдэл нь Гэрээ байгуулагдах үед болон байгуулагдсанаас хойш зөрчигдсөн талаар мэдсэн даруйдаа уг зөрчлийг арилгахыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд зөрчигдсөн баталгаа, мэдэгдэл нь цаашид гэрээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц буюу энэхүү Гэрээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд энэхүү Гэрээг цуцлах эрхтэй байна.

5.3.10. Холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

**5.4. Үнэт цаас гаргагч буюу Худалдан авагч нь энэхүү Гэрээний хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

5.4.1. Биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийн бүртгэлд энэхүү Гэрээний 2.4.3 болон 2.5.1 дэх заалтад заасны дагуу холбогдох өөрчлөлтийг оруулсан тохиолдолд энэхүү Гэрээний 3.2.1 дэх заалтад заасны дагуу харилцан тохиролцсон Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх;

5.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээг гуравдуулагч этгээдээр гүйцэтгүүлэх бөгөөд гуравдагч этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйгээс үүсэх үүргийг бүрэн хариуцна;

5.4.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг нөхөн төлөх;

5.4.4. Холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

**6.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгөтэй холбоотой дараах баталгаа болон мэдэгдлийг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:**

6.1.1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хэлцэл биелэх өдрийн байдлаар Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан болно.

6.1.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйл нь аливаа эрхийн болон биет байдлын хувьд доголдолгүй, өмчийн маргаангүй, дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчийн өмчлөлд шилжүүлэхэд аливаа хязгаарлалт байхгүй болно.

6.1.3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө, фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээ болон Фидуцийн гэрээнд зааснааас өөр нэмэлт үүрэг байхгүй болно.

6.1.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгч болон Зээлдэгчийн хамааралтай этгээд, Фидуцийн зүйлтэй холбоотой дараах сөрөг нөлөөтэй байж болохуйц аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл дампуурлын хэрэг зэргийн талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно. Үүнд:

6.1.4.1. Зээлдэгч болон түүний хамааралтай этгээдийн Хөрөнгөтэй холбоотой хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар доройтоогүй байна.

6.1.4.2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал Гэрээний үргэлжлэх хугацаанд бүрэн хангагдсан байна.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

6.1.5. Зээлдэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийг Үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч болон Аудитор шалган баталгаажуулах боломжтой байна.

6.1.6. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд Зээлийн баримт бичгүүд, Зээлийн данс бүртгэл болон Зээлийн хувийн хэрэг нь зохих ёсоор бүрэн гүйцэт бүртгэгдэж, хадгалагдах бөгөөд Хэлцэл биелэх өдрийн байдлаар уг баримт бичиг нь бүрэн гүйцэт ба шинэчлэгдсэн байдлаар Үнэт цаас гаргагчийн өмчлөлд шилжсэн байна.

6.1.7. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үүсээгүй байна.

6.1.8. Энэхүү Гэрээний 2.6.1 дэх заалтад заасан зөвшөөрлийг авах шаардлагатай тохиолдолд уг ажлыг өөрийн зардлаар, бие даан хариуцна.

6.1.9. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргээ бүрэн биелүүлж байгаа бөгөөд Зээлийг санхүүжүүлсэн эх үүсвэр нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан хориглогдсон эх үүсвэр биш болно.

**6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дараах нийтлэг баталгаа болон мэдэгдлийг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:**

6.2.1. Энэхүү Гэрээ болон Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр, журам, хууль тогтоомжийг зөрчихгүй болно.

6.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний 6.2.1 дэх заалтад заасан гэрээгээр зээлийн хөрөнгийг худалдах буюу шилжүүлэх, фидуцийн зүйлийг барьцаалуулах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг хангасан болно.

6.2.3. Энэхүү Гэрээ болон Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд хавсаргасан баримт бичиг, мэдээ, мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт болно.

**6.3. Баталгаа, мэдэгдэл хангагдах**

6.3.1. Үнэт цаас гаргагч бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг бие даан дуусгавар болгох, энэхүү Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй эсхүл тийнхүү хэрэгжилтийг хойшлуулсан зэрэг нь баталгаа, мэдэгдэл хангагдахгүй байх үндэслэл болохгүй.

6.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн баталгаа, мэдэгдэл зөрчигдсөнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний хүрээнд тодорхойлогдсон эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

**6.4. Баталгаа, мэдэгдэл зөрчигдөх**

6.4.1. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээнд заасан баталгаа, мэдэгдэл нь Гэрээ байгуулагдах үед болон байгуулагдсанаас хойш зөрчигдсөн талаар мэдсэн даруйдаа уг зөрчлийг арилгахыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд зөрчигдсөн баталгаа, мэдэгдэл нь цаашид гэрээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц буюу энэхүү Гэрээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд энэхүү Гэрээг цуцлах эрхтэй байна.

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

6.4.2. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээнд заасан баталгаа, мэдэгдэл худал эсэхийг гэрээ байгуулах үед эсхүл түүнээс өмнө мэдэх боломжтой байсан эсэхээс үл хамааран баталгаа, мэдэгдэл зөрчигдсөнтэй холбоотой шаардлагыг Хөрөнгө худалдан авах үед болон түүнээс хойш гаргаж болох ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд уг зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.

## ДОЛОО. ЗӨРЧИЛ

7.1. **Дараах тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ноцтой зөрчил гаргасан гэж үзнэ. Үүнд:**

7.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид Хөрөнгийн багцыг худалдсан буюу шилжүүлснээс хойш түүний автомашины зээлийн хөрөнгийн багцын үлдэгдэл болон чанар нь Үнэт цаас гаргагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүрэлцэхгүй буюу хангалтгүй болсон;

7.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах ажиллагаа хийгдэж эхэлсэн болон дампуурлын хэрэг үүсгэсэн;

7.1.3. Дээр дурдсанаас бусад байдлаар энэхүү Гэрээнд заасан аливаа зүйл заалт бүрэн болон хэсэгчлэн зөрчигдсөн бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг зөрчлийг арилгуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл өгсөн боловч уг зөрчлийг арилгаагүй;

7.1.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тус хуулийг зөрчсөнийг Эрх бүхий байгууллагаас тогтоосон;

7.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний зүйл заалтыг зөрчсөн бөгөөд уг зөрчил нь энэхүү Гэрээний 7.1 дэх хэсэгт зааснаас бусад зөрчил байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдэлд заасан хугацааны дотор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг зөрчлийг арилгах үүргийг хүлээнэ.

7.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зөрил гарсантай холбоотойгоор Үнэт цаас гаргагчид учирсан бодит хохирлыг нөхөн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

## НАЙМ. НУУЦЛАЛ

8.1. Талууд энэхүү Гэрээний дагуу олж авсан аливаа нууцад хамаарах баримт бичиг, мэдээ, мэдээллийг өөрийн нууц мэдээллийн нэгэн адил үзэж, нууц мэдээллийг хадгалдаг арга хэмжээтэй ижил түвшний арга хэмжээг авч, задруулахгүй байх боломжит бүх арга хэмжээг авна.

8.2. Талууд энэхүү Гэрээний дагуу олж мэдсэн аливаа нууц мэдээллийг энэхүү Гэрээ хэрэгжих хугацааны турш, мөн цуцлагдсан, дуусгавар болсноос хойш 3 (гурван) жилийн хугацаанд хадгална.

8.3. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцыг худалдан авах болон Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй бусад оролцогч талууд (Зээлийн шинжилгээ гаргагч, Андеррайтер, Хуулийн зөвлөх, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч болон бусад) -д шаардлагатай мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гарган өгөх боломжтой байна.

8.4. Талуудын энэхүү Гэрээний дагуу олж мэдсэн аливаа мэдээлэлд хамаарах, эсхүл энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явц, хэрэгжсэнээс үүсэх үр дагавартай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу прокурор, шүүх шаардах тохиолдолд энэхүү Гэрээний 8.2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлахгүй гарган өгнө.

## ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Талуудын аль нэг нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, нөгөө талынхаа эдийн болон эдийн бус баялагт холбогдох эрхийг зөрчсөний улмаас нөгөө талдаа учруулсан биет хохирол болон мөнгөн зардлыг буруутай тал нь бүрэн хариуцаж арилгана.

## АРАВ. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ

10.1. Энэхүү Гэрээ болон Талуудын эрх, үүргийг Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн Эрх бүхий этгээдийн баталсан аливаа дүрэм, журмын дагуу тайлбарлаж, зохицуулна.

10.2. Хэрэв энэхүү Гэрээ болон Үнэт цаас гаргахтай холбоотой бусад оролцогчтой байгуулсан аливаа гэрээний заалт нь Монгол Улсын хууль, Эрх бүхий этгээдийн баталсан дүрэм, журамд заасан заалтуудтай зөрчилдвөл Монгол Улсын хууль болон Эрх бүхий этгээдийн баталсан дүрэм, журамд заасныг дагаж мөрдөнө.

10.3. Хэрэв энэхүү Гэрээний аливаа заалт нь аливаа хууль тогтоомжоор хууль бус эсвэл хүчин төгөлдөр бус эсвэл хэрэгжих боломжгүй болсон нь энэхүү Гэрээний хүчин төгөлдөр бусад заалтуудад нөлөөлөхгүй.

## АРВАН НЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

11.1. Энэхүү Гэрээнээс үүссэн буюу түүнтэй холбоотой, мөн гэрээний бус үүрэгтэй холбоотой аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлнэ.

11.2. Арбитрын шийдвэртэй холбогдон гарах зардлыг аль буруутай тал нь хариуцна.

## АРВАН ХОЁР. БУСАД

12.3. **Гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох:** Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

12.4. **Гэрээний хувь:** Энэхүү Гэрээг Монгол хэл дээр нийт 6 (зургаа) хувь үйлдэх бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгалж, Үнэт цаасны танилцуулгад зориулан 4 хувийг бэлтгэсэн нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

12.5. **Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах:** Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа аль нэг тал нь нөгөө талтайгаа харилцан тохирсноос бусад тохиолдолд Ажлын 3 өдрийн өмнө бичгээр ирүүлнэ. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулж, нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

12.6. **Гэрээ цуцлагдах:** Энэхүү Гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжаалах замаар шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авах буюу шилжүүлэн авсан тохиолдолд Талууд аль нэг талын санаачилгаар энэхүү Гэрээг цуцлах эрхгүй байна.

12.7. **Мэдэгдэл, шаардлага, захидал хүргүүлэх:** Энэхүү Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгэн хэлбэрээр байна. Эдгээрийг энэхүү Гэрээнд заасан дараах цахим хаягаар эсхүл гэрээнд заасан талуудын албан ёсны хаягаар хүргүүлснээр хүлээн авсанд тооцох бөгөөд баримтуудыг хадгална.

СЗХ
2022 оны 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

**“Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”-д**

- Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот
- Холбоо барих албан тушаалтан: **Гүйцэтгэх захирал С. Отгонбат**
- Утас: (976) 9911 6366
- И-мэйл: info@bichilglobus.mn

**“Үнэт цаас гаргагч”-д**

- Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, ногоон нуур, 101 барилга, 705 тоот
- Холбоо барих албан тушаалтан: **Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц. Азбаяр**
- Утас: (976) 9999 8666
- И-мэйл: azbayar.khangolomt@gmail.com

12.8. Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд байгуулагдсан ________ тоот Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний салшгүй хэсэг болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

| | |
|---|---|
| **АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ** | **ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ** |
| “БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ” ХХК | “БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХХК |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>С.ОТГОНБАТ | ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА<br>Ц. АЗБАЯР |
| ____________________ | ____________________ |

СЭХ
2022 оны 11 сар 03 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн 2022 оны 09 сарын 27-ны өдрийн 22/258a/14
дугаар тогтоолын 5 хавсралт

**ФИДУЦИЙН БОЛОН ШААРДАХ ЭРХ БАРЬЦААЛАХ ГЭРЭЭ**

**ГЭРЭЭНИЙ ДУГААР**
**№**

**“БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ” ХХК**
**Барьцаалуулагч**

**болон**

**“БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХХК**
**Барьцаалагч**

Огноо: 2022 оны __-р сарын __-ны өдөр
Улаанбаатар хот

Энэхүү **ФИДУЦИЙН БОЛОН ШААРДАХ ЭРХ БАРЬЦААЛАХ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 153-160 дугаар зүйл, 235 дугаар зүйлийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 9015002106 тоот улсын бүртгэлийн, 5729718 тоот регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101-р барилга, 705 хаягт байрлах "**БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК** (цаашид "Барьцаалуулагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.Отгонбат болон;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6875351 тоот регистрийн, 9011840095 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101-р барилга, 705 хаягт байрлах "**БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК** (цаашид "Барьцаалагч" гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Ц. Азбаяр (цаашид Барьцаалуулагч болон Барьцаалагчийг хамтад нь **"Талууд"** гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Барьцаалуулагч болон Барьцаалагчийн хооронд 2022 оны ___-р сарын ____-ний өдөр байгуулагдсан _____ тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" (цаашид "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" гэх)-ний дагуу шилжүүлж буй Хөрөнгийн багц дахь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Барьцаалуулагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Барьцаалагчид барьцаалуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. **"Ажлын өдөр"** гэж Монгол Улс, Улаанбаатар хотод арилжааны банкнууд нээлттэй ажилладаг, бүх нийтээр амрах болон долоо хоног бүрийн Бямба, Ням гаригаас бусад өдрийг;

1.2.2. **"Барьцааны зүйл"** гэж энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт тодорхойлсон буюу энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан барьцаа хөрөнгүүдийг түүнтэй холбоотой эрхийн хамтаар;

1.2.3. **"Барьцаа хөрөнгийн жагсаалт"** гэж энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт тодорхойлсон буюу Гэрээний Хавсралт 1-т заасан Барьцааны зүйлийн жагсаалтыг;

1.2.4. **"Зээл"** эсхүл **"Автомашины зээл"** гэж Барьцаалуулагчаас Зээлдэгчид **автомашин худалдан авахад нь зориулан** санхүүжилт олгож, тухайн автомашиныг уг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Фидуцийн гэрээ байгуулсныг;

1.2.5. **"Зээлдэгч"** гэж хууль тогтоомжийн хүрээнд Барьцаалуулагчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж автомашины зээл авсан, уг зээлийн үндсэн төлбөр, хүү болон бусад холбогдох төлбөрийн хамт зээлийн гэрээний дагуу Барьцаалуулагчид эргүүлэн төлөх үүрэгтэй этгээдийг;

1.2.6. **"Зээлдэгчийн хамаарал бүхий этгээд"** гэж хамтран зээлдэгч, барьцаа эсхүл баталгаа гаргагч, фидуцийн зүйлийн эзэмшигч зэргийг;

1.2.7. **"Зээлийн эргэн төлөлт"** гэж Зээлдэгчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Үйлчилгээ үзүүлэгчид сар тутам Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх Зээлийн үндсэн төлбөр, түүний хүү болон Зээлийн гэрээний дагуу тооцогдох нэмэгдүүлсэн хүүг;

1.2.8. **"Нууц мэдээлэл"** гэж Үнэт цаас гаргах үйл ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, Хөрөнгийн багц болон түүний Зээл, фидуцитэй холбоотой Зээлдэгч болон гуравдагч этгээд, Үнэт цаас гаргагч ба Анхны үүрэг гүйцэтгэгчтэй холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээд (үүнд андеррайтер, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч, зээлийн шинжилгээ гаргагч, хөндлөнгийн аудитор, банк зэрэг байгууллагууд багтана)-тэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

мэдээлэл, мөн талуудын бизнесийн, үйл ажиллагааны, маркетингийн болон санхүүгийн төлөвлөгөө, харилцагчид, хөрөнгө оруулагч, хувь эзэмшлийн тухай мэдээлэл, санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм, журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл, эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг, график мэдээлэл;

1.2.9. **“Орлуулах хөрөнгө”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.2.1 дэх заалтад заасан хөрөнгийг;

1.2.10. **“Үнэт цаас”** гэж Барьцаалагчийн гарган, нийтэд санал болгон арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг;

1.2.11. **“Фидуцийн гэрээ”** гэж Барьцаалуулагч нь Зээлдэгчид олгох Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгын хүрээнд байгуулсан хөдлөх эд хөрөнгө болох автомашиныг Барьцаалуулагчийн өмчлөлд шилжүүлэх гэрээг:

1.2.12. **“Фидуцийн зүйл”** гэж Талуудын хооронд байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд тодорхойлсон Фидуцийн гэрээний дагуу Барьцаалуулагчийн өмчлөлд шилжүүлсэн автомашиныг;

1.2.13. “**Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн сан**” гэж Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хуулийн 35-р зүйлийн 35.1-т заасан хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн санг;

1.2.14. **“Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хууль”** гэж Монгол Улсын Их хурлаас 2015 оны 7-р сарын 02-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн тухай хуулийг;

1.2.15. **“Хөрөнгө”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 1.2.27 дахь хэсэгт тодорхойлсон хөрөнгийг;

1.2.16. **“Хөрөнгийн багц”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 2.1.1 дэх заалтад заасан, Барьцаалуулагчаас Барьцаалагчид худалдаж буй Хөрөнгийг багц болгосныг;

1.2.17. **“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”** гэж Монгол Улсын Их хурлаас 2010 оны 4-р сарын 23-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг;

1.2.18. **“Шаардлага хангахгүй хөрөнгө”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.2.1 дэх заалтад заасан нөхцөл бүхий хөрөнгийг.

1.2.19. **“Шалгуур үзүүлэлт”** гэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг;

1.2.20. **“Эрх бүхий этгээд”** гэж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид “Төвлөрсөн хадгаламжийн төв” гэх), “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК (цаашид “Төлбөр тооцооны байгууллага” гэх), нээлттэй зах зээлд үнэт цаас гарган арилжаалахтай холбоотой ажилд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа болон бусад төрийн эрх бүхий байгууллагыг.

## ХОЁР. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

2.1. Барьцаалуулагч нь Үнэт цаасны барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Зээлдэгчтэй байгуулсан Фидуцийн гэрээний дагуу өмчлөх эрхийг нь шилжүүлэн авсан энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан Барьцаа хөрөнгийн жагсаалт дахь Фидуцийн зүйлүүдийг түүнтэй холбоотой дараах эрхүүдийн хамтаар (цаашид “Барьцааны зүйл” гэх) Барьцаалагчид барьцаалж байна.

2.1.1. Автомашины зээлийн хөрөнгийн хувьд түүний авлагын шаардах эрх буюу Зээлийн гэрээний дагуу Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү



TDB SECURITIES

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

хэрэг төлбөрийг шаардах, төлбөр цуглуулах, нэхэмжлэл гаргах, Зээлийн төлөлтийг хүлээж авахтай холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхүүд, мөн холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд;

2.1.2. Автомашины зээлийн авлагын шаардах эрхийг баталгаажуулж буй Фидуцийн барьцааны гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлүүдийн өмчлөх эрхийг барьцаалах, энэхүү Гэрээнд заасан барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж, захиран зарцуулахтай холбоотой бүхий л эрх;

2.1.3. Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хохирол нөхөн төлөхийг шаардах эрх;

2.1.4. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлийн хөрөнгөтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, Эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, Зээлдэгч болон түүний хамтран зээлдэгч бусад Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдэд холбогдуулан шаардлага гаргах, шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх;

2.1.5. Зээлийн хөрөнгөтэй холбоотой бүхий л баримт бичгүүд, үүнд зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ, Фидуцийн хөрөнгөтэй холбоотой баримт бичиг болон бусад зээл, барьцаа, батлан даалтын хөрөнгөтэй холбоотой баримт бичгүүдийг шилжүүлэн авч, хадгалах эрх.

2.2. Барьцааны зүйл нь Талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний хүрээнд тодорхойлогдсон Хөрөнгийн нэг хэсэг бөгөөд уг Хөрөнгөтэй салшгүй холбоотой байна.

2.3. Барьцааны зүйлийн өмчлөл, эзэмшил: Барьцааны зүйл нь Барьцаалуулагчийн өмчлөлд байх ба гуравдагч этгээдийн эзэмшилд байж болно.

2.4. Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах: Талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Үнэт цаас гаргагчийн баталсан Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журамд заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт орсон тохиолдолд тухайн Хөрөнгө болон түүнтэй холбогдон Барьцааны зүйлд мөн өөрчлөлт орж, Барьцаа хөрөнгийн жагсаалт дараах байдлаар шинэчлэгдэнэ. Үүнд:

2.4.1. Барьцааны зүйл хасагдах: Зээлдэгч нь Барьцаалуулагчид төлөх зээлийн эргэн төлөлтийг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь уг зээлийн эргэн төлөлтийг Барьцаалагчид бүрэн шилжүүлсэн тохиолдолд Фидуцийн зүйлийн өмчлөх эрх Барьцаалуулагчид бус Зээлдэгчид шилжих бөгөөд Барьцааны зүйл нь Барьцаа хөрөнгийн жагсаалтаас хасагдаж, Барьцаалагчийн барьцаанаас чөлөөлөгдөнө.

2.4.2. Барьцааны зүйл солигдох: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.2.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Барьцаалуулагч нь Орлуулах хөрөнгөөр солих үйл ажиллагааг мөн тус гэрээний 4.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэгжүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Шаардлага хангахгүй хөрөнгийн Барьцааны зүйлийг Барьцаа хөрөнгийн жагсаалтаас хасаж, Барьцаалуулагчийн өмчлөлд шилжүүлэх бол Орлуулах хөрөнгийн Барьцааны зүйлийг Барьцааны жагсаалтад нэмж, Барьцаалагчийн өмчлөлд шилжүүлнэ.

2.4.3. Барьцааны зүйл нэмэгдэх: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.3.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Барьцаалуулагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг мөн тус гэрээний 4.3 дахь хэсэгт заасны дагуу хэрэгжүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Нэмэгдүүлэх хөрөнгийн Барьцааны зүйлийг Барьцааны жагсаалтад нэмж, Барьцаалагчийн өмчлөлд шилжүүлнэ.

2.4.4.Барьцааны зүйл буцаах: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.4.1 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн, мөн Шалгуур

үзүүлэлт хангагдахгүй болсон тохиолдолд Барьцаалагч нь Хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах үйл ажиллагааг мөн тус гэрээний 4.4 дэх хэсэгт заасны дагуу Барьцаалуулагчтай хамтран хэрэгжүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд буцаан худалдах хөрөнгийн Барьцааны зүйлийг Барьцаа хөрөнгийн жагсаалтаас хасаж, Барьцаалуулагчийн өмчлөлд шилжүүлнэ.

2.4.5. Барьцаалагч нь энэхүү Гэрээний 2.4 дэх хэсэгт заасны дагуу Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай бүр холбогдох барьцаа хөрөнгийн бүртгэлийг Хөдлөх эд хөрөнгийн цахим мэдээлийн санд тухай бүр бүртгэлийг хийлгэснээр Барьцаа баталгаажсанд тооцно.

## ГУРАВ. БАРЬЦААНЫ НӨХЦӨЛ

**3.1. Барьцаагаар хангагдах шаардлага**

3.1.1. Барьцаагаар хангагдах шаардлага нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 2.1 дэх хэсэгт заасан худалдах Хөрөнгө болон түүний дагалдах эрхээр тодорхойлогдоно.

**3.2. Барьцааны баталгаажилт**

3.2.1. Барьцаалагч нь барьцааны эрхийг баталгаажуулах зорилгоор Гэрээний Хавсралт 1-т заасан Барьцаа хөрөнгийн жагсаалт дахь Барьцааны зүйл тус бүрээр хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдэл (цаашид “Барьцааны мэдэгдэл” гэх)-ийг үйлдэж, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн сериал дугаараар Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.2.2. Барьцаалуулагч нь Барьцааны зүйлтэй холбоотой Барьцааны мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлэх зөвшөөрлийг Барьцаалагчид үүгээр зөвшөөрч байна.

3.2.3. Энэхүү Гэрээний 3.2.2 дахь заалтад заасан Барьцаалуулагчаас Барьцаалагчид олгосон зөвшөөрлийн хүрээнд Барьцаалагч нь Барьцааны мэдэгдлийг бүртгүүлэх, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, цуцлах, Барьцааны бүртгэлийн талаар лавлагаа авах эрхтэй болохыг тодорхойлж байна.

3.2.4. Барьцааны мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, Барьцааны мэдэгдлийн анхны бүртгэлийн хугацааг сунгах, Барьцааны мэдэгдлийг цуцлахтай холбоотой Улсын бүртгэлийн байгууллагад төлөх хураамж, шимтгэлийг Барьцаалуулагч хариуцна.

**3.3. Барьцааны зүйлтэй холбоотой мэдэгдэл**

3.3.1. Барьцаалуулагч нь барьцааны зүйлтэй холбоотой аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг Эрх бүхий байгууллага, Зээлдэгч болон бусад аливаа этгээдээс хүлээн авсан тохиолдолд энэ талаар Барьцаалагчид Ажлын **3** өдөрт бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ.

**3.4. Тэргүүн ээлжид шаардлага хангуулах**

3.4.1. Барьцаалагч нь энэхүү Гэрээний дагуу барьцаалж буй Барьцааны зүйлээр бусад аливаа шаардлагаас тэргүүн ээлжид үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

**3.5. Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэх болон барьцаалахгүй байх**

3.5.1. Барьцаалуулагч нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үргэлжлэх хугацаанд Барьцааны зүйлийн өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр бусад этгээдэд шилжүүлэхгүй, барьцаалахгүй, тийнхүү шилжүүлэхээр амлахгүй байх үүрэгтэй.

## ДӨРӨВ. БАРЬЦААГААР ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ

**4.1. Барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл**

4.1.1. Зээлийн хөрөнгөтэй холбоотой Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.4.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн мөн Шалгуур үзүүлэлт хангагдахгүй болсон, Барьцаалуулагч нь тус гэрээний 4.4.2 дахь заалтад заасны дагуу Хөрөнгийн багцыг буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Барьцаалагч нь Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах замаар Фидуцийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлж захиран зарцуулна.

СЗХ
2022 . 11 . 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**4.2. Барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах ажиллагаа**

4.2.1. Барьцаалагч нь Барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг бичгээр болон цахим хэлбэрээр Барьцаалуулагчид хүргүүлнэ.

4.2.2. Барьцаалуулагч нь энэхүү Гэрээний 4.2.1 дэх заалтад заасан Барьцаалагчийн мэдэгдлийг хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдох өдрөөс хойш Ажлын **3** өдрийн дотор Фидуцийн зүйлийн өмчлөх эрх нь Барьцаалагчид үл маргах журмаар шилжинэ. Барьцаалуулагч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон зэрэг шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэ заалтыг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

4.2.3. Барьцаалагч нь энэхүү Гэрээний дагуу Фидуцийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх бүртгэлийг Барьцаалуулагчтай хамтран холбогдох Эрх бүхий байгууллагад хийлгэнэ. Бүртгэл хийлгэхтэй холбоотой гарсан зардлыг Барьцаалуулагч бие даан хариуцна.

4.2.4. Энэхүү Гэрээний 4.2.3 дахь заалтад заасны дагуу Барьцаалуулагч нь Барьцаалагчтай хамтран ажиллах боломжгүй байх эсхүл хамтран ажиллахаас үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд Барьцаалагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн бүртгэлийг бие даан Эрх бүхий байгууллагад хийлгэнэ.

4.2.5. Барьцаалагч нь Гэрээний 4.2.2 дахь заалтад заасны дагуу Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш түүнийг гуравдагч этгээдэд худалдан борлуулах, захиран зарцуулах эрхтэй байна.

4.2.6. Барьцаалагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш Зээлдэгч болон Барьцаалуулагчийн хооронд байгуулагдсан Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээний дагуу Фидуцийн зүйлийг Зээлдэгчид шилжүүлэн өгөх нөхцөл үүссэн тохиолдолд уг үүргийг Барьцаалуулагчийн нэгэн адил хэрэгжүүлж Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Зээлдэгчид шилжүүлнэ.

4.2.7. Барьцаалагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авсны дараа Зээлдэгч нь Гэрээний 4.2.6 дахь заалтад заасны дагуу Фидуцийн зүйлийг Зээлдэгчид шилжүүлэн өгөх нөхцөл үүссэн ч, Барьцаалагч нь уг Фидуцийн зүйлийг захиран зарцуулсан байх тохиолдолд Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт заасны дагуу Зээлдэгчид хохирол төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

## ТАВ. БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

**5.1. Барьцаалуулагч нь дараах баталгаа, мэдэгдлийг гаргаж байна. Үүнд:**

5.1.1. Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийн цор ганц хууль ёсны өмчлөгч мөн болохыг үүгээр баталж байна.

5.1.2. Барьцааны зүйлд аливаа гуравдагч этгээдийн барьцааны эрх, шаардах эрх үүсээгүй, Барьцааны зүйл нь аливаа эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг үүгээр баталж байна.

5.1.3. Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийн хууль ёсны өмчлөлийг баталгаажуулахад шаардлагатай бүхий л бүртгэлийг холбогдох байгууллагуудад хийлгэсэн бөгөөд эдгээр нь хүчин төгөлдөр хэвээр байгаа болохыг үүгээр баталж байна.

5.1.4. Энэхүү Гэрээг байгуулах, биелүүлэх болон түүнтэй холбоотойгоор хийсэн аливаа хэлцэл нь дараах баримт бичгүүдтэй зөрчилдөхгүй. Үүнд:

5.1.4.1. Монгол Улсын хууль, тогтоомж;

5.1.4.2. Барьцаалуулагчийн үүсгэн байгуулах болон бусад баримт бичгүүд.

5.1.5. Барьцааны эрх нь энэхүү Гэрээгээр үүсэж байгаа бөгөөд Барьцаалуулагчийн шийдвэр, хүсэлтээр эсхүл Барьцаалуулагч дампуурсан нь уг эрх хүчингүй болох үндэслэл болохгүй болохыг үүгээр баталж байна.

5.1.6. Барьцаалуулагч нь энэхүү Гэрээг байгуулах, биелүүлэх бүрэн эрхтэй бөгөөд түүнтэй холбоотой бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан болохыг үүгээр баталж байна.

5.1.7. Барьцаалуулагчаас гаргаж өгсөн бүхий л мэдээлэл нь тухайн мэдээллийг гаргаж өгсөн өдрийн байдлаар үнэн зөв, бүрэн, тодорхой бөгөөд төөрөгдүүлсэн утга агуулгагүй болохыг үүгээр баталж байна.

TDB SECURITIES

СЗХ
2022 . 11 сар 03 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

5.1.8. Барьцаалагчийн эрхэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болохуйц үр дагавартай, Барьцаалуулагчид эсхүл Барьцааны зүйлд холбогдох шүүхийн, арбитрын болон эвлэрүүлэн зуучлалын маргаан байхгүй болохыг үүгээр баталж байна.

## ЗУРГАА. НУУЦЛАЛ

6.1. Талууд энэхүү Гэрээний дагуу олж авсан аливаа нууцад хамаарах баримт бичиг, мэдээ, мэдээллийг өөрийн нууц мэдээллийн нэгэн адил үзэж, нууц мэдээллийг хадгалдаг арга хэмжээтэй ижил түвшний арга хэмжээг авч, задруулахгүй байх боломжит бүх арга хэмжээг авна.

6.2. Талууд энэхүү Гэрээний дагуу олж мэдсэн аливаа нууц мэдээллийг энэхүү Гэрээ хэрэгжих хугацааны турш, мөн цуцлагдсан, дуусгавар болсноос хойш 3 (гурван) жилийн хугацаанд хадгална.

6.3. Талуудын энэхүү Гэрээний дагуу олж мэдсэн аливаа мэдээлэлд хамаарах, эсхүл энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явц, хэрэгжсэнээс үүсэх үр дагавартай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу прокурор, шүүх шаардах тохиолдолд энэхүү Гэрээний 6.2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлахгүй гарган өгнө.

## ДОЛОО. ЗӨРЧИЛ БА ХАРИУЦЛАГА

7.1. Барьцаалуулагч нь энэхүү Гэрээний зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд Барьцаалагч нь Барьцаалуулагчид бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдэлд заасан хугацааны дотор Барьцаалуулагч нь уг зөрчлийг арилгах үүргийг хүлээнэ.

7.2. Талуудын аль нэг нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, нөгөө талынхаа эдийн болон эдийн бус баялагт холбогдох эрхийг зөрчсөний улмаас нөгөө талдаа учруулсан бодит хохирол болон мөнгөн зардлыг буруутай тал нь бүрэн хариуцаж арилгана.

## НАЙМ. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ

8.1. Энэхүү Гэрээ болон Талуудын эрх, үүргийг Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн Эрх бүхий этгээдийн баталсан аливаа дүрэм, журмын дагуу тайлбарлаж, зохицуулна.

8.2. Хэрэв энэхүү Гэрээ болон Үнэт цаас гаргахтай холбоотой бусад оролцогчтой байгуулсан аливаа гэрээний заалт нь Монгол Улсын хууль, Эрх бүхий этгээдийн баталсан дүрэм, журамд заасан заалтуудтай зөрчилдвөл Монгол Улсын хууль болон Эрх бүхий этгээдийн баталсан дүрэм, журамд заасныг дагаж мөрдөнө.

8.3. Хэрэв энэхүү Гэрээний аливаа заалт нь аливаа хууль тогтоомжоор хууль бус эсвэл хүчин төгөлдөр бус эсвэл хэрэгжих боломжгүй болсон нь энэхүү Гэрээний хүчин төгөлдөр бусад заалтуудад нөлөөлөхгүй

## ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Энэхүү Гэрээнээс үүссэн буюу түүнтэй холбоотой, мөнг гэрээний бус үүрэгтэй холбоотой аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлнэ.

9.2. Арбитрын шийдвэртэй холбогдон гарах зардлыг аль буруутай тал нь хариуцна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
2022 он 11 сар 0.0 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-11-15
БҮРТГЭВ-03

## АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1.**Гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох:** Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

10.2. **Гэрээний хувь:** Энэхүү Гэрээг Монгол хэл дээр нийт 6 (зургаа) хувь үйлдэх бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.3. **Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**: Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа аль нэг тал нь нөгөө талтайгаа харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 3 өдрийн өмнө бичгээр ирүүлнэ. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

10.4. **Гэрээ цуцлагдах:** Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу Барьцаалагч нь Үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжаалах замаар шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, Хөрөнгийн багцыг Барьцаалуулагчаас худалдан авах буюу шилжүүлэн авсан тохиолдолд Талууд аль нэг талын санаачилгаар энэхүү Гэрээг цуцлах эрхгүй байна.

10.5. **Мэдэгдэл, шаардлага, захидал хүргүүлэх:** Энэхүү Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгэн хэлбэрээр байна. Эдгээрийг энэхүү Гэрээнд заасан дараах цахим хаягаар эсхүл гэрээнд заасан талуудын албан ёсны хаягаар хүргүүлснээр хүлээн авсанд тооцох бөгөөд баримтуудыг хадгална.

**"Барьцаалуулагч"-д**

- **Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот
- **Холбоо барих албан тушаалтан: Гүйцэтгэх захирал С. Отгонбат**
- **Утас:** (976) 9911 6366
- **И-мэйл:** info@bichilglobus.mn

**"Барьцаалагч"-д**

- **Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, Ногоон нуур гудамж, 101 барилга, 705 тоот
- **Холбоо барих албан тушаалтан: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц. Азбаяр**
- **Утас:** (976) 9999 8666
- **И-мэйл:** azbayar.khangolomt@gmail.com

10.6. Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд байгуулагдсан __________ тоот Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний салшгүй хэсэг болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

| БАРЬЦААЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ | БАРЬЦААЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ |
| --- | --- |
| "БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК | "БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>С.ОТГОНБАТ | ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА<br>Ц. АЗБАЯР |
| ______________________ | ______________________ |

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/307

2013 оны 10 сарын 23 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 сарын 23 өдрийн 379 дугаар тогтоолоор

**"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК** -д

**Банк бус санхүүгийн**

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

"тамга"

*Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй*

СЗХ
2022 . 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№01

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**МОНГОЛ УЛС**
**САНХҮҮГИЙН**
**ЗОХИЦУУЛАХ**
**ХОРОО**

**ТЗ 1001/307 ТООТ**
**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН**
**ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2013.10.23 | №379 тогтоол | |
| 2. | Факторингийн үйлчилгээ | 2018.09.12 | №309 тогтоол | |
| 3. | Итгэлцэл | 2019.12.04 | №340 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

TDB SECURITIES

“Үлэмжмэлмий ББСБ” ХХК-ийн оноосон нэрийг “Бичил глобус финанс ББСБ” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрөв. 2017.10.09 №440 тушаал

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Алтан тэвш, Амины орон сууцны хорооллын урд байрлах, 72 $м^2$ талбай бүхий оффисийн байр. | | |
| 2. | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол, Москва центр, 502 тоот. | 99119632 | 2013.11.29 №7/4575 албан тоот |
| 3. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур гудамж, 101 байр, 705 тоот. | | 2022.09.08 ЦМ-7/128 цахим мэдэгдэл |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2013.10.23 | №379 | 400,000,000 /анх олгосон/ |
| 2. | 202,800,419 /нэмэгдүүлсэн/ | 2015.11.06 | №305 | 602,800,419 |
| 3. | 279,589,566 /нэмэгдүүлсэн/ | 2017.02.21 | №133 | 882,389,985 |
| 4. | 361,312,715 /нэмэгдүүлсэн/ | 2017.07.17 | №352 | 1,243,702,700 |
| 5. | 3,657,297,300 /нэмэгдүүлсэн/ | 2018.06.04 | №390 | 5,000,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

СЗХ БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-11-15 БҮРТГЭВ-03

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 400,000,000 | 100% | 2013.10.23 | №379 тогтоол |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 602,800,419 | 100% | 2015.11.06 | №305 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 882,389,985 | 100% | 2017.02.21 | №133 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 1,243,702,700 | 100% | 2017.07.17 | №352 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 5,000,000,000 | 100% | 2018.06.04 | №390 тушаал |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Салбар-01 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2017.10.25 | №468 тушаал | |
| 2. | Салбар-02 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 3. | Салбар-03 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 4. | Салбар-04 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 5. | Салбар-05 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 6. | Салбар-06 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 7. | Салбар-07 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 8. | Салбар-08 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 9. | Салбар-09 | Дорнод аймаг, Хэрлэн сум. | 2018.08.23 | №485 тушаал | |
| 10. | Салбар-10 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2020.03.17 | №115 тушаал | |
| 11. | Салбар-11 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. | 2020.05.11 | №167 тушаал | |
| 12. | Салбар-12 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. | 2020.10.02 | №331 тушаал | |
| 13. | Салбар-13 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг | 2021.03.22 | №78 тушаал | |
| 14. | Салбар-14 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2021.05.20 | №123 тушаал | |
| 15. | Салбар-15 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2021.06.14 | №152 тушаал | |
| 16. | Салбар-16 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2022.08.03 | №380 тушаал | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ ХХК

СЗХ
2022 .11. 0
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОГТООЛ

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,
7-р хороолол, Ногоон нуурын
гудамж, Прован оффис
7 давхар 706 тоот

2022 оны 09 сарын 27 өдөр №22/04а/59 Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.11, 62.1.16 дахь заалт, 89, 91, 92-р зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13-р зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, 19-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06-р сарын 22-ны өдрийн №360-р тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын холбогдох зүйл, хэсэг, заалт болон Компанийн дүрмийн 7.5.10 дахь заалт болон холбогдох бусад заалтыг тус тус үндэслэн "Бичил глобус финанс ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн охин компани болох "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн тохиолдолд энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан хөрөнгийг "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-д худалдах замаар шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах зорилгоор "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-тай байгуулах "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын хавсралт 2-ын дагуу, "Фидуцийн болон өмчлөх эрх барьцаалах гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын хавсралт 3-ын дагуу тус тус батлсугай.

3. "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-д гэрээний үндсэн дээр хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон гэрээнд заасан, хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхийг Компанид зөвшөөрсүгэй.

4. Компани нь Үйлчилгээ үзүүлэгч болохын хувьд "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-тай байгуулах "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын хавсралт 4-ийн дагуу, "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах "Төлбөр цуглуулах дансны хөрөнгийн барьцааны гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын хавсралт 5-ын дагуу тус тус батлсугай.

5. "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлийг авч, түүнийг анхдагч зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах замаар шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн

Харилцах утас: +976 7000-2020
+976 9404 9300
И-мэйл: info@bichilglobus.mn
Вэб: www.bichilglobus.mn

Гарын үсэг

№ А4 040047

тохиолдолд энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан хөрөнгийг шилжүүлэх болохыг дурдсугай.

6. Компани нь энэхүү тогтоолын 2, 3, 4 дэх хэсгийг хэрэгжүүлэхтэй холбоотой сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвшөөрсүгэй.

7. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах, хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой шаардлагатай бүх талын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал С.Отгонбатад үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал С.Отгонбатад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

| | |
|---|---|
| "БИЧИЛ ГЛОБУС" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД | "БИЧИЛ ГЛОБУС" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД |
| Б.ХҮРЭЛХҮҮ | С.ОТГОНБАТ |

СЗХ
2022 . 11 . 02
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000236781

2021.09.16
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011831586
/ Хувийн хэргийн дугаар /

2870657
/ Регистрийн дугаар /

Юнайтед эйр файнэнс — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2005.01.27 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр шийдэх бөөний худалдаа |
|---|---|
| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 1 | 50,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / [illegible] тоо / | / [illegible] хэмжээ, мөнгөн төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот, Утас1: 80808886, Утас2: ,
Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Э.БАТОЧИР
/ гарын үсэг /

УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123

TDB SECURITIES

ТГЭВ
№ 01

2022-11-15
БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 316/18

2021 оны 10 сарын 28 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 28 өдрийн 473 дугаар тогтоолоор "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК -д ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
"Тамга"

Д.БАЯРСАЙХАН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЗХ он 2022 сар 11 09 өдөр БҮРТГЭВ №01

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-11-15 БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 316/18 тоот
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг" ТУ32072 9020030255 5043239

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Хөрөнгө итгэмжлэн удирдах | 2021.10.28 | №473 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

СЗХ
2022 11 09
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

**БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол,
Ногоон нуур, 101 барилга, 705 тоот
Утас: 99119632

2022.09.28 № 23/22

Танай_____________-ны №_____________

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын
талаар мэдэгдэл гаргах тухай

"Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК нь биржийн зах зээлд Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгоор Үүсгэн байгуулагч болох "Бичил глобус финанс ББСБ" ХХК-ийн шийдвэрээр үүсгэн байгуулагдсан болно.

Түүнчлэн, "Бичил глобус финанс ББСБ" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байгаа ба Компанийн тухай хууль, Үнэт цаас гаргагчийн дүрэм болон холбогдох бусад зохицуулалтад нийцүүлэн холбогдох тогтоол, шийдвэрийг гаргасан болно.

Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
2. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК;
4. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН.

Хүндэтгэсэн,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.АЗБАЯР

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК

СЗХ 2022.11.09 он сар өдөр БҮРТГЭВ №01

MONGOLIAN STOCK EXCHANGE ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД 2022-11-15 БҮРТГЭВ-03

**БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ ХХК**
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11-р хороо, 7-р хороолол /14180/,
Pro One оффис 7 давхар #706
харилцах утас: +976 7000-2020 | и-мэйл: info@bichilglobus.mn
вэб: www.bichilglobus.mn

2022.09.28 № 04/723

танай ______________-ны № ______________ -т

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

“Бичил глобус финанс ББСБ” ХХК нь биржийн зах зээлд Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгоор “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд тус компанийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэ бүхий 1,000 (нэг мянга) ширхэг энгийн эрхийн хувьцааг дангаар эзэмших 100 хувийн хувьцаа эзэмшигч билээ.

Түүнчлэн, үнэт цаас гаргах үйл ажиллагаанд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байгаа ба Компанийн тухай хууль, Үнэт цаас гаргагчийн дүрэм болон холбогдох бусад зохицуулалтад нийцүүлэн холбогдох тогтоол, шийдвэрийг гаргасан болно.

Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй “Юнайтед Айр Файнэнс” ХХК;
2. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч “Онч Аудит” ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК;
4. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй өмгөөллийн “Ди Би энд Жи Ти Эс” ХХН.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С. ОТГОНБАТ

№ А4 040286

СЗХ
он 2022 сар 11 өдөр 09
БҮРТГЭВ
№07

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 11 15
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД
БҮРТГЭВ-03

TDB SECURITIES

Худалдаа, хөгжлийн банк, 14210 Энхтайваны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Улаанбаатар, Монгол Улс
Утас: (976) 7010-0261, Факс: (976-11) 31-19-44
Э-шуудан: info@tdbsecurities.mn Вэб хуудас: www.tdbsecurities.mn

2022.09.29 № 03/232

танай ____________ -ны №____________ -т

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Тус компани нь "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд санал болгох төсөлд андеррайтер, зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргаж буй "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлж буй "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК;
3. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
4. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
5. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН.

Хүндэтгэсэн,

ДЭД ЗАХИРАЛ Г. ЭНХБАТ

0220424

СЗХ
20__ 11 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

DB&GTS

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

2022.09.28 № 01/341

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Тус нөхөрлөл нь "Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд санал болгох төсөлд хуулийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Нөхөрлөл нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргаж буй "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлж буй "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК;
4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
5. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д. ЗОЛЖАРГАЛ

Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН
Утас: +976 7133 1020, Факс: +976 7011 5060 И-мэйл: info@dblaw.mn www.dblaw.mn
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул Дүүрэг, 15-р хороо Чингисийн өргөн чөлөө - 33/2, Режис Плэйс Тауэрын 903 тоот

Онч & Company

Онч Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян-Гүний гудамж,
"Олон улсын худалдааны төв" цамхаг, 15-р давхар.
Утас: +976 7010-0450, 7012-0450
www.onch.mn

2022 оны 9 сарын 27

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Тус компани нь “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд санал болгох төсөлд харилцан тохиролцсон ажил үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргаж буй “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлж буй “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК;
4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй “Юнайтед Айр Файнэнс” ХХК;
5. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй өмгөөллийн “Ди Би энд Жи Ти Эс” ХХН;

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал ШЩ. НОРЖИНБАТ

СЭХ
2022 .11. 09
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ЮНАЙТЭД АЙР ФАЙНЭНС

Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо
Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот
Утас/факс: 976-70122346, Утас: 976-70142346
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот15160, Ш/Х 186

2022/09/29 № 09-03

танай_____________ -ны № ______________-т

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -11- 15
БҮРТГЭВ-03

ӨМГӨӨЛЛИЙН "ДИ БИ ЭНД ЖИ ТИ ЭС" ХХН-д

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Тус компани нь Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК-д "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байна. Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргаж буй "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлж буй "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК;
4. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
5. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй өмгөөллийн "Ди Би энд Жи Ти Эс" ХХН.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ [signature, seal: ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС ХХК / UNITED AIR FINANCE LLC] Х.МАРГАД-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР ХОТ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES